

**ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК
БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН БОДЛОГО**

Захирлуудын зөвлөлийн 2014 оны 5 дугаар сарын 7-ны хурлаар батлав.

АГУУЛГА

ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлого	3
А. Энэхүү бодлогын зорилго	3
С. Төслийг боловсруулж, хэрэгжүүлэх үе шатанд байгаль орчин, нийгмийн асуудлыг уялдуулж тусгах нь	6
D. ЕСБХБ-ны олон нийтэд тайлагнах, хариуцлага хүлээх үүрэг	11
E. Бусадтай түншлэх болон хөрөнгө оруулалтын арга хэмжээнд байгаль орчин, нийгмийн ач холбогдлыг сайжруулах асуудлыг хөхиүлэн дэмжих нь	12
F. Байгууллага болон хэрэгжилтийн зохицуулалт	12
Хавсралт 1. ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн хориглосон үйл ажиллагааны жагсаалт	14
Хавсралт 2. «А» ангиллын төслүүд	16
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 1:.....	19
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 2.....	27
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 3.....	34
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 4.....	40
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 6.....	57
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 7.....	67
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 8.....	78
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 9.....	82
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 10.....	86

ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлого

А. Энэхүү бодлогын зорилго

1. Европын сэргээн босголт, хөгжлийн банк (цаашид ЕСБХБ, эсвэл Банк гэх) нь ЕСБХБ-ийг үүсгэн байгуулах тухай гэрээний¹ дагуу, явуулж буй хөрөнгө оруулалтын болон техникийн хамтын ажиллагааны бүхий л үйл ажиллагаандаа "байгаль орчинд халгүй, тогтвортой хөгжил"-ийн зарчмыг хөхиүлэн дэмждэг. ЕСБХБ нь байгаль орчин, нийгмийн² тогтвортой хөгжил бол тус Банкны шилжилтийн эдийн засгийг дэмжих бодлогод нийцэхүйц үр дүнд хүрэх нэгэн чухал суурь үзүүлэлт хэмээн үзэж байгаа ба байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг дэмжсэн төслүүд Банкны үйл ажиллагаанд эн тэргүүний ач холбогдолтойд тооцогдох болно.
2. Энэхүү бодлогын баримт бичигт «төсөл» гэж ЕСБХБ-аас санхүүжилт авахыг хүссэн, эсвэл ЕСБХБ-аас санхүүжилт авахаар дэмжигдсэн, санхүүжилтийн гэрээнд тусгагдсан, Захирлуудын зөвлөл, эсвэл шийдвэр гаргагч бусад байгууллагаар зөвшөөрөгдсөн бизнесийн цогц үйл ажиллагааг хэлнэ.
3. Тус бодлогын баримт бичиг нь Банкны зүгээс төслүүдийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг:
 - төслүүдийг энэхүү бодлого, Гүйцэтгэлийн шаардлага (ГШ)-ын дагуу боловсруулах, хэрэгжүүлэхэд ЕСБХБ болон зээлдэгчдийн хүлээх холбогдох үүрэг, хариуцлагыг тодорхойлох,
 - байгаль орчны болон нийгмийн өндөр үр ашигтай төслүүдийг дэмжих стратегийн зорилтыг тодорхойлох,
 - байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг хангах үзүүлэлтүүдийг өөрийн бүхий л үйл ажиллагаандаа гол шаардлага болгох замаар хэрхэн зохицуулах талаар тайлбарласан болно.

В. ЕСБХБ-ны үүрэг, амлалт

4. ЕСБХБ-ны санхүүжүүлж буй бүхий л төслүүд нь энэхүү бодлогод тусгагдсан шаардлагуудыг хангасан байх хэрэгтэй.
5. ЕСБХБ нь тодорхой асуудлуудаар Гүйцэтгэлийн шаардлагуудыг боловсруулан баталсан бөгөөд Банкны бүх төслүүд эдгээр шаардлагыг хангавал зохино. Тодорхой хугацааны хүрээнд зээлдэгчид төслүүдтэй холбоотой байгаль орчин, нийгмийн асуудлуудыг эдгээр ГШ-ын дагуу зохицуулах шаардлагатай.
6. ЕСБХБ нь өөрийн эрх мэдэл болон Банкны байгаль орчин, нийгмийн үнэлгээ, мониторингийн бодлогын хүрээнд тухайн санхүүжилт хүсэж буй төслүүдийг

¹ ЕСБХБ-ийг үүсгэн байгуулах тухай гэрээний 2 дугаар зүйлийн 2.1 (vii).

² Энэхүү бодлогын баримт бичгийн хувьд «нийгмийн» гэсэн нэр томъёонд төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн хүмүүс, тэдний оршин суугаа орон нутаг, ажилчдад хамааралтай асуудлууд, эдгээр хүмүүсийн нийгэм-эдийн засгийн статус, эмзэг байдал, жендэр, хүний эрх, бэлгийн чиг хандлага, соёлын өв, хөдөлмөрийн болон ажлын нөхцөл, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцож буй байдал зэрэгт хамаарах асуудлуудыг ойлгоно.

холбогдох хууль, журам болоод олон улсын сайн туршлага (ОУСТ)³-д нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх нөхцлийг хангахын төлөө ажиллана. Үүнд, нөлөөллийг шат дараатайгаар бууруулах арга хэмжээ⁴ авах нь хамгийн чухал юм.

7. ЕСБХБ нь Европын Байгаль орчны зарчмууд⁵-ыг баримтлагч тал болохын хувьд өөрийн санхүүжүүлж буй төслүүдийг газар зүйн байршлаас үл хамааран Европын холбооны байгаль орчны зарчмууд, туршлага, нарийвчилсан стандартууд⁶-ыг төслийн түвшинд баримтлан хэрэгжүүлэхийг дэмжиж шаардах үүрэгтэй. Хэрэв төсөл хэрэгжих орны хууль, тогтоомж нь Европын холбооны нарийвчилсан стандартаас зөрж байвал эдгээр стандартуудаас аль өндөр шаардлага тавигдсан байгааг нь мөрдвөл зохино.
8. ЕСБХБ нь үйл ажиллагаа явуулж буй тухайн улс орны олон улсын байгаль орчин болоод нийгмийн харилцааны гэрээ хэлэлцээр, конвенцид нэгдэн орсон байдлыг хүлээн зөвшөөрнө. ЕСБХБ өөрийн эрх мэдлийн хүрээнд санхүүжүүлж буй төсөл нь олон улсын эрх зүйн холбогдох зарчмууд, нарийвчилсан шаардлагыг хангасан байхын төлөө ажиллана. Төслийн судалгааны үеэр тодорхойлсон, тухайн орны олон улсын аливаа гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүрэгт нь харшлах төслийг ЕСБХБ зориудаар санхүүжүүлэхгүй.
9. ЕСБХБ нь өөрийн зээлдэгчдийг бизнес үйл ажиллагаандаа хүний эрх⁷-ийг хүндэтгэх, хүний эрх нь байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын салшгүй хэсэг болохыг хүлээн зөвшөөрөх үүрэгтэйг анхааран үздэг. Энэхүү хариуцлагад хүний эрхийг хүндэтгэх, бусдын эрхийг зөрчихгүй байх, бизнес үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлийн асуудлыг шийдвэрлэх зэрэг үүрэг багтана.
10. Жендэрийн тэгш байдлыг хангах нь орчин үеийн зах зээлийн эдийн засаг, ардчилсан нийгмийн үндсэн нэг шаардлага хэмээн ЕСБХБ-аас үздэг. ЕСБХБ-ны зээлдэгчид нь жендэрийн холбогдолтой аливаа гажуудал, сөрөг нөлөөллийг илрүүлэн, тэдгээрийн үр дагаврыг багасгах, бууруулах арга хэмжээ авах ёстой. Шаардлагатай үед, тэгш боломж олгох, эмэгтэйчүүдийн нийгэм-эдийн засгийн эрх мэдлийг ялангуяа санхүүжилт, үйлчилгээ, ажил эрхлэлтийн хувьд нэмэгдүүлэх

³ Олон улсын сайн туршлага гэж дэлхийд болон бүс нутагт ижил төслийг ижил төстэй нөхцөлд хэрэгжүүлэх явцад мэргэшсэн, туршлагатай мэргэжилтнүүдийн зүгээс мэргэжлийн өндөр үр чадвар, хянамгай байдал, анхаарал, ирээдүйг харсан байдлаар ажиллаж ирсэн туршлагыг хэлнэ. Ийм туршлагын үр дүнд төслийн онцлог нөхцөл байдалд хамгийн тохиромжтой технологийг тухайн төсөлд ашигласан тохиолдол орж болно.

⁴ Нөлөөллийг бууруулах үе шатуудад төслийн үйл ажиллагаа эхлэх үеэс байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй тохиолдолд нөлөөллийг багасгах, бууруулах, эцэст нь дүйцүүлэн хамгаалах, нөхөн олговор олгох зэрэг арга хэмжээнүүд багтана.

⁵ Европын Байгаль орчны зарчмууд (ЕРЕ)-ыг Европын хөгжлийн банк, ЕСБХБ, Европын хөрөнгө оруулалтын банк, Нордикийн байгаль орчны санхүүжилтийн корпораци, Нордикийн хөрөнгө оруулалтын банкны зөвлөлөөс батлан гаргасан байна. ЕРЕ нь төслийн санхүүжилттэй холбоотой байгаль орчны зарчим, туршлага ба стандартыг хооронд нь улам уялдуулан нийцүүлэх санаачилга юм. ЕРЕ-ийн үүргийг ГШ-ын 1, 3, 4 ба 10-т тусгасан болно.

⁶ Европын холбоо (ЕХ)-ны байгаль орчны нарийвчилсан стандарт нь ЕХ-ны хоёрдогч хууль тогтоомж, тухайлбал журам, тогтоол, шийдвэрт багтсан байдаг. ЕХ-ны гишүүн улсууд, байгууллагуудад үйлчлэх процедурын хэм хэмжээ болон гишүүн улсууд, ЕХ-ны байгууллагууд, ЕХ-ны хуулийн этгээд, иргэдэд үйлчлэх Европын шүүх, анхан шатны шүүхийн шийдвэрүүд энэ тодорхойлолтод хамаарахгүй.

⁷ Энэхүү бодлогын баримт бичгийн хувьд ЕСБХБ нь Олон улсын хүний эрхийн билл, НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын тулгуур 8 конвенцийг баримтална.

замаар төслийн жендэрийн эерэг талуудыг бэхжүүлэхийг зээлдэгчээс шаардах эрхтэй.

11. ЕСБХБ нь тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдсэн аливаа тарифын өөрчлөлт нь хүн амын эмзэг бүлгийн хүмүүс⁸-т хүрэх суурь үйлчилгээний хүрэлцээнд асуудал үүсгэх эсэхийг нягтлан үзэх бөгөөд тийм нөхцөл байдлыг шийдвэрлэх үр дүнтэй механизм бий болгон хэрэгжүүлэх арга хэмжээ авна.
12. ЕСБХБ нь энэхүү бодлогыг хэрэгжүүлэх замаар төслийн үйл ажиллагааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, урт хугацааны тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, нийгмийн менежментийг сайжруулах талаар зээлдэгчтэй түншлэл тогтоон ажиллана.
13. Банк нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй улс орны уур амьсгалын өөрчлөлтийн учир шалтгаан, үр дагаврыг тодорхойлох, шийдвэрлэх нь ач холбогдолтой асуудал болохыг хүлээн зөвшөөрч байгаа юм. Мөн шаардлагатай тохиолдолд хүлэмжийн хий бага, эсвэл огт ялгаруулдаггүй хөрөнгө оруулалт, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох арга хэмжээг дэмжихэд чиглэсэн шинэлэг хөрөнгө оруулалт хийх, техникийн туслалцаа үзүүлэхэд оролцож, ЕСБХБ-ны дэмжлэгтэй төслүүдийн хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгах боломжийг хайж ажиллана. ЕСБХБ нь уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөрөнгө оруулалтыг дэмжсэн дасан зохицох арга хэмжээг тодорхойлоход нь зээлдэгчдийг дэмжиж ажиллана.
14. ЕСБХБ нь байгалийн амьд нөөцийг хамгаалах, хадгалах, удирдах, тогтвортой ашиглах асуудалд болгоомжтой ханддаг бөгөөд холбогдох төслүүдийг экосистем, биологийн олон янз байдлыг хамгаалах, боломжтой нөхцөлд сэргээх талаар арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлэхийг шаардах эрхтэй.
15. ЕСБХБ нь ил тод байдал, хариуцлага хүлээх, талуудын оролцоог хангах зарчмыг баримтална. Банкны Олон нийтэд мэдээлэх бодлого (ОНМБ)-ын дагуу байгаль орчин, нийгмийн асуудлаарх үйл ажиллагааны тухай тойм мэдээллийг олон нийтэд байнга ил тод мэдээлж, холбогдох талуудтай зөвлөлдөж ажиллана. Түүнчлэн, дээрх сайн туршлагыг зээлдэгчдийн дунд нэвтрүүлэх асуудлыг дэмжиж ажиллана.
16. ЕСБХБ нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй улс орондоо байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг бүс нутгийн болоод салбарын түвшинд үр дүнтэй хангах чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллагууд, Европын холбоо, хоёр талын хандивлагчид, НҮБ-ын агентлагууд, олон улсын бусад байгууллагатай уялдаа холбоотой ажиллана. Олон улсын санхүүгийн бусад байгууллагатай хамтран төсөл санхүүжүүлэхдээ төслийн үнэлгээ, шаардлага, мониторингийн талаар нэгдсэн бодлого баримтлах тохиролцоонд хүрэх талаар хамтран ажиллахыг эрмэлзэнэ.
17. ЕСБХБ нь өөрийн улс орнуудтай хамтран ажиллах стратеги, мөн салбарын стратеги, бодлогодоо ЕСБХБ-ны төлөвлөж буй үйл ажиллагаанаас үүсч болзошгүй байгаль орчин, нийгмийн асуудал, боломжуудын талаар мэдээлэл оруулна.
18. ЕСБХБ нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй улс орнуудын байгаль орчин, нийгмийн асуудлуудыг авч үзэх, зохицуулах чадавхийг өөрийн техникийн хамтын

⁸ Энэхүү бодлогын баримт бичгийн хувьд «эмзэг бүлэг» гэж жендэр, бэлгийн чиг хандлага, шашин шүтлэг, яс үндэс, уугуул иргэншил, нас, хөгжлийн болон санхүүгийн бэрхшээл, нийгмийн статус зэргээс хамааран бусадтай харьцуулахад төслийн нөлөөлөлд илүүтэйгээр өртсөн, төслийн үр ашгаас хүртэх боломж, чадвар багатай хүмүүсийг хэлнэ. Эмзэг бүлгийн хүмүүст ядуурлын түвшнээс доогуур амьжиргаатай, өөрийн гэсэн газаргүй хүмүүс, ахмад настан, өрх толгойлсон эмэгтэйчүүд, хүүхдүүд, албадан нүүлгэсэн хүмүүс, үндэстний цөөнх, амьжиргаа нь байгалийн баялгаас хамааралтай бүлэг хүмүүс зэрэг тухайн улс орны болон олон улсын хууль тогтоомжоор хамгаалагдаагүй байж болох бусад хүмүүс бас багтаж болно.

ажиллагаа, бодлогын яриа хэлэлцээний хүрээнд сайжруулах, бий болгох боломжийг хайж ажиллана. Түүнчлэн, төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчин, нийгмийн тогтвортой үр дүнд хүрэх тааламжтай нөхцөл байдлыг зээлдэгчдэд бий болгож өгөхийн төлөө ажиллана.

19. ЕСБХБ нь дотоод үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын асуудлаар олон улсын сайн туршлагыг ашиглах бөгөөд энэ төрлийн ижил төстэй өндөр стандарт мөрддөг ханган нийлүүлэгч, гэрээт компанитай ажиллахыг эрмэлзэнэ.

С. Төслийг боловсруулж, хэрэгжүүлэх үе шатанд байгаль орчин, нийгмийн асуудлыг уялдуулж тусгах нь

ЕСБХБ-ны үүрэг, хариуцлага

20. ЕСБХБ нь Банкны удирдлага, Захирлуудын зөвлөл, эрх бүхий бусад удирдлагын гаргасан шийдвэрийн дагуу Банкны нөөц хөрөнгөнөөс олон улсын санхүүгийн байгууллагын хувиар төслүүдэд санхүүжилт олгох үүрэг, хариуцлагыг хүлээдэг. Аливаа тодорхой хөрөнгө оруулалт, эсвэл техникийн хамтын ажиллагааны төсөл дэх ЕСБХБ-ны оролцооны түвшин нь төслийн мөн чанар, хэмжээ, хандивлагчийн санхүүжилт байгаа эсэх, мөн зээлдэгчтэй тогтоосон хамтын ажиллагаа, харилцааны онцгой нөхцөл байдлаар тодорхойлогддог.
21. ЕСБХБ нь байгаль орчны болон нийгмийн үндэслэлээр аливаа төслийг санхүүжүүлэхээс татгалзаж болно. ЕСБХБ нь албадан хөөх⁹ үйл ажиллагаа явуулж болзошгүй төслүүдийг зориудаар санхүүжүүлдэггүй ба энэхүү бодлогын баримт бичгийн Хавсралт 1-д заасан ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн хориглосон үйл ажиллагааны жагсаалтад багтсан хэд хэдэн төрлийн үйл ажиллагааг санхүүжүүлдэггүй болно.
22. ЕСБХБ нь хэд хэдэн тусгай сан болон хамтын ажиллагааны санг ажиллуулдаг. Тусгай сангаас бүхэлдээ, эсвэл хэсэгчлэн санхүүжсэн төсөл, үйл ажиллагаа нь энэхүү бодлогын баримт бичгийг мөрдөх шаардлагатай. Хамтын ажиллагааны сангийн тухайд уг бодлогын баримт бичиг мөн хамаарах бөгөөд харин байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотойгоор хандивлагчийн нэмэлт шаардлага тавигдаж болно. Эдгээр хандивлагчийн шаардлага нь энэхүү бодлогын баримт бичигтэй нийцсэн байх ёстой.

Төслийн үе шат

Ангилал

23. ЕСБХБ нь байгаль орчин, нийгмийн асуудлын мөн чанар, түвшин, мэдээллийн ил тод байдал, талуудын оролцооны байдлыг тодорхойлох зорилгоор төслүүдийг ангилдаг. Энэ нь төслийн мөн чанар, байршил, эмзэг байдал, цар хүрээтэй, мөн байгаль орчин, нийгмийн хэтийн болзошгүй сөрөг нөлөөллийн хэмжээтэй уялдана. Төслийн одоогийн барилга байгууламжтай холбоотой байгаль орчин, нийгмийн

⁹ Албадан, эсвэл сайн дурын бус байдлаар иргэд, бүлэг хүмүүсийг тэдний хамааралтай гэр орон, ба/эсвэл газар, нийтийн эзэмшлийн байр, газраас нүүлгэн шилжүүлэх, тэгснээр тэдний тодорхой орон байртай байх, оршин суух, байрлах боломжийг зохих ёсны эрх зүйн болон тодорхой хэлбэрийн бусад хамгаалалтанд орох эрх олголгүй хаах, эсвэл хязгаарлах явдал. Хуулийн дагуу болон олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийн заалтад нийцүүлэн нүүлгэн шилжүүлэх тохиолдол үүнд хамаарахгүй.

өмнө болон одоо үүсээд буй асуудлууд, эрсдэлийг дээрх ангиллаас үл хамааран үнэлнэ.

Шууд хөрөнгө оруулалт¹⁰

24. Тухайн төсөл нь ирээдүйд байгаль орчин, нийгмийн ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй ч ангилал тогтоох үед шууд үнэлгээ өгөхөд амаргүй байсан тул хамтын оролцоот байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэн төслийг «А» ангиллын төсөлд оруулан ангилдаг. «А» ангиллын төслүүдийн төлөөллийг багтаасан жагсаалтыг энэ бодлогын баримт бичгийн Хавсралт 2-т оруулав.
25. Тухайн төслийн байгаль орчин, нийгмийн хэтийн сөрөг нөлөө нь ерөнхийдөө төсөл байрлаж буй газарт илүүтэйгээр хамаарах бөгөөд нөлөөллийг тодорхойлоход амар, мөн бууруулах арга хэмжээг авч болохуйц байвал «В» ангиллын төсөлд багтаадаг. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх эсэх нь тухайн төслөөс хамаарах бөгөөд ЕСБХБ-аас тухай бүр шийдвэрлэдэг.
26. Төслийн байгаль орчин, нийгмийн хэтийн сөрөг нөлөөлөл нь маш бага, эсвэл огт байхгүй тохиолдолд төслийг «С» ангилалд батгаана. Байгаль орчин, нийгмийн ерөнхий үнэлгээ хийх байдлаар нөлөөллийг тодорхойлох боломжтой.
27. Ангилал тогтоох үед ангилал тогтоох, үнэлгээний цар хүрээг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл хомс байвал байгаль орчин, нийгмийн анхан шатны судалгаа (IESE) хийнэ.

Санхүүгийн зуучлалын ажиллагаа

28. Санхүүгийн зуучлагчид (FI)-аар дамжуулан төслийн хөрөнгийг босгож байгаа тохиолдолд төслийг FI ангилалд оруулна. Энэ тохиолдолд санхүүгийн зуучлагчид (FI)¹¹ нь дэд төслийн үнэлгээ, мониторингийн асуудлыг хариуцна.

Төслийн үнэлгээний нийтлэг аргачлал

29. ЕСБХБ-аас санхүүжүүлж болох эсэхийг шийдвэрлэхэд тус дөхөм болох үүднээс, мөн санхүүжилт хийгдэх тохиолдолд төлөвлөлт, хэрэгжилт, үйл ажиллагааны явцад байгаль орчин, нийгмийн асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор бүх төсөлд байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийдэг. Үнэлгээ нь төслийн мөн чанар, цар хүрээнд нийцэх ёстой бөгөөд байгаль орчин, нийгмийн үр нөлөө, асуудлуудтай уялдан хийгдэж, нөлөөллийг шат дараатайгаар бууруулах арга хэмжээг тооцон үзсэн байх шаардлагатай. Үнэлгээгээр тухайн төсөл энэхүү бодлогын баримт бичиг, Гүйцэтгэлийн шаардлагууд (ГШ)-ын дагуу хэрэгжих боломжтой эсэхийг тодорхойлж, санхүү, хууль эрх зүй, нэр хүндэд учирч болзошгүй бодит эрсдэлд үнэлгээ өгч, мөн төслийн хүрээнд бий болох байгаль орчин, нийгмийн боломжуудыг тодорхойлдог. Энэхүү байгаль орчин, нийгмийн үнэлгээг ЕСБХБ-ны зүгээс хийх төслийн нэгдсэн үнэлгээнд нэгтгэдэг. ЕСБХБ нь

¹⁰ ЕСБХБ-ны төслүүдийг «Шууд хөрөнгө оруулалтын төсөл», «Санхүүгийн зуучлалын төсөл» гэж хуваадаг. Санхүүгийн зуучлалын төслийн хувьд зээлдэгч нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө оруулалтын сан, эсвэл ижил төстэй байгууллага байдаг. Бусад төслүүд нь Шууд хөрөнгө оруулалтын төсөлд багтдаг.

¹¹ FI-д тухайлбал, хувийн хөрөнгө оруулалтын сан, банк, түрээсийн компани, даатгалын компани, тэтгэврийн сан зэрэг ордог.

нарийн мэргэжлийн, эсвэл техникийн асуудлаар гуравдагч этгээдийн зөвлөгөө авах эрхтэй байж болно.

30. ЕСБХБ-ны байгаль орчин, нийгмийн үнэлгээнд (i) төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлууд, (ii) төслийг ГШ-тай нийцүүлэн гүйцэтгэх зээлдэгчийн чадавхи, үүрэг хариуцлага, (iii) боломжтой түвшинд төсөлтэй хамааралтай боловч ЕСБХБ-аас санхүүжүүлээгүй барилга байгууламж, үйл ажиллагаа гэсэн 3 үндсэн асуудлыг тусгана. ЕСБХБ-ны байгаль орчин, нийгмийн үнэлгээний цар хүрээг тухай бүр тодорхойлох бөгөөд барьцаа болгосон хөрөнгөтэй холбоотой эрсдэл, өр төлбөрийн асуудлыг үнэлгээнд тусгаж болно.
31. Банкны зүгээс энэхүү бодлогын баримт бичгийн дагуу байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийхэд шаардагдах хангалттай мэдээллийг өгөх үүргийг зээлдэгч хүлээнэ. Банк нь (i) зээлдэгчийн өгсөн мэдээллийг хянан үзэх, (ii) холбогдох ГШ-ыг хангах үүднээс байгаль орчин, нийгмийн нөлөөллийг шат дараатайгаар бууруулах арга хэмжээг боловсруулахад нь зээлдэгчид чиглэл өгөх, (iii) байгаль орчин, эсвэл нийгмийн нэмэлт үр ашиг өгөх боломжуудыг илрүүлэхэд туслах үүргийг хүлээнэ.
32. Банкнаас үнэлгээ хийх үед төслүүд янз бүрийн түвшний мэдээлэлтэй байж болно. Зарим тохиолдолд, банкны зүгээс хөрөнгө оруулах шийдвэр гаргах үед ЕСБХБ-ны хөрөнгө оруулалт, холбогдох байгаль орчин, нийгмийн нөлөөллийн талаар төслийг уламжлалт аргаар санхүүжүүлэхтэй адил мэдлэг, ойлголттой болсон байдаг. Гэхдээ зарим тохиолдолд, Банкны хөрөнгө оруулалт нь урсгал хөрөнгийн санхүүжилт, үндсэн хөрөнгө зэрэг тодорхой биет хөрөнгөд чиглэгдээгүй, эсвэл ирээдүйн хөрөнгөд чиглэгдсэн байж болно. Тийм тохиолдолд, банкны зүгээс хөрөнгө оруулах шийдвэр гаргах үед ЕСБХБ-ны хөрөнгө оруулалт, холбогдох байгаль орчин, нийгмийн нөлөөллийн тухай мэдээлэл тодорхой бус байдаг. Тиймээс, Банкны зүгээс (i) тухайн салбар, бизнес үйл ажиллагааны онцлогт хамаарах эрсдэл, нөлөөллийн үндсэн дээр хөрөнгө оруулалтын үнэлгээ, (ii) ГШ-ын дагуу төслийг хэрэгжүүлэх зээлдэгчийн чадавхид үнэлгээг тус тус хийдэг.
33. Баригдаж эхэлсэн төслийг санхүүжүүлэх, эсвэл тухайн орноос зөвшөөрөл авсан, түүний дотор байгаль орчин, нийгмийн үнэлгээ нь батлагдсан төсөл санхүүжүүлэх хүсэлт хүлээн авбал ЕСБХБ-ны шаардлагыг хангахад нэмэлт судалгаа хийх, бууруулах арга хэмжээнүүд нэмэж тусгах эсэх талаар тодруулах зорилгоор тухайн төслийг хэрхэн боловсруулж, хэрэгжүүлж буй байдлыг ГШ-тай харьцуулсан дүн шинжилгээг ЕСБХБ-аас гүйцэтгэнэ.
34. ЕСБХБ үнэлгээ хийхдээ тухайн төслийн нөлөөлөлд өртөгч, эсвэл төслийг сонирхогч талуудыг тодорхойлох, төслөөс үүдэлтэй нөлөөлөл, асуудлуудын талаар хангалттай мэдээлэл өгөх, талуудтай үр дүнтэйгээр, тэдний соёл, зан заншилд тохируулан зөвлөлдөхийг зээлдэгчээс шаардах эрхтэй. Ялангуяа, ЕСБХБ нь төсөлтэй холбоотойгоор үүсэж болзошгүй нөлөөлөл, санаа зовоосон асуудлуудын талаар холбогдох талуудтай зөвлөлдөн, тэдний оролцоог хангахыг зээлдэгчээс шаарддаг. Талуудын оролцоог хангахдаа НҮБ-ын Европын эдийн засгийн комисс (ЕЭЗК)-ын Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах, шударга ёсыг хангах тухай конвенцийн үзэл санаа, зарчмуудыг анхаарах шаардлагатай. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) хийлгэх шаардлагатай бөгөөд олон улсын хил дамнасан байгаль орчны нөлөөлөл ихтэй төслүүдийн хувьд газар зүйн байршил, нөлөөллийн түвшнээс үл хамааран, НҮБ-ын ЕЭЗК-ын Хил дамнасан үйлчлэл бүхий байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай конвенцийг баримтлахыг Банкны зүгээс

дэмжинэ. Банк зарим тохиолдолд оролцогч талуудын санал бодлыг сонсох зорилгоор олон нийттэй зөвлөлдөх арга хэмжээнүүдийг өөрийн зүгээс зохион байгуулж болно. Шаардлагатай тохиолдолд оролцогч талуудыг тодорхойлох, оролцуулах асуудлыг Банкны техникийн хамтын ажиллагааны үйл ажиллагаанд тусгаж болно.

35. FI ангиллын төслийн хувьд ЕСБХБ нь холбогдох санхүүгийн зуучлагч, түүний хариуцсан хөрөнгийн талаар зохих судалгаа хийж, (i) тухайн FI-ийн баримталдаг байгаль орчин, нийгмийн бодлого, журам, тэдгээрийг хэрэгжүүлэх чадавхи, (ii) FI-ийн одоогийн болон ирээдүйд хариуцах хөрөнгөтэй холбоотой байгаль орчин, нийгмийн асуудлууд, (iii) тухайн FI-ийн одоогийн байгаль орчин, нийгмийн хамгааллын системийг сайжруулах арга хэмжээнүүд зэрэгт үнэлгээ өгнө.

Гүйцэтгэлийн шаардлагууд (ГШ)

36. Банкнаас санхүүжүүлэх төслүүд нь байгаль орчин, нийгмийн тогтвортой хөгжилд хамааралтай олон улсын сайн туршлагад нийцсэн байх шаардлагатай. Зээлдэгчид болон/эсхүл төслүүд энэхүү нөхцлийг хангахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ЕСБХБ-аас байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын гол чиглэлээр доор жагсаасан ГШ-ыг боловсруулсан болно. Үүнд:

- ГШ 1 – Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлын үнэлгээ ба менежмент
- ГШ 2 – Хөдөлмөр эрхлэлт ба ажиллах нөхцөл
- ГШ 3 – Нөөцийн үр ашигтай хэрэглээ, бохирдлоос сэргийлэх ба хянах
- ГШ 4 – Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа
- ГШ 5 – Газар чөлөөлөх, албадан нүүлгэн суурьшуулах ба эдийн засгийн хохирол амсах
- ГШ 6 – Биологийн олон янз байдлыг хадгалах, байгалийн амьд нөөцийг тогтвортой ашиглах
- ГШ 7 – Нутгийн уугуул иргэд
- ГШ 8 – Соёлын өв
- ГШ 9 – Санхүүгийн зуучлагчид
- ГШ 10 – Мэдээллийг ил тод болгох, талуудын оролцоо

Шууд хөрөнгө оруулалт нь ГШ 1-8 ба 10-ыг хангасан байх ёстой. Санхүүгийн зуучлалын ажиллагаа ГШ 2 ба 9 болон хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны тухай ГШ 4-ыг хангах хэрэгтэй. ГШ тус бүрийн зорилго дотор хүсч буй үр дүнг тодорхойлж, дараа нь тэрхүү үр дүнд хүрэхэд нь төслийн зүгээс үйлчлүүлэгчдэд дэмжлэг үзүүлэх тодорхой шаардлагуудыг зааж өгнө. Тухайн улс орны холбогдох хууль, журмыг дагаж мөрдөх явдал нь нийт ГШ-ын салшгүй хэсэг байна.

37. Шинэ объект, эсвэл шинэ бизнесийн үйл ажиллагаанд холбогдолтой төслүүд ГШ-ыг эхнээсээ хангасан байхаар төлөвлөгдсөн байх хэрэгтэй. Хэрэв одоо байгаа объект, үйл ажиллагаатай холбоотой төслүүд нь Зөвлөлийн хурлаар батлагдах үедээ ГШ-ыг хангахгүй байгаа бол ЕСБХБ-ны хүлээн авахуйц хугацааны дотор ЕСБХБ-ны шаардлагад нийцсэн техникийн болон санхүүгийн хувьд биелэгдэх боломжтой, зардал багатай арга хэмжээнүүд авч, ГШ-д нийцүүлэхийг Банк зээлдэгчээс шаардана. Түүний дээр, ЕСБХБ тухайн төслийн нэг хэсэг биш боловч түүнд хамааралтай үйл ажиллагаандаа ГШ-тай нийцсэн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагыг хангах талаар зээлдэгчтэй хамтран ажиллана.

38. Хэрэв тухайн төсөл олон газар үйл ажиллагаа явуулдаг компаний санхүүжилт, урсгал хөрөнгө, үндсэн хөрөнгөтэй нийтлэг байдлаар холбогдож байвал компаний түвшинд (тухайн төслийн түвшинд биш) ГШ-ыг тодорхой хугацааны дотор хангах арга хэмжээ авахыг зээлдэгчээс шаардана. Санхүүжилтийг тодорхой биет хөрөнгөнд зарцуулахаар байвал тухайн үйл ажиллагаа ГШ-ыг хангасан байх ёстой. Санхүүжилтийг тодорхой биет хөрөнгөнд ашиглахгүй тохиолдолд дээрх §32-д заасан шаардлагууд үйлчилнэ.

Гуравдагч талын гүйцэтгэл

39. Зарим үед төслийн нийгмийн болон байгаль орчны зорилгыг ГШ-д нийцүүлэн биелүүлэх зээлдэгчийн чадвар гуравдагч тал¹²-ын үйл ажиллагаанаас шалтгаалдаг. ЕСБХБ-ны санхүүжүүлж буй төслүүд гуравдагч талын үйл ажиллагаанаас шалтгаалах тохиолдолд ч мөн тухайн төсөл ГШ-д нийцсэн үр дүнтэй хэрэгжих нөхцлийг Банкны зүгээс эрэлхийлж ажиллана. Гуравдагч талын эрсдэл өндөр, эсвэл зээлдэгч нь гуравдагч этгээдийн ажиллагаа, үйлдлийг хянадаг, нөлөө үзүүлдэг байвал ЕСБХБ ГШ-ын зорилгод нийцсэн үр дүнд хүрэх зорилгоор гуравдагч талтай хамтран ажиллахыг зээлдэгчээс шаардах эрхтэй. Тусгай шаардлага тавих, арга хэмжээ авах тохиолдолд тухайн нөхцөл байдлаас хамааруулан шийднэ. Гуравдагч талын тодорхой эрсдэлээс хамааран, Банк төслийг санхүүжүүлэхээс зайлсхийж болно.

Шийдвэр гаргах

40. Төслийг батлуулахаар ЕСБХБ-ны Захирлуудын зөвлөл, эсвэл шийдвэр гаргагч бусад байгууллагад танилцуулах баримт бичигт байгаль орчин, нийгмийн үнэлгээний танилцуулга, төслөөс үүсэх томоохон нөлөөлөл, асуудлууд, тэдгээрийг бууруулах арга хэмжээ, талуудын оролцооны талаарх танилцуулга, эдгээр нөлөөлөл, асуудлыг зээлдэгчийн зүгээс шийдвэрлэх арга зам зэргийг оруулсан байх ёстой. Захирлуудын зөвлөл, эсвэл шийдвэр гаргагч бусад байгууллага төслийн нийт ашиг тус, эрсдэлийг тооцсон шийдвэр гаргахдаа оролцогчдын санал, санаа зовоосон асуудлуудыг харгалзан үзнэ.
41. Зөвлөлөөр төслийг баталж, санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурсны дараа байгаль орчин, нийгмийн үнэлгээний зарим арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвшөөрөх эсэхийг ЕСБХБ-ны санхүүжилтийн нэг нөхцөл болгон ЕСБХБ-ны Захирлуудын зөвлөл өөрийн үзэмжээр шийдвэрлэнэ. Зөвлөл ийм шийдвэр гаргахдаа төслийн ерөнхий нөлөөлөл, эрсдэл, үр ашгийг тооцоолж үзнэ. Ийм нөхцлөөр төслийг баталсан бол төслийн танилцуулга баримт бичигт энэ тухай зааж өгнө.

Хууль, эрх зүйн баримт бичиг

42. Төслийн талаар ЕСБХБ-аас зээлдэгчтэй байгуулах санхүүжилтийн гэрээнд ЕСБХБ-ны байгаль орчин, нийгмийн шаардлагуудыг тусгасан тодорхой зүйл заалтуудыг оруулна. Үүнд, холбогдох бүх ГШ-ыг хангах, байгаль орчин, нийгмийн асуудлуудын талаар тайлагнах, талуудын оролцоог хангах, мониторинг хийх заалтууд орно. Санхүүжилтийн гэрээний дагуу хэрэгжүүлэх байгаль орчин, нийгмийн шаардлагуудыг багтаасан заалтуудыг зээлдэгч, эсвэл хөрөнгө оруулалт авсан компани биелүүлээгүй тохиолдолд Банкны зүгээс эдлэх эрх, хариу авах арга хэмжээний талаар гэрээний баримт бичигт шаардлагатай газар нь зааж өгнө.

¹² Гуравдагч тал нь тухайлбал төсөл/зээлдэгчийн нилээд гүнзгий хамтран ажилладаг Засгийн газрын агентлаг, гэрээт этгээд, ханган нийлүүлэгч, эсвэл холбогдох объект, үйлчилгээний байгууллага байж болно.

Мониторинг

43. Банк нь төслийн байгаль орчин, нийгмийн арга хэмжээний хэрэгжилт, гэрээнд тохирсон байгаль орчин, нийгмийн үүрэг, хариуцлагаа хэрхэн хэрэгжүүлж байгааг хянах эрхтэй. Хяналт мониторингийн цар хүрээ нь төсөл, түүний дотор шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн зуучлалын аль алинд нь хамаарах төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлуудаас шууд хамаарна. Мониторингийн хамгийн наад захын шаардлагад тухайн зээлдэгч жил тутам төслийн байгаль орчин, нийгмийн тайланг бэлтгэн танилцуулах үүрэн орно. ЕСБХБ нь тодорхой хугацааны давтамжтайгаар Банкны байгаль орчин, нийгмийн мэргэжилтнүүд, эсвэл бие даасан экспертүүдийг төслийн талбайд ажиллуулан тэдний бэлтгэсэн мэдээллийг хянах замаар мониторинг мөн явуулж болно.
44. Хэрэв зээлдэгч гэрээний баримт бичгүүдэд заасан нийгэм, байгаль орчны үүрэг хариуцлагаа биелүүлээгүй бол ЕСБХБ хэрэгжилтийг хангахад шаардагдах засч залруулах нэмэлт арга хэмжээ авах талаар зээлдэгчтэй тохиролцож болно. Хэрэв зээлдэгч тохирсон нэмэлт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээгүй тохиолдолд ЕСБХБ шаардлагатай гэж үзвэл санхүүжилтийн гэрээнд заасан болон засч залруулах арга хэмжээ авч болно. ЕСБХБ төсөлтэй холбоотой үйл ажиллагааг сайжруулах аливаа боломжийн талаар зээлдэгчтэй хамтран судалж үзнэ.

Төслийн үйл ажиллагаанд орох өөрчлөлтүүд

45. ЕСБХБ-аар батлагдаж, санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурснаас хойш төслийн агуулга, цар хүрээнд өөрчлөлт орж болох ба үүнээс үүдэн байгаль орчин, нийгмийн томоохон нөлөөллүүд үүсэж болзошгүй юм. Энэ төрлийн бодит өөрчлөлтүүд бий болохоор байгаа тохиолдолд Банкны зүгээс энэхүү бодлогын баримт бичгийн дагуу болон аливаа нэмэлт шаардлага, талуудын оролцооны шаардлагын дагуу холбогдох өөрчлөлтүүдэд байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийх бөгөөд байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг төслийн шинэчилэн өөрчилсөн баримт бичгүүдэд тусгана. Хэрэв төслийн үйл ажиллагаанд орсон өөрчлөлтүүдээс үүдсэн нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь Банкны зөвлөлөөр батлагдсан байгаль орчин, нийгмийн арга хэмжээнээс ихээхэн өөр байгаа бол тухайн төслийн өөрчлөлтийн талаар удирдлагын ахлах албан тушаалтан, хэрэв шаардлагатай бол ЕСБХБ-ны холбогдох бодлогын дагуу Зөвлөлд мэдээлж, зөвшөөрөл авна.

D. ЕСБХБ-ны олон нийтэд тайлагнах, хариуцлага хүлээх үүрэг

46. ЕСБХБ нь өөрийн үйл ажиллагаатай холбогдсон байгаль орчин, нийгмийн асуудлуудын талаар болон энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн талаар жил тутам тайлагнана.
47. Банкны Олон нийтэд мэдээлэх бодлого (ОНМБ¹³)-д тусгагдсан шаардлагын дагуу ЕСБХБ-аас санхүүжигдсэн төслүүдтэй холбоотой байгаль орчин, нийгмийн асуудлуудыг ЕСБХБ-ны Төслийн танилцуулга баримт бичиг (ТТБ)-т тоймлон танилцуулсан байна.
48. Банкны Хяналт үнэлгээний газраас ЕСБХБ-ны санхүүжилттэй төслүүдийн байгаль орчин, нийгмийн арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг Банкны Хяналт үнэлгээний бодлого, холбогдох зааврын дагуу хянан дүгнэж байна.

¹³ ОНМБ-ын баримт бичгүүдийг ЕСБХБ-ны Мэдээллийн булан болон ЕСБХБ-ны www.ebrd.com цахим хуудаст байршуулсан болно.

49. Банкнаас санхүүжүүлж байгаа төслүүдийн талаарх гомдлыг үнэлж, хянаж нягтлах зорилгоор ЕСБХБ нь төслийн холбогдолтой Гомдол барагдуулах механизм (ГБМ)-ыг бий болгосон болно. Тус механизм нь Банкны төслөөс үүдэн хохирол амсч байгаа хэмээн үзэж буй орон нутгийн иргэд, байгууллага, бүлэг хүмүүст гомдол гаргах, банкны үйл ажиллагаанаас хамааралгүйгээр асуудлыг шийдвэрлэхэд тусламж авах боломж олгодог. Мөн Банкны зүгээс энэхүү бодлогын баримт бичгийг, эсвэл ОНМБ-д тусгагдсан төсөлтэй холбоотой заалтыг хэрэгжүүлэхгүй байна гэж үзсэн иргэд, бүлэг хүмүүс гомдол гаргахдаа уг механизмыг ашиглаж болно.

Е. Бусадтай түншлэх болон хөрөнгө оруулалтын арга хэмжээнд байгаль орчин, нийгмийн ач холбогдлыг сайжруулах асуудлыг хөхиүлэн дэмжих нь

50. ЕСБХБ нь байгаль орчин, нийгмийн томоохон үр ашгийг бий болгох зорилгоор тусгайлан төлөвлөгдсөн төсөл, санаачилгуудыг хөхиүлэн дэмжинэ. Энэ бодлогод дараах асуудлууд багтана. Үүнд:

- ЕСБХБ-ны одоо хэрэгжүүлж байгаа ба санал болгосон төслүүдийг сайжруулах техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх;
- Техникийн хамтын ажиллагаа болон бодлогын яриа хэлэлцээг өрнүүлэх замаар ЕСБХБ-ны зээлдэгчид байгаль орчин, нийгмийн асуудлуудаа илүү сайн шийдвэрлэж чадахуйц тааламжтай орчныг бүрдүүлж сайжруулах;
- Тэргүүлэх чиглэлүүдээр бие даасан хөрөнгө оруулалтын төслүүдийг дэмжих;
- Байгаль орчин, нийгмийн өндөр үр ашигтай бизнесийн шинэ боломжуудыг судалж нээх туршилтын төслүүдийг санхүүжүүлэх.

Ү. Байгууллага болон хэрэгжилтийн зохицуулалт

51. Дээр дурдсан стратегийн чиглэлүүдийг хангалттай хэмжээнд тусгах үүднээс ЕСБХБ энэхүү бодлогын баримт бичгийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд үүрэг хариуцлага, зохих хөрөнгө нөөцийг хуваарилна. Түүнчлэн, байгаль орчин, нийгмийн үнэлгээ, мониторингийн үйл явцыг хянах, байгаль орчны болон нийгмийн ашиг тустай төслүүдийг санаачлах, боловсруулахын тулд Банк өөрийн ажилтнуудын зохих нөөцийг бэлэн байлгана.

52. Энэхүү бодлогын баримт бичиг нь Захирлуудын зөвлөлөөр батлагдсанаас хойш 6 сарын дараа хүчин төгөлдөр болно. Тус бодлого хүчин төгөлдөр болохоос өмнө Банкны удирдлага¹⁴-аар зөвшөөрөгдсөн төслүүдийн хувьд тухайн зөвшөөрөл гарсан үед хүчин төгөлдөр байсан бодлого үйлчилнэ.

53. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс ЕСБХБ нь байгаль орчин, нийгмийн журам, холбогдох удирдамж, гарын авлага, арга аргачлалыг боловсруулан шинэчилж, энэ бодлогын шаардлагуудын талаар Банкны ажилтнуудыг зохих сургалтанд хамруулна.

54. ЕСБХБ ерөнхий бодлогын асуудлууд, салбарын бодлого, стратегийн асуудлаар шийдвэр гаргахын өмнө өөрийн Байгаль орчин, нийгмийн зөвлөл (БОНЗ)-ийн

¹⁴ Энэхүү бодлого батлагдах үед, дээрх анхан шатны зөвшөөрөл гаргахыг «Концепцийн хувьд хянан үзэх» гэж нэрлэнэ.

дэмжлэг, саналыг авдаг байна. Мөн ЕСБХБ-ны төсөл, үйл ажиллагаатай холбоотой тодорхой асуудлаар энэ зөвлөлийн саналыг авна.

55. ЕСБХБ нь өөрийн санхүүжүүлж буй төслийн байгаль орчин, нийгмийн арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг тус бодлогын зорилготой нийцэж байгаа эсэхийг байнга нягтлан хянана. Энэхүү бодлогыг байнга эргэн нягталж, Захирлуудын зөвлөлийн баталснаар бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах буюу шинэчилж болно. Үүнээс гадна, энэ бодлогыг Захирлуудын зөвлөл 5 жил бүр хянан нягталж байна.

Хавсралт 1. ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн хориглосон үйл ажиллагааны жагсаалт

ЕСБХБ дараах бүтээгдэхүүн, үйл ажиллагаатай холбогдсон төслүүдийг санаатайгаар шууд, эсвэл шууд бусаар санхүүжүүлэхгүй. Үүнд:

- төсөл хэрэгжиж буй орны хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенциор хууль бус гэж үзсэн, эсвэл олон улсын шат дараатайгаар татаж авах ажиллагаа, хоригт хамрагдсан аливаа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах, аливаа үйл ажиллагаа явуулах, тухайлбал:
 - полихлорт бифенил (PCB буюу ПХБ) агуулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, худалдах¹⁵,
 - олон улсын үе шаттайгаар татаж авах ажиллагаа, хоригийг зөрчсөн эм, пестицид/гербицид болон бусад аюултай бодисыг үйлдвэрлэх, худалдах¹⁶,
 - олон улсын үе шаттайгаар татаж авах ажиллагаанд хамаарах озоныг задлах зүйлсийг үйлдвэрлэх, худалдах¹⁷,
 - зэрлэг амьтны ба ургамлын аймгийн ховордсон төрөл зүйлсийн олон улсын худалдааны тухай конвенц (CITES – ХЗОУХК)-аар зохицуулагддаг зэрлэг ан амьтныг худалдах, зэрлэг ангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах¹⁸,
 - олон улсын хуулиар хориглосон хаягдлыг хил дамнуулан тээвэрлэх¹⁹ зэрэг үйл ажиллагаа орно.
- асбестан наалдаагүй зөөлөн эд эсхүл асбест агуулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, ашиглах, худалдах,

¹⁵ PCB: Полифлоринатжуулсан бифенил маш хортой химийн бодисын бүлэг. 1950-1985 оны үеийн тосоор дүүргэсэн цахилгаан трансформатор, конденсатор болон хуваарилах төхөөрөмжинд PCB орсон байдаг.

¹⁶ Ишлэл: Зарим аюултай химийн бодисын экспорт ба импортын тухай нэмэлт өөрчлөлт оруулсан ЕХ-ны журам (ЕЕС) 2455/92, Засгийн газуудаас хэрэглээ болон/эсвэл худалдааг нь хорисон, татан авсан, хатуу хязгаарласан эсвэл батлаагүй бүтээгдээний НҮБ-ын нэгдсэн жагсаалт, Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай конвенци (Роттердамын конвенци), Тэсвэртэй органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенци, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын пестицидийн аюулын ангилал.

¹⁷ Озоны үе давхаргыг задалдаг бодисууд (ОЗБ): “Озоны цоорхой” бий болгоход хүргэдэг стратосферийн озонтой урвалд орж түүнийг задладаг химийн бодисууд. Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын протоколд эдгээр бодисуудыг багасгах, аажмаар устгах зорилтот хугацааг дурдсан байдаг. Аэрозоль, хөргөх бодис, хөөс үлээгч бодис, уусгагч болон галаас хамгаалах бодисыг багтаасан Монреалийн протоколоор зохицуулагддаг химийн бодисын жагсаалтад гарын үсэг зурсан орнуудын эдгээр бодисыг хэрэглээнээс хасах, устгах зорилтот хугацааны талаарх мэдээллийг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс авч болно.

¹⁸ CITES: Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци. CITES конвенцийн хүрээнд хамгаалагдсан зүйлсийн жагсаалтыг CITES-ийн ажлын албанаас авч болно.

¹⁹ Ишлэл: Хаягдал зөөвөрлөх тухай журам (ЕС) 1013/2006, Нөхөн сэргээлтэд зориулсан хаягдлыг хил давуулан тээвэрлэх ажиллагаанд тавих хяналтын тухай эцсийн шийдвэр С(92)39-ийн өөрчлөлттэй хамаатай Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын зөвлөлийн эцсийн шийдвэр С(2001) 107, Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенци.

- биологийн олон янз байдал, эсвэл соёлын өв уламжлалыг хамгаалах тухай хүлээн авагч орны хууль, тогтоомж буюу олон улсын конвенциор хориглосон үйл ажиллагаа²⁰,
- 2.5 км-аас илүү урт тор ашиглан далайд тор хөвүүлэн загас барих,
- олон улсын далайн байгууллага (ИМО)-ын шаардлагыг хангаагүй ачааны усан онгоцонд газрын тос болон бусад аюултай бодис материал тээвэрлэх²¹,
- шаардлагатай экспорт, импортын лицензгүй, эсвэл экспорт, импорт хийж байгаа холбогдох орны транзитын зөвшөөрөлгүй барааг худалдах, транзитаар тээвэрлэх үйл ажиллагаанууд орно.

²⁰ Холбогдох олон улсын конвенциуд: Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенци (Бонны конвенц); Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенци (Рамсар конвенци); Европын зэрлэг ан амьтан ба байгалийн амьдрах орчныг хамгаалах тухай конвенци (Берны конвенци); Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенци; Биологийн олон янз байдлын тухай конвенци.

²¹ Эдгээрт: Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын конвенци (MARPOL), Далайд хүний аюулгүй ажиллагааг хангах тухай олон улсын конвенци (SOLAS)-ийн дагуу холбогдох сертификат аваагүй (мөн Олон улсын аюулгүй ажиллагааны менежментийн дүрэм зэрэг бусад шаардлагууд) ачааны усан онгоцууд, ЕХ-ны хар жагсаалтад орсон, эсвэл Боомт бүхий улсуудын хяналтын талаарх харилцан ойлголцлын тухай Парижийн санамж бичиг (Парижийн харилцан ойлголцлын санамж бичиг)-ийн дагуу үйл ажиллагааг нь хориглосон, түүнчлэн MARPOL-ийн 13G заалтын дагуу аажмаар хасагдах усан онгоцууд тус тус багтана. Их бие нь 25 жилээс илүү болсон аливаа ачааны усан онгоцыг ашиглахгүй байвал зохино.

Хавсралт 2. «А» ангиллын төслүүд

Энэ жагсаалт нь "ашиглагдаж байгаагүй шинэ газар"-т хэрэгжүүлэх төсөл, эсвэл ихээхэн өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэл хийх зорилготой доор дурдсан ангиллын төслүүдэд хамаатай. Доор жагсаасан төслүүд нь ирээдүйд байгаль орчин, нийгмийн ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй тул байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагатай төслүүдийн тоонд орно. Тухайн төсөл ямар ангилалд багтах нь төслийн мөн чанар, байршил, эмзэг байдал, цар хүрээнээс шалтгаалсан байгаль орчин, нийгмийн одоо үүсээд буй болон цаашид үүсэж болзошгүй нөлөөллийн мөн чанар, цар хэмжээнээс хамаарна.

1. Газрын тосыг боловсруулах үйлдвэрүүд (үүнд газрын тосноос тослох материал үйлдвэрлэх жижиг үйлдвэрүүд орохгүй) болон өдөрт 500 тонн ба түүнээс их нүүрс эсвэл битумен занарыг хийжүүлэх, шингэрүүлэх байгууламжууд.
2. 300 ба түүнээс дээш мегаватт²² дулаан гаргадаг дулааны эрчим хүчний станц ба бусад эрчим хүч үйлдвэрлэдэг байгууламжууд, цөмийн эрчим хүчний станцууд болон цөмийн бусад реактор, үүнд ийм төрлийн эрчим хүчний станц эсвэл реакторыг задлах, ашиглалтаас хасах явдал мөн орно (дээд чадал нь 1 кВт үргэлжлэх дулааны ачааллаас хэтрэхгүй задрах, эсвэл цөмийн түлшний түүхий эдийг үйлдвэрлэх, хувиргах шинжилгээ судалгааны байгууламжуудаас бусад).
3. Цөмийн түлшийг үйлдвэрлэх, баяжуулах, цацраг туяанд өртсөн цөмийн түлшийг дахин боловсруулах, хадгалах, зайлуулах, цацраг идэвхт хаягдлыг хадгалах, зайлуулан устгах, эсвэл боловсруулах зориулалттай байгууламжууд.
4. Ширэм болон ганг анхан шатанд хайлуулах үйлдвэрүүд, металлургийн, химийн эсвэл элетролизийн аргаар өнгөт-бус түүхий металлын хүдэр, концентрат, хоёрдогч түүхий материалаас үйлдвэрлэх байгууламжууд.
5. Химийн хувирал ашиглан үйлдвэрлэлийн хэмжээнд химийн бодис үйлдвэрлэх, өөрөөр хэлбэл нэг нэгэнтэйгээ холбоотой хэд хэдэн зэргэлдээ нэгжүүдээс бүрдсэн нэгтгэсэн химийн байгууламжуудыг байгуулж химийн эсвэл биологийн явц, тэсрэх материалыг ашиглан дараах бүтээгдэхүүнийг боловсруулна. Үүнд: суурь органик химийн бодис, суурь органик бус химийн бодис, фосфор, азот юмуу калийн үүсэлтэй бордоо (дан эсвэл нийлмэл бордоо); үндсэн ургамлын эрүүл мэндийн бүтээгдэхүүн, биоцид хийгээд химийн болон биологийн явцыг ашиглан үндсэн эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
6. Автозам, хурдны зам болон холын зайн төмөр зам, 2,100 болон түүнээс урт нисэх, буух талбайтай нисэх онгоцны буудал, 4 ба түүнээс олон шугамтай шинэ зам барих, эсвэл 4 ба түүнээс олон шугамтай замтай болохын тулд одоогийн замуудыг өөрчлөх, өргөтгөх, ингэхдээ шинэ зам, өөрчөгдөх буюу замын өргөтгөсөн хэсэг уртаараа 10 км болон түүнээс урт байх нөхцөлд дээрх төрлийн зам барих.
7. Хий, газрын тос болон химийн бодисыг их хэмжээгээр тээвэрлэхэд зориулсан дамжуулах хоолой, терминал тэдэнтэй холбоотой байгууламжууд.

²² Уурын болон нэг эргэлттэй хийн хөдөлгүүрт эрчим хүчний станцын 140 мВт цахилгаан үйлдвэрлэх хүчин чадалтай тэнцэнэ.

8. Томоохон хэмжээний далайн боомт, улс орны дотоодын усан зам болон тэдгээрийн боомт, худалдааны боомт, газартай холбогдсон ачих ба буулгах усан зогсоол, гадны (гаталгаат онгоцны зогсоолоос бусад) боомт.
9. Шатаах, химийн үйлчилгээ эсвэл аюултай, хортой, хор хөнөөлтэй хог хаягдлыг шатаах, химийн боловсруулалт хийх, хог хаягдлыг булж устгах байгууламжууд.
10. Хор хөнөөлгүй хог хаягдлыг шатаах, химийн боловсруулалт хийх томоохон байгууламжууд.
11. Ус тогтоох, байнга хадгалах зориулалттай том²³ далан болон бусад байгууламж.
12. Жилд 10 сая шоо метр ба түүнээс илүү хэмжээний газрын доорх усыг ашиглах, эсвэл дахин ашиглах.
13. (i) Мод эсвэл ижил ширхэгтэй материалаас зөөлөн эдийг нь авч боловсруулах; (ii) салхинд хатаасан 200-аас дээш метр-тонн цаас ба банз өдөрт үйлдвэрлэх хүчин чадалтай аж үйлдвэрүүд.
14. Их хэмжээний хүлэр олборлох, ил уурхайн олборлолт, металлын хүдэр, нүүрс боловсруулах байгууламж.
15. Бизнесийн зорилгоор газрын тос болон байгалийн хийг олборлох ажиллагаа.
16. 200,000 ба түүнээс дээш тоннын хүчин чадалтай газрын тос, нефтийн гаралтай химийн бодис буюу химийн бодисыг хадгалах байгууламж.
17. Их хэмжээний мод бэлтгэл, эсвэл их хэмжээний ойг устгах ажиллагаа.
18. 150,000-аас дээш хүн амтай хот суурин газарт зориулсан бохир ус цэвэрлэх байгууламж
19. Хотын хатуу хог боловсруулж устгах байгууламжууд.
20. Өргөн хүрээтэй жуулчлал ба жижиглэн худалдаа.
21. Агаарын өндөр хүчдэлийн цахилгаан эрчим хүчний шугам.
22. Салхин эрчим хүч үйлдвэрлэх томоохон байгууламжууд (салхин парк).
23. Их хэмжээний талбай бүхий шинэ газар ашиглах, усны ёроолын хөрс ухах томоохон ажиллагаа.
24. Нэмэлт тариалалт хийх, газар ашиглалтын зориулалтыг өөрчлөх, биологийн чухал төрөл зүйлс, амьтан ургамлын амьдрах орчныг өөрчилж болзошгүй хөдөө аж ахуйн болон ойжуулалтын томоохон ажиллагаа.

²³ Том далангийн олон улсын комисс (ТДОУК)-ын тодорхойлсноор том даланд суурьнаасаа 15 м болон түүнээс дээш өргөгдсөн далан орно. Өндрөөрөө 5-15 м боловч хадгалах усны багтаамж нь 3 сая шоо метрээс илүү бол мөн том даланд тооцогдоно.

25. Өдөрт 12 тонноос илүү эцсийн бүтээгдэхүүн гаргах хүчин чадалтай арьс шир боловсруулах үйлдвэрүүд.
26. (i) 85,000 дэгдээхий, 60,000 өндөгний тахианы байр; (ii) 30 кг-аас дээш жинтэй 3,000 гахайны байр; эсвэл (iii) 900 мэгжний байрнаас дээш хүчин чадалтай гахай, тахиаг эрчимтэй өсгөх байгууламжууд.
27. Хэдийгээр энэ жагсаалтад ангилагдан ороогүй боловч олон улсын, тухайн улс орны болоод орон нутгийн ач холбогдол бүхий эмзэг газар орчинд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй, эсвэл тэр газар орчинд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр байгаа төслүүд²⁴. Тийм эмзэг газар орчинд тухайлбал, тухайн улс орон, олон улсын хуулиар тогтоогдсон тусгай болон бусад хамгаалалттай газар, мөн олон улсын, үндэсний, бүсийн ач холбогдолтой газар нутаг, тухайлбал биологийн чухал төрөл зүйл бүхий намагшсан газар, ой мод, археологийн ба соёлын ач холбогдолтой газар нутаг, нутгийн уугуул иргэд, бусад эмзэг бүлэг хүмүүст чухал бүс нутгийг багтаана.
28. Орон нутгийн нийгмийн бүлгүүд эсвэл төслийн нөлөөлөлд өртсөн талуудад нийгмийн ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй төслүүд.
29. Албадан нүүлгэн суурьшуулалт, эсвэл эдийн засгийн хувьд ихээхэн алдагдал, хохирол дагуулж болзошгүй төслүүд.

²⁴ Байгаль орчин, нийгмийн чиглэлтэй бүхий л төслүүд (тухайлбал, сэргээгдэх эрчим хүч зэрэг)

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 1: **Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлын үнэлгээ ба менежмент**

Танилцуулга

1. Энэхүү Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) нь төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн нөлөөлөл²⁵, асуудлыг тодорхойлох цогц үнэлгээг гүйцэтгэх асуудал, мөн зээлдэгч нь төслийг хэрэгжүүлэх бүхий л хугацааны туршид байгаль орчин, нийгмийн асуудлыг зохицуулан шийдвэрлэх нь ихээхэн чухал болохыг онцлон тэмдэглэсэн болно. Амжилттай, мөн үр ашигтай байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС) нь компаний удирдлагаас санаачилж дэмжсэн хувьсан өөрчлөгдөж байдаг үргэлжилсэн явц бөгөөд энэхүү систем нь зээлдэгч, түүний ажиллагсад, төслийн эсвэл зээлдэгчийн бусад үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн олон нийт, шаардлагатай тохиолдолд бусад талууд хоорондын уялдаа харилцааг зохицуулдаг. Төслийн үйл ажиллагааг байнга сайжруулахын тулд уг системийн хүрээнд төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж нягтлах, үр дүнг сайжруулах цогц арга хандлагыг нэвтрүүлэх шаардлагатай. Цаашлаад, төслийн цар хүрээ, шинж чанарт тохирсон БОНТС систем нь байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг дэмжих ба төслийн санхүү, байгаль орчин, нийгмийн арга хэмжээний үр дүнд эерэгээр нөлөөлдөг.
2. Энэхүү ГШ нь төсөлтэй холбоотойгоор үүсэж болзошгүй байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлуудыг тодорхойлох, тэдгээрийг зохицуулах, хянах холбогдох журмыг боловсруулж, хэрэгжүүлэх талаар зээлдэгчийн хүлээх үүрэг хариуцлагыг зааж өгсөн болно. Талуудыг татан оролцуулах явдал энэ үйл явцын салшгүй хэсэг байна. Энэ ГШ-ыг хэрэгжүүлэхдээ талуудын оролцооны талаарх ГШ 10-тай танилцан уялдуулвал зохино.

Зорилго

3. Энэхүү ГШ нь:
 - төслөөс үүдэн бий болж болзошгүй байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлуудыг тодорхойлон, үнэлэх,
 - төслийн үйл ажиллагаанаас үүдэн ажиллагсад, олон нийт, байгаль орчинд үзүүлэх байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл, асуудлуудыг нөлөөллийг шат дараатайгаар арга замаар²⁶ шийдвэрлэх,
 - менежментийн системийг үр дүнтэй ашиглах замаар зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааг сайжруулахад түс дөхөм үзүүлэх,
 - холбогдох ГШ-д нийцсэн байдлаар байгаль орчин, нийгмийн асуудал, нөлөөллийг үнэлэх, зохицуулах зорилгоор төслийн мөн чанарт тохирсон БОНМС-ийг боловсруулах зорилготой болно.

²⁵ Энэхүү бодлогын баримт бичигт нийгмийн нөлөөлөл гэж хувь хүн, хамт олон, ажилчдад тухайн бизнес үйл ажиллагаанаас үүдэн учрах нөлөөлөл, тэдний ажлын нөхцөл, нийгэм-эдийн засгийн статус, соёлын онцлог, хүний эрх, эрүүл мэндэд нөлөө үзүүлэх хэлбэрийг хэлнэ.

²⁶ Нөлөөллийг бууруулах үе шатуудад төслийн үйл ажиллагаа эхлэх үеэс байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй тохиолдолд нөлөөллийг багасгах, бууруулах, эцэст нь дүйцүүлэн хамгаалах, нөхөн олговор олгох зэрэг арга хэмжээнүүд багтана.

Үйлчлэх хүрээ

4. Энэхүү ГШ нь ЕСБХБ-ны санхүүжүүлж буй бүх төсөлд үйлчилнэ. Зээлдэгч нь өөрийн байгаль орчин, нийгмийн үнэлгээний ажлын хүрээнд энэхүү ГШ-ын холбогдох шаардлагууд, мөн тэдгээр шаардлагыг төслийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төслийг хүлээлгэн өгөх, эсвэл хаах, шинээр эхлүүлэх явцад хэрхэн хангах талаар тодорхойлно.
5. Энэхүү ГШ-д «төсөл» гэж ЕСБХБ-аас санхүүжилт авахыг хүссэн, эсвэл ЕСБХБ-аас санхүүжилт авахаар дэмжигдсэн, санхүүжилтийн гэрээнд тусгагдсан, Захирлуудын зөвлөл, эсвэл шийдвэр гаргагч бусад байгууллагаар зөвшөөрөгдсөн бизнесийн цогц үйл ажиллагааг хэлнэ.
6. Шинэ байгууламж барих, эсвэл шинэ бизнес үйл ажиллагаа эрхэлж буй төслийг энэхүү ГШ-нд тусгагдсан шаардлагуудыг төслийн эхэн үеэс хангасан байхаар боловсруулах шаардлагатай. Одоо байгаа байгууламжтай холбоотой төслийн хувьд, эсвэл тухайн төсөл уг ГШ-ыг анхнаасаа хангахгүй байгаа тохиолдолд байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ)²⁷ боловсруулан хэрэгжүүлэхийг зээлдэгчээс шаардана. БОНМТ-д тухайн байгууламжтай холбоотой үйл ажиллагаа энэхүү ГШ-ыг тодорхой хугацааны дотор хангахад шаардлагатай цогц арга хэмжээнүүдийг тусгана.

Шаардлага

Байгаль орчин, нийгмийн үнэлгээ

7. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг гүйцэтгэхдээ хамгийн сүүлийн үеийн мэдээлэл, түүний дотор төслийн тухай үнэн бодит тодорхойлолт, зээлдэгчийн холбогдох үйл ажиллагаанууд, нийгэм, байгаль орчны суурь нарийвчилсан өгөгдөл, тоо баримтад тулгуурласан байна. Үнэлгээний ажлаар мөн (i) тухайн төсөл хэрэгжиж буй улс орны байгаль орчин, нийгмийн холбогдох хууль тогтоомж, шаардлагууд, түүний дотор тухайн улс орны олон улсын хуулиар хүлээсэн үүрэгтэй холбоотой хууль тогтоомжууд, болон (ii) уг ГШ-ын дагуу биелүүлэх ёстой холбогдох шаардлагуудыг тус тус тодорхойлно. Энэхүү үнэлгээнд нөлөөллийг шат дараатайгаар бууруулах болон олон улсын сайн туршлагыг²⁸ голлож ашиглах хэрэгтэй. Хэрэв тухайн төслөөс байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөлөл үзүүлэхээр бол зээлдэгч үнэлгээний ажлын хүрээнд төсөлд хамаатай оролцогч талуудыг тодорхойлон, ГШ 10-ын дагуу төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад тэдэнтэй хамтран ажиллаж, санал бодлыг нь тусган ажиллах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх шаардлагатай.
8. Үнэлгээний ажил нь төслөөс үүдэн бий болж болзошгүй нөлөөлөл, асуудлуудыг бүрэн хамарсан байх ёстой бөгөөд төслийг хэрэгжүүлэх үе шатууд (тухайлбал барилгын өмнөх, барилгын, төслийг хэрэгжүүлэх, хүлээлгэн өгөх, хаах, дахин сэргээх үе шат)-д үүсэж болзошгүй байгаль орчин, нийгмийн шууд болон шууд бус нөлөөлөл, асуудлуудыг иж бүрнээр нь авч үзсэн байх шаардлагатай. Түүнчлэн,

²⁷ БОНСТ нь санхүүжилтийн гэрээнүүдийн салшгүй хэсэг байна.

²⁸ Олон улсын сайн туршлага гэж дэлхийд болон бүс нутагт ижил төслийг ижил төстэй нөхцөлд хэрэгжүүлэх явцад мэргэшсэн, туршлагатай мэргэжилтнүүдийн зүгээс мэргэжлийн өндөр үр чадвар, хянамгай байдал, анхаарал, ирээдүйг харсан байдлаар ажиллаж ирсэн туршлагыг хэлнэ. Ийм туршлагын үр дүнд тухайн төслийн онцлог нөхцөл байдалд хамгийн тохиромжтой технологийг тухайн төсөлд ашигласан тохиолдол орж болно.

зээлдэгч байгаль орчин, нийгмийн үнэлгээнээс гадна, онцгой эрсдэл, нөлөөлөл, жишээ нь уур амьсгалын өөрчлөлт, хүний эрх, жендэрийн асуудал зэргийг хамарсан нэмэлт судалгаа хийх нь зүйтэй.

9. Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл ба асуудлуудын үнэлгээнд мөн тухайн төслийн бүрэлдэхүүн хэсэг биш боловч төслийн шууд болон шууд бус нөлөөлөлд өртсөн, эсвэл тухайн төслөөс хамааран оршин тогтнож байгаа, эсвэл тухайн төсөлд эрсдэл учруулж байгаа тийм үйл ажиллагаа, барилга байгууламжийн байгаль орчин, нийгмийн асуудлуудыг боломжийн хэрээр тодорхойлон гаргах ёстой. Энэ төрлийн үйл ажиллагаа, барилга байгууламж нь төслийн хувьд чухал ач холбогдолтой байж болох ба зээлдэгчийн шууд хяналтанд байдаг, эсвэл гуравдагч этгээдийн хариуцдаг, эсвэл түүний мэдлийн байж болно. Зээлдэгч тэдгээр үйл ажиллагаа, барилга байгууламжийг хянаж, нөлөөлж чадахгүй тохиолдолд байгаль орчин, нийгмийн үнэлгээнд энэхүү барилга байгууламж, үйл ажиллагаанаас төсөлд учруулж болзошгүй эрсдлүүдийг тодорхойлох нь зүйтэй. Гуравдагч этгээдийн үйл ажиллагаа, барилга байгууламжтай холбоотой байгаль орчин, эсвэл нийгмийн томоохон сөрөг эрсдэлийг илрүүлсэн тохиолдолд зээлдэгч эдгээр эрсдэлийг хянах, бууруулах талаар тэдгээр холбогдох гуравдагч этгээдтэй хамтран ажиллах ёстой. Мөн төслийн ашиг тусыг нэмэгдүүлэх боломжтой бол зээлдэгч нь гуравдагч этгээдэд нөлөөлөх талаар ажиллах шаардлагатай. Дээр нь үнэлгээний ажилд төслийн хуримтлагдах нөлөөллийг өнгөрсөн, одоогийн болон цаашдын хүлээгдэж буй тооцоолох боломжтой холбогдох үйл явц, мөн төслийн явцад төлөвлөгдөөгүй боловч гарч болзошгүй, эсвэл өөр газар гарч магадгүй үйл ажиллагааны нөлөөллийн хамт авч үзэх ёстой.
10. «А» ангиллын төслүүд²⁹ нь тийм амар илрүүлэн тодорхойлох боломжгүй, байгаль орчин, нийгмийн томоохон сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй тул зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ)-г цогц байдлаар хийх шаардлага үүсдэг. БОННУ-г хийхдээ төсөлтэй холбогдон гарч болзошгүй байгаль орчин, нийгмийн нөлөөллийг илрүүлэх үе шатыг тодорхойлно. БОННУ-нд эдгээр нөлөөллийн эх сурвалжийг бууруулж болох техникийн болоод санхүүгийн хувьд боломжтой арга хувилбарууд, түүний дотор төслийг хэрэгжүүлэхгүй байх хувилбарыг судалж, авч болох тодорхой арга хэмжээний саналыг баримтжуулсан байна. Мөн нөхцөл байдлыг сайжруулах боломжуудыг тодорхойлж, сөрөг нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй тохиолдолд нөлөөллийг багасгах, бууруулах арга хэмжээнүүдийг санал болгоно³⁰. БОННУ-г бие даасан мэргэжилтнүүдээр хийлгэх буюу шалгуулах шаардлагатай байж болно. БОННУ-ий ажлыг хийхдээ ГШ 10-т заасны дагуу олон нийтэд нээлттэй мэдэгдэн, зөвлөлдөх үйл ажиллагаа явуулсан байх шаардлагатай.
11. «В» ангиллын төслүүдийн хувьд цаашид үүсэх байгаль орчин, нийгмийн нөлөөлөл нь зөвхөн тухайн төсөл хэрэгжиж буй талбайд хамааралтай, мөн эдгээр тодорхойлсон нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах замаар шийдвэрлэж болох ба зээлдэгч нь төслийн мөн чанар, цар хүрээ, байршилтай уялдсан, үүсэж болзошгүй нөлөөлөл, эрсдэлийг тооцон үзсэн байгаль орчин, нийгмийн үнэлгээг хийлгэнэ. Үнэлгээгээр төсөлтэй холбоотой цаашид үүсэж болзошгүй сөрөг

²⁹ «А» ангиллын төслийн жагсаалтыг ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлогын Хавсралт 2-т оруулсан болно.

³⁰ Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд төсөлтэй холбоотой үүсэж болзошгүй шууд болон шууд бус, хуримтлагдах нөлөөлөл, мөн шаардлагатай үед хил дамнасан нөлөөллийг авч үзнэ.

нөлөөллийг тодорхойлж, нөхцөл байдлыг сайжруулах боломжуудыг илрүүлэн, нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй тохиолдолд багасгах, бууруулах арга хэмжээг зөвлөмж болгоно.

12. Одоо байгаа барилга, байгууламжтай холбоотой «А», «В» ангиллын төслүүдийн хувьд өмнө нь явагдсан болон одоо явагдаж буй үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг тодорхойлох байгаль орчин, нийгмийн үнэлгээг хийлгэх шаардлагатай. Тус үнэлгээний зорилго нь одоогийн байгаа барилга, байгууламж болон үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэж болзошгүй эрсдэл, үүрэг хариуцлага, боломжуудыг илрүүлж, тухайн төслийн үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, зээлдэгчийн менежментийн систем, нийтлэг үйл ажиллагаа нь эдгээр ГШ-ыг хангаж байгаа эсэхэд үнэлгээ өгөх явдал юм. Одоогийн барилга байгууламжуудыг шалгахдаа тухайн объектуудад хамааралгүй бие даасан мэргэжилтнээр шалгалтыг хийлгэх нь зүйтэй.
13. Байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөө нь маш бага, эсвэл аливаа нөлөөлөл үзүүлэхээргүй, цаашлаад сөрөг нөлөөллийг илрүүлэх, бууруулах арга хэмжээ аван шийдвэрлэх боломжтой «С» ангиллын төслүүдийн хувьд зээлдэгч нь энэхүү ГШ-ын §14-22-т заасанчлан нөлөөлөл, эрсдэлийг бууруулахад тохирсон БОНМС-ийг хэрэгжүүлж, ГШ 1-ын §23-28-д заасны дагуу ГШ-тай нийцэж байгаа эсэхэд мониторинг хийж, тайлагнана.
14. Олон талбайд үйл ажиллагаа явуулж буй зээлдэгч ЕСБХБ-аас ерөнхий санхүүжилт, урсгал хөрөнгө, эсвэл үнэт цаасны санхүүжилтийг хүсэх тохиолдолд дээрх §7-12-т заасан үнэлгээг хийлгэх нь тохиромжтой бус байх талтай. Энэ тохиолдолд зээлдэгчийн одоогийн байгаль орчин, нийгмийн менежментийн систем, мөн компанийн өмнө явагдсан болон одоогийн үйл ажиллагаа нь холбогдох ГШ-тай нийцэж буй эсэхийг харьцуулж, төслийн талбайн хэмжээнд бус, харин байгууллагын түвшинд байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. Байгууллагын түвшний үнэлгээнд:
 - зээлдэгчийн үйл ажиллагаа, барилга байгууламжтай холбоотой бүхий л байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлыг энэхүү ГШ-д заасан шаардлагуудын дагуу шийдвэрлэж чадах эсэхийг үнэлэх,
 - төсөл хэрэгжиж байгаа орны байгаль орчин, нийгмийн асуудлуудад хамааралтай холбогдох хууль, тогтоомжийг зээлдэгч дагаж мөрдөж ирсэн байдлыг үнэлэх, зээлдэгчийн төслийн холбогдох оролцогч талууд болон одоо хийгдэж буй талуудын оролцооны үйл ажиллагааг үнэлж тодорхойлох ажлууд багтана.

Корпорацийн түвшний үнэлгээний бодит цар хүрээг тухай бүр тогтоож байна.

Байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС)

15. Зээлдэгчид төслийн мөн чанар, цар хэмжээнд тохирсон, мөн төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлуудыг шийдвэрлэх боломжтой, олон улсын сайн туршлагад нийцсэн БОНМС-ийг бий болгон ажиллуулах шаардлагатай. Энэ төрлийн менежментийн системийн зорилго нь байгаль орчин, нийгмийн шаардлагуудыг нэг мөр, харилцан уялдаатай үйл явцад нэгтгэн хэрэгжүүлэх, зээлдэгчийн үндсэн үйл ажиллагаанд шингээж өгөх явдал юм.

Байгаль орчин, нийгмийн бодлого

16. Зээлдэгч шаардлагатай тохиолдолд төслийн байгаль орчин, нийгмийн асуудлыг амжилттай шийдвэрлэх байгаль орчин, нийгмийн харилцааны зорилт, зарчмуудыг тодорхойлсон нийтлэг бодлого гаргаж ажиллана. Энэхүү бодлогоор ГШ-ын зарчмуудад нийцсэн байгаль орчин, нийгмийн үнэлгээ, менежментийн цар хүрээг тогтоож өгнө.

Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө

17. Байгаль орчин, нийгмийн үнэлгээгээр тодорхойлсон асуудлууд, талуудын оролцооны үр дүнг харгалзан, зээлдэгч нь ГШ-ыг хангах зорилгоор төслийн нийгэм, байгаль орчны нөлөөлөл, асуудлуудыг шийдвэрлэх, гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээний хөтөлбөр боловсруулж ажиллана. Тухайн төслөөс хамааран, энэхүү хөтөлбөр нь байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнүүд (БОНМТ) хэмээн нийтэд нь нэрлэгдэх үйл ажиллагааны бодлого, менежментийн систем, холбогдох журмууд, төлөвлөгөө, туршлага, үндсэн хөрөнгө оруулалт зэрэг бодлогын баримт бичгүүдээс бүрдэж болно.
18. БОНМТ-г нөлөөллийг шат дараатайгаар бууруулсан байхаар боловсруулж, техникийн болоод санхүүгийн хувьд боломжтой бол сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах, нөхөн олговор олгон шийдвэрлэхээс илүүтэйгээр зайлсхийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг түлхүү авч хэрэгжүүлнэ. Мөн төслийг хэрэгжүүлэх бүхий л үе шатанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, ГШ-ыг хангасан байхаар төслийг төлөвлөх шаардлагатай. Нөлөөлөлд өртсөн хүмүүс, бүлэг хүмүүсийг үнэлгээний явцад боломж муутай, эмзэг бүлэгт³¹ багтах аар тодорхойлсон тохиолдолд БОНМТ-нд төслөөс үүдэлтэй сөрөг нөлөөлөл тэдэнд хэт хүндээр тусахааргүй байх, мөн төслөөс ашиг тус хүртэх боломж олгосон тусгай арга хэмжээнүүдийг зааж өгөх нь зүйтэй. Шаардлагатай тохиолдолд БОНМТ-нд гуравдагч этгээдийн менежмент, ханган нийлүүлэлтийн сүлжээний асуудлыг тусгана.
19. БОНМТ нь хэр дэлгэрэнгүй, нарийвчилсан байх нь тухайн төслийн онцлог, эрсдэл, нөлөөлөл, боломжоос хамаарна. БОНМТ-нд хүсч байгаа үр дүнг тодорхой хугацааны турш хэмжиж болохуйц зорилтот тоо хэмжээ, шалгуур үзүүлэлтээр илэрхийлэн тусгаж өгнө. Төслийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх үйл явц төслийн хугацаанд өөрчлөгдөж байдаг тул БОНМТ-нд урьдчилж тооцоогүй үйл явдал, хууль тогтоомжид орсон шинэчлэлт, мониторинг, хяналт шалгалтын үр дүнгээс хамаарсан өөрчлөлтийг тухай бүр тусгана.
20. БОНМС болон түүнд тодорхойлсон тусгай шаардлага, арга хэмжээг зээлдэгч өөрөө, эсвэл гэрээт гүйцэтгэгчид хэрэгжүүлж байгаа эсэхээс үл хамааран эдгээр арга хэмжээг тухайн төслийн хувьд авч хэрэгжүүлнэ. Энд дурдсанчлан төслийн талбайд ажиллаж буй гэрээт гүйцэтгэгчид дээрх шаардлагыг биелүүлэх ёстой

³¹ Энэхүү бодлогын баримт бичгийн хувьд «эмзэг бүлэг» гэж жендэр, бэлгийн чиг хандлага, шашин шүтлэг, яс үндэс, уугуул иргэншил, нас, хөгжлийн болон санхүүгийн бэрхшээл, нийгмийн статус зэргээс хамааран бусадтай харьцуулахад төслийн нөлөөлөлд илүүтэйгээр өртсөн, төслийн үр ашгаас хүртэх боломж, чадвар багатай хүмүүсийг хэлнэ. Эмзэг бүлгийн хүмүүст ядуурлын түвшнээс доогуур амьжиргаатай, өөрийн гэсэн газаргүй хүмүүс, ахмад настан, өрх толгойлсон эмэгтэйчүүд, хүүхдүүд, албадан нүүлгэсэн хүмүүс, үндэстний цөөнх, амьжиргаа нь байгалийн баялгаас хамааралтай бүлэг хүмүүс зэрэг тухайн улс орны болон олон улсын хууль тогтоомжоор хамгаалагдаагүй байж болох бусад хүмүүс бас багтаж болно.

бөгөөд зээлдэгч нь гэрээт гүйцэтгэгчдийн үйл ажиллагааг хянах менежментийн системийг боловсруулж хэрэгжүүлэх замаар энэхүү шаардлагыг хангах үүргийг хүлээнэ. Гэрээт гүйцэтгэгчдийг үр дүнтэйгээр хянан удирдах арга хэмжээнд:

- гэрээт ажил, үйлчилгээтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлд үнэлгээ хийж, БОНМТ-ний нөхцлийг тендэрийн баримт бичигт тусгах, холбогдох стандартыг биелүүлэх, үл биелүүлсэн тохиолдолд авах арга хэмжээг тусгахыг гэрээгээр шаардан заах,
- гэрээний нөхцлийн дагуу гэрээт гүйцэтгэгч нь төслийн ажлыг гүйцэтгэх мэдлэг, мэргэшлийн түвшинг хангасан байхыг хянан шалгаж байх,
- гэрээт гүйцэтгэгч гэрээний нөхцлийг хангаж байгаа эсэхэд мониторинг хийж байх,
- гэрээт гүйцэтгэгч нь өөрийн давхар гэрээлсэн гүйцэтгэгчтэй адил зохицуулалт хийсэн байхыг гэрээт гүйцэтгэгчээс шаардах арга хэмжээнүүд багтана.

Гэрээт ажиллагсадын хөдөлмөр, ажлын нөхцөлтэй холбоотой шаардлагуудыг ГШ 2-т, ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлагуудыг ГШ 4-т тус тус оруулав.

Байгууллагын чадавхи болон үүрэг амлалт

21. Зээлдэгч тухайн улс орны холбогдох хууль, тогтоомжийн шаардлага, ГШ-ыг хангаж байх зорилгоор БОНМС-ийг авч явах үүрэг, хариуцлага, эрх мэдлийг тодорхойлсон байгууллагын бүтцийг бий болгон ажиллаж, цаашид бэхжүүлэх шаардлагатай. Зээлдэгч БОНМС-ийг хэрэгжүүлэх тодорхой үүрэг, эрх мэдэл бүхий тусгай ажилтан, мөн менежментийн түвшний төлөөлөгч томилж ажиллуулна. Байгаль орчин, нийгмийн асуудлаар хүлээх гол хариуцлагыг тодорхойлж, холбогдох ажилтнуудад танилцуулсан байх ёстой. Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн асуудлыг үр дүнтэйгээр тухай бүр шийдвэрлэн авч явах нөхцлийг хангах үүднээс шаардлагатай дэмжлэг, хүний болон санхүүгийн нөөцөөр тогтмол хангавал зохино.
22. Зээлдэгч нь төслийн нийгэм, байгаль орчинтой холбоотой үйл ажиллагааг шууд хариуцан ажиллаж буй ажиллагсдад зохих мэдлэг олгон, холбогдох сургалтанд хамруулна.

Ханган нийлүүлэлтийн сүлжээний менежмент

23. Зээлдэгч өөрийн ханган нийлүүлэлтийн сүлжээтэй холбоотой эрсдэлийг тодорхойлох шаардлагатай. Зээлдэгч өөрийн гол ханган нийлүүлэгчдийг зохих түвшинд хянаж чадах тохиолдолд байгаль орчин, нийгмийн үнэлгээний явцад төслийн суурь үйл ажиллагаанд гол үүрэгтэй бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн сүлжээ нь байгаль орчин, нийгмийн эрсдэл учруулах эсэхийг тодруулна. Хэрэв тийм эрсдэл байгаа бол зээлдэгч нь ханган нийлүүлэлтийн сүлжээний менежментийн системийг бий болгон хэрэгжүүлэх ба энэхүү систем нь эдгээр хангамжийн сүлжээний нөхцөл байдал, төслийн мөн чанар, цар хүрээнд нийцсэн холбогдох байгаль орчин, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд тохирсон байна. Менежментийн систем нь ханган нийлүүлэлтийн сүлжээнд хийсэн үнэлгээ, эсвэл одоо явагдаж буй мониторингийн үр дүнд илрүүлсэн байгаль орчин, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх үйл явцыг тусгах ёстой. Ингэхдээ, (i) зээлдэгч энэ асуудлыг үүсгэсэн, эсвэл үүсгэхэд оролцсон эсэх, (ii) ханган нийлүүлэгчийг хариуцлагатай байлгах зээлдэгчийн чадавхи, (iii) тэдний харилцаа зээлдэгчийн хувьд аль зэрэг чухал болох, (iv) асуудал аль зэрэг хурц болох, (v) ханган

нийлүүлэгчтэй харилцаагаа тасалвал тэр нь ямар сөрөг үр дагавартай байх гэсэн асуудлыг анхааралдаа авах хэрэгтэй. Ханган нийлүүлэтийн сүлжээнд хамааралтай хөдөлмөрийн стандартын шаардлагуудыг ГШ 2-д заасан болно. Байгалийн амьд нөөцийн ханган нийлүүлэх сүлжээний шаардлагуудыг ГШ 6-д дурдав.

Гүйцэтгэлийн мониторинг болон тайлагнах үйл ажиллагаа

24. Зээлдэгч төслийн байгаль орчин, нийгмийн талаар авч буй арга хэмжээнд мониторинг хийнэ. Тус мониторинг нь (i) төсөл ГШ-ын дагуу хэрэгжиж байгаа эсэхийг тодорхойлох, (ii) сургамж авах, нөөц хөрөнгийг хуваарилах, үйл ажиллагааг цаашид сайжруулах боломжуудыг илрүүлэх зорилготой байна.
25. Мониторингийн шаардлагууд нь төслийн мөн чанар, түүний байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлуудад нийцсэн байна. Мониторингоор дараах асуудлуудыг шийдвэрлэнэ. Үүнд:
 - байгаль орчин, нийгмийн үнэлгээний явцад илрүүлсэн байгаль орчин, нийгмийн томоохон үр нөлөө, асуудлууд,
 - төслийн үнэлгээний явц, цаашдын мониторингийн явцад илрүүлсэн ГШ-ын холбогдох шаардлагууд,
 - БОНМТ болон БОНУАТ-нд тодорхойлсон холбогдох арга хэмжээнүүд,
 - ажиллагсад болон хөндлөнгийн оролцогч талуудаас хүлээн авсан гомдлууд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн байдал,
 - хууль тогтоомжийн мониторинг хийх, тайлагнах шаардлагууд,
 - бусад талууд (тухайлбал, бараа худалдан авагч, санхүүжүүлэгч, эсвэл гэрчилгээ олгогч)-аас хүссэн аливаа мониторинг, тайлан багтана.
26. Зээлдэгч нь мониторинг хийх зохих систем, нөөц хөрөнгө, ажиллах хүчнийг бэлэн байлгах ёстой. Зээлдэгч нь мониторингийн үр дүнг хянан үзэж, шаардлагатай тохиолдолд засаж залруулах ажлыг санаачилна. Дээр нь, зээлдэгч бие даасан мэргэжилтэн, орон нутгийн олон нийт, эсвэл иргэний нийгмийн байгууллага зэрэг гуравдагч талуудыг ашиглан, нэмэлт мониторинг хийх буюу өөрийн мониторингийн мэдээллийг шалгуулж болно. Холбогдох эрх бүхий байгууллага, эсвэл гуравдагч тал тодорхой асуудал, нөлөөллийг бууруулах арга хэмжээг хариуцаж буй тохиолдолд зээлдэгч нь тэдгээр байгууллага, гуравдагч талтай дээрх бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, мониторинг хийх талаар хамтран ажиллавал зохино.
27. Зээлдэгч төслийн байгаль орчин, нийгмийн ажиллагааны талаар, түүний дотор ГШ-ыг хангаж байгаа эсэх, БОНМС, БОНМТ, БОНУАТ болон Талуудыг татан оролцуулах төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар ЕСБХБ-нд тогтмол тайлагнана. Мониторингийн үр дүнгээс хамаарч зээлдэгч нь БОНМТ эсвэл БОНУАТ-нд нэмэлт арга хэмжээ оруулах, мөн ЕСБХБ-тай тохиролцсоны үндсэн дээр засаж залруулах буюу урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлон тусгах үүрэгтэй. Зээлдэгч нь Банктай тохиролцсоны дагуу засаж залруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн, үйл ажиллагаагаа сайжруулах эдгээр арга хэмжээг үргэлжүүлэн авна.
28. Зээлдэгч өөрт, эсвэл төсөлд учирсан бөгөөд томоохон сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байгаль орчин, нийгмийн холбогдолтой хэрэг явдал, осол гарсан тохиолдолд ЕСБХБ-нд яаралтай мэдээлэх ёстой.

29. Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн бодит нөлөөлөл үзүүлэхүйц аливаа өөрчлөлт төслийн цар хүрээ, бүтэц, үйл ажиллагаанд орсон тохиолдолд энэ талаар ЕСБХБ-нд яаралтай мэдээлэх ёстой. Үүнтэй холбоотойгоор, зээлдэгч нь ЕСБХБ-тай тохирсны ГШ-тай нийцүүлэн холбогдох нэмэлт үнэлгээ, талуудын оролцоог хангах арга хэмжээг авч энэ талаар БОНМТ болон БОНҮАТ-нд тусгана.
30. Байгаль орчин, нийгмийн томоохон нөлөөлөл, асуудал үүсгэж болзошгүй төслүүдийн хувьд зээлдэгч төслийн бие даасан хяналт шалгалтыг үе үе явуулах, эсвэл байгаль орчин, нийгмийн тодорхой асуудлаар мониторинг хийх хөндлөнгийн мэргэжилтнүүдийг ажиллуулж болно. Энэ ажлын цар хүрээ, мониторинг хийгдсэний дараагаар авах арга хэмжээний асуудлыг тухайн тохиолдол бүрт тодорхойлно.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 2

Хөдөлмөр эрхлэлт ба ажиллах нөхцөл

Танилцуулга

1. Зээлдэгчид болон тэдний бизнесийн үйл ажиллагааны хувьд ажиллах хүчин үнэ цэнэтэй хөрөнгө бөгөөд эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээ хийх эрх зэрэг ажиллагсдын эрхийг хүндэтгэх үндсэн дээр бий болсон хүний нөөцийн сайн менежмент хийгээд ажиллагсад-удирдлага хоорондын харилцаа нь бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг бүрэлдүүлэх гол хүчин зүйл болохыг энэхүү ГШ-нд онцлон авч үзлээ. Ажиллагсад шударгаар хандаж, тэднийг аюулгүй, эрүүл ажлын нөхцлөөр хангаснаар³² зээлдэгчид бодит үр дүнд хүрэх, тухайлбал өөрийн үйл ажиллагааны үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх боломжтой.

Зорилго

2. Энэ ГШ-ын зорилго нь:
 - ажиллагсдын эрх ашиг, үндсэн зарчмуудыг³³ хүндлэн хамгаалах,
 - ажиллагсад шударга хандах, ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш боломж олгох зэрэг ажлын тааламжтай нөхцлийг³⁴ хөхиүлэн дэмжих,
 - ажиллагсад-менежментийн хооронд сайн харилцаа бий болгож, хадгалж, сайжруулах,
 - зээлдэгчийн нэгдэж орсон аливаа хамтын хэлэлцээр, тухайн улс орны хөдөлмөрийн болон ажил эрхлэлтийн тухай хууль тогтоомжуудыг мөрдлөг болгон ажиллахыг дэмжих,
 - ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хамгаалах ялангуяа эрүүл, аюулгүй ажлын нөхцлийг дэмжих,
 - төслийн үйл ажиллагаатай холбоотой албадан хөдөлмөр болон хүүхдийн хөдөлмөр ашиглахаас (Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас тодорхойлсон) урьдчилан сэргийлэх.

Үйлчлэх цар хүрээ

3. Зээлдэгч байгаль орчин, нийгмийн үнэлгээний нэг хэсэг болгон энэхүү ГШ-д орсон холбогдох шаардлагуудыг төсөл хэрэгжүүлэх бүхий л хугацаанд хэрхэн шийдвэрлэх, хангах талаар тодорхойлно. Энэхүү ГШ-ыг хангах шаардлагатай арга хэмжээнүүдийг зээлдэгч байгаль орчин, нийгмийн менежментийн систем болон төслийн онцлогийг тусгасан байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ. Байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон менежментийн шаардлагыг ГШ 1-д тусгасан болно.

³² Хөдөлмөрийн эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааны шаардлагуудыг ГШ 4-д тусгав.

³³ ОУХБ-ын 29, 105 (албадан хөдөлмөр), 87 (эвлэлдэн нэгдэх эрх чөлөө), 98 (хамтын хэлэлцээр хийх эрх), 100 ба 111 (ялгаварлан гадуурхах), 138 (насны доод хязгаар), 182 (хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд) дугаар конвенцууд.

³⁴ Ажлын тааламжтай нөхцөл гэдэгт хүмүүс ажил эрхэлж байхдаа хүсч явдаг хүсэл эрмэлзлийг нэгтгэн ойлгоно. Үүнд, үр бүтээлтэй, зохих ёсны орлого өгсөн ажлын боломж, ажлын байран дахь аюулгүй байдал, гэр бүлийн нийгмийн хамгаалал, хувь хүнийн хөгжил ба нийгэмд нэгдэх илүү сайн нөхцлүүд, хүмүүсийн асуудлаа илэрхийлэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх, амьдралд нөлөөлөх асуудлаар шийдвэр гаргахад оролцох, эмэгтэй, эрэгтэй гэж ялгалгүй боломж, хандлагаар тэгш хангах асуудлууд багтана.

4. Энэхүү ГШ-ын хүрээнд «ажиллагсад» гэж зээлдэгч байгууллагын ажиллагсдыг хэлэх ба үүнд, хагас цагийн, түр болон улирлын чанартай ажиллагсад, мөн шилжин ирсэн ажиллагсад багтана. ГШ-ын гэрээт ажиллагсдад хамаарах асуудлыг §21-23-т, ханган нийлүүлэх сүлжээтэй холбоотой хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг §24-26-д тус тус оруулав.

Шаардлага

Ерөнхий зүйл

5. Төслүүд нь (i) тухайн улс орны хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны тухай хууль тогтоомжууд болон (ii) ОУХБ-ын конвенциудад³⁵ заасан үндсэн зарчим болон стандартыг дагаж мөрдөх шаардлагатай.

Ажиллагсдын харилцааны менежмент

Хүний нөөцийн бодлого

6. Зээлдэгч тухайн улс орны хууль тогтоомж болон энэхүү ГШ-ын шаардлагын дагуу ажиллах хүчийг удирдах, зохион байгуулах арга барилыг тодорхойлохдоо өөрийн байгууллагын хэмжээ болон ажиллах хүчинд нийцсэн хүний нөөцийн бодлого, удирдлагын систем, журмыг баталж мөрдөнө. Эдгээр бодлого, журам нь ойлгомжтой, ажиллагсдад хүртээмжтэй байх ба ажиллах хүчний ярьдаг хэл дээр байна.

Ажлын харилцаа

7. Зээлдэгч тухайн улс орны ажил эрхлэлт, хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хамтын гэрээний дагуу ажиллагсдын эдлэх эрх, ажиллах нөхцөл болон ажил эрхлэлттэй холбоотой нөхцөлүүд үүний дотор, цалин, ажиллах цаг, илүү цаг, илүү цагийн нөхөн олговор, аливаа хөнгөлөлт (өвчний чөлөө, эх/эцэг болсны чөлөө буюу нийтийн баяр ёслол) мөн ямар нэгэн баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдол зэргийг бүх ажиллагсдад баримтжуулж хүргүүлнэ. Энэхүү мэдээлэл нь ойлгомжтой, ажиллагсдад хүртээмжтэй байх ба ажиллах хүчний ярьдаг хэл дээр байна. Хүний нөөцийн удирдлагын систем нь хувийн мэдээллийн нууцыг хадгалан хамгаалж ажиллагсдын эрхийг хүндэтгэнэ.
8. Ажиллагсдыг мэдээллээр хангахдаа (i) ажиллах хүчинд нөлөө үзүүлж болох аливаа өөрчлөлтийн талаар бүрэн мэдээлэл өгсөн байх, (ii) ажил сайжруулахад чиглэсэн санал шүүмжлэл гаргах боломж, түүний дотор §20-д заасан санал, гомдол гаргах боломжоор хангасан байна.

Хүүхдийн хөдөлмөр

9. Зээлдэгч насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хүүхдийг дээд зэргээр хамгаалсан үндэсний холбогдох хууль тогтоомж, олон улсын хөдөлмөрийн стандартыг дагаж мөрдөнө.
10. Зээлдэгч эдийн засгийн мөлжлөгийн чанартай, эсвэл аюултай байж болох, эсвэл хүүхдийн боловсролд сөргөөр нөлөөлөх, эсвэл хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, сэтгэц, оюун санаа, ёс суртахуун болон нийгмийн хөгжилд нь хортой байж болох ажилд хүүхдийг авахгүй. Зээлдэгчээс тогтоосон 18 наснаас доош насны залуу

³⁵Дээрх 33 дугаар зүйлийг үзнэ үү.

хүмүүсийг аюултай байж болох ажилд авахгүй бөгөөд 18 наснаас доош насны хүмүүсийн гүйцэтгэх бүх ажлын зохих эрсдэлийн үнэлгээг хийх ба эрүүл мэнд, ажлын цаг, ажиллах нөхцөл байдалд нь тогтмол мониторинг хийнэ.

Албадан хөдөлмөр

11. Зээлдэгч шийтгэл эсвэл сүрдүүлэлтийн дор хувь хүнээс аливаа сайн дурын бус ажил, үйлчилгээ буюу албадан хөдөлмөр ашиглахыг хориглоно. Үүнд, гэрээлэгдсэн хөдөлмөр, боолын хөдөлмөр, ижил төрлийн зохицуулалт хийсэн хөдөлмөр буюу хүний наймаанд өртсөн хүн³⁶ зэрэг сайн дурын бус, албадлагын хөдөлмөр ордог.

Үл ялгаварлан гадуурхах ба ижил боломж олгох

12. Төслүүд ажил эрхлэлттэй холбоотой ялгаварлан гадуурхахгүй байх шаардлагуудыг хангасан байна. Тухайлбал төсөлтэй холбоотойгоор зээлдэгч нь:
- ажлын зайлшгүй шаардлагад хамаагүй хүйс, арьс өнгө, яс үндэс, улс төрийн үзэл бодол, аливаа эвлэл холбооны гишүүнчлэл, гарал үүсэл, шашин шүтлэг, хөгжлийн хязгаардмал байдал, нас эсвэл бэлгийн чиг хандлага зэрэг хувь хүний шинж чанараас шалтгаалан ажилд авах эсэх шийдвэр гаргахгүй байх,
 - тэгш байдал ба шударга хандлагын зарчимд үндэслэсэн ажил эрхлэлтийг дэмжих, ажил эрхлэлтийн харилцааны бүх асуудлаар ялгаварлан гадуурхахгүй байх, үүнд ажилд авах, ажлын даалгавар, нөхөн олговор олгох (цалин, урамшууллыг оролцуулан)³⁷, ажлын байрны болон ажил эрхлэлтийн нөхцөл, сургалтанд хамруулах боломж, албан тушаал дэвших, ажил эрхлэлтийг дуусгавар болгох эсвэл тэтгэвэрт гарах, мөн сахилга батын асуудал зэрэг орно,
 - дарамт, түүний дотор бэлгийн дарамт, хууран мэхлэлт, айлган сүрдүүлэлт болон/эсвэл мөлжлөг зэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авах шаардлагатай.

Дараах арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй. Үүнд, өнгөрсөн хугацаанд явагдсан ялгаварлан гадуурхлыг арилгах буюу засаж залруулахад туслах тусгай арга хэмжээ, орон нутгийн ажил эрхлэх боломжийг дэмжих, болон тухайн улс орны хууль тогтоомжийн дагуу ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн тодорхой ажилд сонгон шалгаруулалт хийх асуудлууд орно.

Ажиллагсдын байгууллагууд

13. Зээлдэгч ажиллагсдын өөрсдийн төлөөлөгчдийг сонгох, хүссэн байгууллагаа байгуулах, эсвэл өөрсдийн сонгосон байгууллагад нэгдэх, болон хамтын хэлэлцээ хийх зэрэгт ажиллагсдад саад хийхгүй байвал зохино. Зээлдэгч тэдгээр байгууллагад буюу хамтын хэлэлцээнд төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэж байгаа, оролцож байгаа, эсвэл оролцох хүсэлтэй ажиллагсдыг ялгаварлан гадуурхахгүй буюу тэдний эсрэг арга хэмжээ авахгүй байх хэрэгтэй. Тухайн улс орны хуулийн дагуу зээлдэгч тэдгээр ажиллагсдын төлөөлөгчид буюу байгууллагуудтай хамтран ажиллаж, үр дүнтэй хэлэлцээ хийхэд шаардлагатай мэдээллийг цаг хугацаанд нь гарган өгч байна. Хэрэв тухайн улс орны хууль ажиллагсдын байгууллагыг

³⁶ Хүний хулгай гэж заналхийлэх, хүч хэрэглэх зэрэг хүч тулгасан, хулгайн замаар, хууран мэхлэх, эрх мэдлээ ашиглах, эмзэг байдлыг нь ашиглах зэрэг аргаар хүмүүсийг элсүүлэх, тээвэрлэх, шилжүүлэх, нуун дарагдуулах, хүлээн авах, эсвэл мөлжих зорилгоор бусдад төлбөр төлж өөр хүнийг эрх мэдэлдээ оруулах зэрэг үйлдлийг хэлнэ.

³⁷ Зээлдэгч нь ижил үнэлгээтэй ажилд ижил цалин хөлс олгох зарчмыг баримтална.

байгуулах, ажиллуулах явдлыг үлэмж хязгаарлаж байвал зээлдэгч байгууллагын хэмжээ, ажиллах хүчинд зохицсон ажлын болон ажил эрхлэлтийн нөхцлийн талаар ажиллагсдыг санал, гомдлоо илэрхийлэх, эрхээ хамгаалах бие даасан үйл ажиллагааг бий болгоно.

Цалин, урамшуулал ба ажлын нөхцөл

14. Санал болгож буй цалин, урамшуулал (ажлын цагыг оруулан), ажлын нөхцөл нь тухайн холбогдох улс/бүс нутаг болон салбарын бусад ажил олгогчдын санал болгож буй нөхцөлтэй ойролцоо байвал зохино.
15. Зээлдэгч хамтын хэлэлцээний гэрээний нэг тал эсвэл ямар нэгэн үүрэг хүлээсэн бол тэр гэрээг хүндэтгэн үзэх ёстой. Хэрэв энэ төрлийн гэрээ байгуулаагүй, эсвэл уг гэрээнд ажлын байрны болон ажил эрхлэлтийн нөхцлийн асуудлыг тусгаагүй тохиолдолд зээлдэгч шаардлагатай ажлын байрны болон ажил эрхлэлтийн нөхцлөөр хангаж өгнө.
16. Зээлдэгч нь шилжин ирсэн ажиллагсдыг бүртгэн ижил төрлийн ажил эрхэлж байгаа суурин ажиллагсадтай ижил төстэй нөхцлөөр ажиллах боломжоор хангаж өгнө.

Хөдөлмөрийн эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа (ХЭМАА)

17. Зээлдэгч ажиллагсдыг аюулгүй, эрүүл ажлын орчин нөхцлөөр ханган төслийн хувьд ГШ 4-д заасан шаардлагуудыг даган биелүүлнэ.

Ажиллагсдын орон байр

18. Зээлдэгч ажиллагсдаа орон байраар хангах бол тухайн байр нь тохиромжтой байршилтай, цэвэр, аюулгүй байх ба ажиллагсдын наад захын үндсэн хэрэгцээг хангасан байна. Тухайлбал, уг байр нь тухайн салбарын олон улсын сайн туршлагыг³⁸ хангасан байна. Ажил олгогчийн олгосон байранд ажиллагсдын чөлөөтэй орох, гарах эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлаж болохгүй.

Ажлын байрны цомхотгол

19. Зээлдэгч төсөлтэй холбоотойгоор ажиллагсдыг олноор нь ажлаас халах³⁹ шаардлага үүссэн тохиолдолд ажлын байрны цомхотголыг хэрхэн явуулах хувилбаруудыг авч үзэн дүн шинжилгээ хийнэ. Дүн шинжилгээгээр ажлын байрыг цомхотгох оновчтой хувилбарыг тодорхойлоход хүндрэлтэй байвал зээлдэгч нь тухайн улс орны хууль, тогтоомж болон салбарын олон улсын сайн туршлагад нийцсэн үл ялгаварлан гадуурхах ба харилцан зөвшилцөх зарчимд үндэслэн ажиллагсдад гарч болох цомхотголын сөрөг нөлөөг үнэлэх, багасгах, бууруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. Цомхотголд орох ажиллагсдыг тодорхойлох үйл явц нь шударга, бодитой, тууштай хэрэгжүүлэх шалгууруудын үндсэн дээр ил тод байх бөгөөд санал гомдлын үр дүнтэй механизмыг санал болгосон байна. Зээлдэгч ажил эрхлэлтийн нөхцөлд орсон өөрчлөлтийн талаар үйлдвэрчний эвлэл (тийм байгууллага байгаа бол), ажиллагсад, тэдний төлөөлөгчид, шаардлагатай бол холбогдох төрийн эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ. Энэхүү зөвшилцөх арга хэмжээ нь ажлаа алдаж буй ажиллагсдад учрах

³⁸ "Ажиллагсдын орон байр: үйл явц ба стандарт" ЕСБХБ/ОУСК-ийн удирдамж, 2009.

³⁹ Олноор нь ажлаас халах талаар ЕХ-ны 98/59-р удирдамжаас харна уу.

сөрөг нөлөөг багасгах, бууруулах зорилготой юм. Ийм зөвшилцөх ажиллагааны үр дүнг ажлын байрны цомхотголын эцсийн төлөвлөгөөнд тусгана. Төлвөл зохих цалингийн үлдэгдэл, нийгмийн даатгал, тэтгэврийн даатгалын төлбөрийг (i) ажлын харилцааг дуусгавар болгосон өдөр буюу өмнө нь хийсэн байх, (ii) боломжтой бол тухайн ажилтантай тохиролцсон үед, (iii) хамтын хэлэлцээрт заасан хугацааны дагуу хийнэ.

Санал гомдлын механизм

Зээлдэгч ажлын байртай холбоотой асуудлыг шийдвэрлэх үүднээс санал гомдлын үр дүнтэй механизмыг ажиллагсад (болон хэрэв байгаа бол ажиллагсдын байгууллагад) зориулан бий болгосон байна. Зээлдэгч ажиллагсад санал гомдлын механизмын талаар ажилд орох үед нь танилцуулж, ажиллагсад энэхүү механизмаар дамжуулан санал, гомдлоо гаргахад хөнгөн, хүртээмжтэй байхаар зохион байгуулна. Тус механизм нь зохих түвшинд саналыг хариуцан зохицуулах эзэнтэй, санал гомдлыг шуурхай шийдвэрлэдэг, ойлгомжтой, ил тод үйл явцтай байх бөгөөд ямар нэг хариу шийтгэл оногдуулахгүйгээр цаг тухай бүрд нь хариу өгнө. Энэхүү механизм нь гомдлоо нууцаар гаргах, шийдвэрлүүлэх боломжийг олгосон байна. Тус үйл ажиллагаа нь хуулийн дагуу эсвэл одоо байгаа арбитрын шүүх, эвлэрүүлэн зуучлах журмаар батлагдсан захиргааны арга хэмжээ болон бусад шүүхийн шийдвэрт саад учруулахгүй байхаас гадна тухайн механизмыг хамтын гэрээ, ажиллагсдын үйлдвэрчний эвлэлээс бий болгосон санал гомдлын механизмаар орлуулж болно.

Гэрээт ажиллагсад

21. Хэрэв гэрээт гүйцэтгэгч болон бусад зуучлагчаар дамжуулан зээлдэгч нь төслийн талбай буюу төслийн гол ажиллагаатай шууд холбоотой ажил гүйцэтгүүлэхээр ажиллагсад авч ажиллуулж байгаа тохиолдолд (i) эдгээр гэрээт гүйцэтгэгч болон зуучлагч нь нэр хүндтэй, хууль ёсны этгээд болохыг магадлах, (ii) эдгээр гэрээт гүйцэтгэгч, зуучлагчаас дээрх §6-18 ба §20 дугаар зүйлд заасан шаардлагыг биелүүлэхийг шаардах хэрэгтэй. Хэрэв зээлдэгч гэрээт ажиллагсадтай шууд гэрээлж ажиллах бол зээлдэгч нь дээрх §6-18 ба §20 дугаар зүйлд тусгасан шаардлагуудыг дагаж мөрдөнө.
22. ГШ 1-д заасны дагуу зээлдэгч нь гуравдагч этгээдийн ажлыг хянан зохицуулахдаа төсөл болон энэхүү заалттай уялдуулан бодлого, журам гаргана. Мөн зээлдэгч гуравдагч этгээдийн ажил олгогчтой хийх гэрээнд дээрх шаардлагуудыг тусгаж хэрэглэх тал дээр анхааран ажиллаж шаардлагатай тохиолдолд гэрээний менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
23. Зээлдэгч нь гэрээт ажиллагсадтай холбоотой эрсдэлүүдийг тодорхойлох шаардлагатай. Зээлдэгч нь гэрээт ажиллагсад ГШ 2-ыг хангасан санал гомдлын үр дүнтэй механизмыг ашиглах боломжоор хангана. Гуравдагч этгээд санал гомдол гаргах механизмыг бүрдүүлж чадахгүй бол зээлдэгч гуравдагч этгээдээр дамжуулан ажиллаж буй ажиллагсад зориулсан санал гомдлын үр дүнтэй механизмыг бүрдүүлж өгнө.

Ханган нийлүүлэлтийн сүлжээ

24. ГШ 1-д заасан ханган нийлүүлэлтийн ажиллагааг үнэлгэх явцад зээлдэгч нь төслийн гол үйл ажиллагаанд (гол ханган нийлүүлэлтийн сүлжээ) чухал байгаа бараа, материалын ханган нийлүүлэлтийн сүлжээний үйл ажиллагаанд хүүхдийн

хөдөлмөр болон албадан хөдөлмөр⁴⁰ хийлгэхтэй холбоотой гарах эрсдэлийг тодорхойлж үнэлсэн байна.

25. Хэрэв зээлдэгч гол ханган нийлүүлэлтийн сүлжээнд ОУХБ-ын стандартыг зөрчсөн албадан буюу хүүхдийн хөдөлмөр оролцсон байгааг олж тогтоосон тохиолдолд доорх шаардлагуудын дагуу тухайн зөрчлийг арилгах тохирсон арга хэмжээ авна. Үүнд:

- хэрэв хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зөрчил илэрвэл сайн санааны үүднээс засах буюу бууруулах арга хэмжээ авна. Зээлдэгч дээрх зөрчлийг арилгахад анхаарч авсан арга хэмжээний баталгаа хуудас, эсвэл олон улсын сайн туршлагын хүрээнд дээрх зөрчлийг арилгах хөтөлбөр хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа нотолгоог тухайн ханган нийлүүлэгчээс авсан тохиолдолд л тэрхүү нийлүүлэгчээс үргэлжлүүлэн бараа материал худалдан авна. Түүнчлэн, зээлдэгч дээрх хөтөлбөрийн хэрэгжилтийг тухай бүрт нь тайлагнаж мэдээлэх,
- албадан хөдөлмөр хийлгэхтэй холбоотой зөрчил илэрсэн тохиолдолд зээлдэгч албадан хөдөлмөрийг бий болгож буй нөхцлийг арилгах тал дээр хангалттай арга хэмжээ авч байгааг нотолсон баримт хүлээн авсан тохиолдолд л бараа материал авах,
- хүүхдийн хөдөлмөр болон/эсвэл албадан хөдөлмөр хийлгэхтэй холбоотой эрсдэл байгаа тохиолдолд, зээлдэгч гол ханган нийлүүлэлтийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн хянах ба дээрх төрлийн эрсдэл, тохиолдлыг тодорхойлох тал дээр анхаарч ажиллах арга хэмжээнүүд багтана.

Мөн, гол ханган нийлүүлэлтийн үйл ажиллагаанд ажиллагсдын хөдөлмөр хамгаалалтай холбоотой асуудал үүссэн тохиолдолд зээлдэгч холбогдох ханган нийлүүлэгчид дээрх нөхцөл байдлыг арилгах арга хэмжээ авч байгаа эсэхийг тодорхойлох журам болон тухайн нөхцлийг сайжруулах арга хэмжээг танилцуулна.

26. Зээлдэгчийн дээрх эрсдэлүүдийг бүрэн тодорхойлох чадавхи нь гол ханган нийлүүлэгчдийг хэр хэмжээнд зохицуулж байгаа эсвэл тэдэнд хэр нөлөөлж байгаагаас шалтгаална. Зээлдэгч шаардлага хангаагүй гол ханган нийлүүлэлтийн үйл ажиллагааг тохиролцсон тодорхой хугацааны дотор энэхүү ГШ-ыг хангаж байгаагаа нотолсон бусад нийлүүлэгчдэд шилжүүлнэ.

Хамгаалалтын ажиллагсдад тавих шаардлагууд

27. Зээлдэгч өөрийн ажилтан болон эд хөрөнгийг хамгаалуулахаар ажилтан эсвэл гэрээт байгууллагыг ажиллуулахдаа ажилттан авч ажиллуулах, биеэ авч явах, сургах, техник хэрэгслээр хангах, хянаж шалгахтай холбогдуулан тэнцүү чанарын зарчим болон олон улсын сайн туршлагыг⁴¹ баримталсан хамгаалалтын албаны практик, биеэ авч явах стандартын талаар тохиролцоно. Зээлдэгч нь тухайн хамгаалалтын албаныхан ямар нэгэн өмнөх зөрчилгүй, хүч (шаардлагатай бол галт зэвсэг) хэрэглэх талаар зохих түвшинд бэлтгэгдсэн, ажиллагсад болон тухайн орон нутгийнхантай зөв харьцдаг эсэхийг сайтар судалж, тухайн албаны хүмүүсээс хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг шаардаж ажиллана. Зээлдэгч тухайн аюул заналын мөн чанар, цар хүрээнд тохирсон урьдчилан сэргийлэх болон хамгаалах зорилготойгоос бусад тохиолдолд ямар нэгэн хүч

⁴⁰ ОУХБ-ын 138, 182, 29, 105 дугаар конвенцуудад тодорхойлсон.

⁴¹ Жишээ нь, *Аюулгүй байдал, хүний эрхийн сайн дурын зарчмууд*.

хэрэглэх зөвшөөрөл өгөхгүй. Зээлдэгч энэхүү ГШ болон ГШ 10-д заасны дагуу тухайн орон нутгийн олон нийт болон ажиллагсдын зүгээс ирэх хамгаалалтын үйлчилгээтэй холбоотой санал гомдлыг хүлээн авах үр дүнтэй механизмыг бий болгож, тухайн орон нутгийн олон нийт болон ажиллагсдад санал гомдлын механизм байгаа тухай болон түүнийг хэрхэн ашиглаж харилцах талаар мэдээлнэ.

28. Төрийн хамгаалалтын албаны ажилтнууд хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхээр дайчлагдсан тохиолдолд зээлдэгч энэ төрлийн хамгаалалтын үйл ажиллагаанаас үүсч болох эрсдэлийг тодорхойлон дүгнэлт хийж, орон нутгийн засаг захиргаатай холбогдон тухайн хамгаалалтын ажилтнууд дээрх §27 дугаар зүйлд заасан журмын дагуу ажиллах шаардлагатай талаар мэдэгдэх ба зээлдэгчийн барилга, байгууламжийг хамгаалах тухай аюулгүйн ажиллагааны нөхцөл байдлаас хамааран олон нийтэд танилцуулахыг төрийн холбогдох байгууллагаас хүснэ.
29. Зээлдэгч хамгаалалтын ажилтны гаргасан хууль бус эсвэл хохиролтой үйлдэлтэй холбоотой гомдлыг судалж, давтагдуулахгүй байх талаар арга хэмжээ авах (эсвэл арга хэмжээ авахыг холбогдох талаас шаардах), хууль бус болон хохирол учруулсан үйлдлийн талаар төрийн байгууллагад мэдээлэх шаардлагатай.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 3

Нөөцийн үр ашигтай хэрэглээ, бохирдлоос сэргийлэх ба хянах

Танилцуулга

1. Энэхүү ГШ нь эдийн засгийн өсөлт болон хотжилт нь агаар, ус, хөрсний бохирдлын хэмжээг нэмэгдүүлж байгаагийн дээр хязгаарлагдмал нөөцийг ашигласнаар орон нутаг, бүс болон дэлхийн хэмжээнд ард иргэд болоод байгаль орчинд хохирол учруулж болзошгүй болохыг онцолж байна. Иймд нөөцийн зөв ашиглалт, бохирдлоос хамгаалах болон хянах нь байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын чухал хэсэг бөгөөд төслүүд үүнтэй холбоотойгоор олон улсын сайн туршлагад нийцсэн үйл ажиллагаа явуулах нь зүйтэй.
2. Энэхүү ГШ нь нөөцийг зохистой ашиглах, бохирдлыг хянах зорилгоор боломжит арга аргачлал, олон улсын сайн туршлагыг ашиглах нь чухал болохыг онцолж байна.
3. Энэхүү ГШ нь нөөцийн менежмент, бохирдлоос сэргийлэх, хянах, нөлөөллийг шат дараатайгаар бууруулах, байгаль орчинд учруулсан аливаа хохирлыг "бохирдуулагч нь төлөх" зарчим, арга аргачлалыг төслийн түвшинд ашиглах нь чухал болохыг онцолж байна. Төслийн нөөц ашиглалт, хаягдал, бохирдол ялгаруулахтай холбоотой нөлөөллийг тухайн төслийн байршил болон орон нутгийн байгаль орчны нөхцөлтэй уялдуулан үнэлэх нь зүйтэй.

Зорилго

4. Энэхүү ГШ-ын зорилго нь:
 - төслийн үйл ажиллагааны хүрээнд эрчим хүч, ус болон нөөц ашиглалтыг сайжруулах, хаягдлын менежменттэй холбоотой боломжуудыг тодорхойлох,
 - төслийн үйл ажиллагааны хүрээнд нөөц ашиглалт болон бохирдлын улмаас бий болсон хүний эрүүл мэнд, байгаль орчинтой холбоотой асуудлуудад хор хөнөөлийг арилгах бодлого баримтлах,
 - төсөлтэй холбоотой хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах арга хэмжээг дэмжих асуудал болно.

Үйлчлэх хүрээ

5. Зээлдэгч өөрийн байгаль орчин, нийгмийн үнэлгээний ажлын хүрээнд мөрдөх шаардлагатай энэхүү ГШ-ын холбогдох шаардлагуудыг тодорхойлж улмаар тэдгээрийг төслийн хэрэгжилтийн хугацаанд хэрхэн биелүүлж, хэрэгжүүлэх талаар зааж өгнө. Энэхүү ГШ-тай нийцүүлэхээр тодорхойлсон арга хэмжээг зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн менежментийн систем болон тухайн төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлнэ.

Шаардлага

Нөөцийн зохистой ашиглалт

6. Байгаль орчин, нийгмийн үнэлгээний хүрээнд олон улсын сайн туршлагатай уялдуулан төсөлтэй холбоотойгоор нөөцийг үр ашигтай ашиглах боломж,

хувилбаруудыг тодорхойлно. Ингэснээр үйлчлүүлэгч нь өөрийн эрчим хүч, ус болон бусад нөөц, материалын хэрэглээг багасгах, сайжруулах, мөн төслийг хэрэгжүүлэх явцад гарсан хаягдал материалыг сэргээх, дахин ашиглах тал дээр техникийн болоод санхүүгийн хувьд боломжтой⁴², зардлын үр ашигтай⁴³ арга хэмжээг авна. Төслийн гол үйл ажиллагаа болон зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаанд дээрхтэй ижил боломжуудыг мөн авч үзнэ. Жишиж болохуйц мэдээлэл байгаа тохиолдолд зээлдэгч нь өөрийн үйл ажиллагааг олон улсын сайн туршлагатай харьцуулан үнэлж ижил түвшний бүтээмжийг бий болгоно.

7. Зээлдэгч нь бүтээгдэхүүний загварыг боловсруулах болон үйлдвэрлэх явцад нөөцийг зөв зохистой ашиглах арга хэмжээ, цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх зарчмыг үйл ажиллагаандаа тусгаж түүхий эд, эрчим хүч, ус хэмнэх болон байгаль орчинд ялгарч буй бохирдлыг багасгах зорилттойгоор ажиллана.

Бохирдлоос сэргийлэх, хянах

8. Зээлдэгч нь төслийн байгаль орчин, нийгмийн үнэлгээг гүйцэтгэх явцад төсөлд авч хэрэгжүүлэх бохирдлоос сэргийлэх болон хянах тохиромжтой арга, технологийг тодорхойлно. Энэхүү үнэлгээ нь төслийн бүрэлдэхүүнд багтаж буй байгууламж, үйл ажиллагааны онцлогыг анхааран үзэх ба мөн төслийн газар зүйн байрлал, орон нутгийн байгаль орчны нөхцөл байдлыг харгалзан үзнэ. Түүнчлэн, тус үнэлгээгээр хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах эсвэл зайлсхийхэд хамгийн тохирсон техникийн болон санхүүгийн хувьд хэмнэлттэй бохирдлоос сэргийлэх, хянах арга, техникийг тодорхойлно. Тэдгээр арга, техник нь эрсдэлийг бууруулах, эсвэл эрсдэлээс зайлсхийх боломжийг бүрдүүлсэн байх шаардлагатай ба олон улсын сайн туршлагад тулгуурласан, мөн төслийн сөрөг нөлөөлөл, асуудлын мөн чанар, цар хүрээнд тохирсон байвал зохистой.
9. Зээлдэгч нь төслийн түвшинд⁴⁴ дагаж мөрдөж болохуйц ЕХ-ны холбогдох байгаль орчны стандартыг хангасан байхаар төслийг төлөвлөж боловсруулсан байна. Зарим төслүүд шинж чанар, цар хүрээнээсээ хамааран ЕХ-ны үйлдвэрийн хаягдлын талаарх журмыг дагах шаардлагатай ба төслийн байршлаас үл хамааран ЕХ-ны Хамгийн сайн боломжит техник (ХСБТ), мөн бохирдол ялгаруулах, хаях тухай бусад стандартыг хангасан байх шаардлагатай.

⁴² Техникийн хувьд боломжтой гэдэг нь тухайн санал болгосон арга хэмжээнүүдийг байгаа чадвар, тоног төхөөрөмж, материалыг ашиглан хэрэгжүүлж болох тухай юм. Ингэхдээ уур амьсгал, газар зүй, дэд бүтэц, аюулгүй байдал, засаглал, чадавхи, ажиллагааны найдвартай байдал зэрэг орон нутгийн хүчин зүйлсийг бодолцох ёстой. Санхүүгийн хувьд боломжтой гэдэг нь арилжааны хүчин зүйлс, тухайлбал тийм арга хэмжээнүүд авснаар төслийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны болон урсгал зардалтай харьцуулахад үүсч болох нэмэгдэл зардлын харьцангуй хэмжээ зэргийг тооцох тухай болно.

⁴³ Зардлын үр ашиг гэдгийг тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааны туршид гарах үндсэн хөрөнгө болон үйл ажиллагааны зардал, санхүүгийн үр ашиг дээр үндэслэн тодорхойлно. Энэхүү ГШ-ын утгаар, төсөлтэй харьцуулахад хөрөнгө оруулалтын эрсдэлийг тооцсон өгөөжөө өгөхөөр байвал нөөцийн үр ашиг буюу хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгах арга хэмжээг зардлын хувьд үр ашигтай гэж тооцно.

⁴⁴ Энэхүү ГШ-ын хувьд, ЕХ-ны 2 дахь шатны эрх зүйн баримт бичигт төслийн түвшинд (тухайлбал, хүрээлэн буй орчинтой харьцуулсан) хэрэгжүүлэх тоон болоод чанарын тодорхой шаардлагууд орсон байвал ЕХ-ны байгаль орчны стандартуудыг тухайн төслийн түвшинд ашиглаж болно.

10. Төслийн түвшинд дагаж мөрдөх шаардлагатай ЕХ-ны аливаа байгаль орчны стандарт байхгүй байгаа тохиолдолд зээлдэгч нь ЕСБХБ-тай зөвшилцсөний үндсэн дээр олон улсын сайн туршлагатай уялдуулан холбогдох бусад байгаль орчны стандартыг сонгон төслийн үйл ажиллагаанд мөрдөж болно. Үүнээс гадна, төслийг холбогдох тухайн улс орны хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулах ба төсөл нь дотоодын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна. Төсөл хэрэгжиж буй орны хууль, журам нь ЕХ-ны байгаль орчны дүрэм болон бусад холбогдох журамд тогтоосон шаардлага, хэм хэмжээнээс өөр байвал эдгээрээс хамгийн хатуу, чанга шаардлагатайг нь баримтална.
11. Төслийн хүрээнд шинэ барилга байгууламж, үйл ажиллагаа нэмэгдэж байгаа тохиолдолд төслүүд нь мөн ЕХ-ны байгаль орчны стандартууд, эсвэл дагаж мөрдөхөөр тохиролцсон бусад болон тухайн улс орны байгаль орчны стандартад нийцсэн байх шаардлагатай. Одоо байгаа барилга байгууламж ба/буюу үйл ажиллагааг сэргээн сайжруулж байгаа төслүүд тодорхой хугацааны туршид энэхүү ГШ-ын 9, ба/буюу 10-р заалтыг хангасан байх шаардлагатай ба төслийн үйл ажиллагаа холбогдох стандартад нийцэж байгаа эсэхийг албан ёсны үнэлгээгээр тодорхойлно.
12. ЕХ-ны гишүүн орнууд, ЕХ-нд нэгдэхээр төлөвлөж буй, ЕХ-нд нэгдэж болзошгүй улс орны нутаг дэвсгэрт байрлаж буй одоо байгаа барилга байгууламж ба/буюу үйл ажиллагааг сэргээн сайжруулж буй төслүүдийн хувьд ЕХ-ны холбогдох байгаль орчны стандартуудыг дагаж мөрдөхөөр тохиролцсон бол эдгээр стандартыг хэрэгжүүлэх цаг хугацаа нь тухайн улсын зүгээс зөвшөөрсөн цаг хугацааг мөн тооцон үзнэ. Бусад бүх улс оронд хэрэгжиж буй төслүүдийн хувьд, ЕХ-ны байгаль орчны стандартуудыг хэрэгжүүлэх цаг хугацаа нь орон нутгийн нөхцөл, авч хэрэгжүүлэх зардал зэргийг тооцон улмаар Европын хөршийн бодлого, ЕХ болон төсөл хэрэгжиж буй холбогдох улс хоорондын тохиролцсон хоёр талын гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нийцсэн байх шаардлагатай.
13. Төслийг хэрэгжүүлэх бүхий л хугацааны туршид, зээлдэгч нь техникийн болон санхүүгийн хувьд боломжтой, үр ашигтай байдлаа хадгалахын зэрэгцээ хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг үр дагаварыг нөлөөллийг шат дараатайгаар бууруулах аргаар багасган, бохирдлыг бууруулж, хянах арга техникийг ашиглана. Энэ нь ердийн, ердийн бус, эсвэл санамсаргүй нөхцөл байдлын улмаас үүссэн бохирдолтын асуудалд мөн хамаарна.

Хүлэмжийн хий

14. Зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийх үйл явц нь төслийг боловсруулж, хэрэгжүүлэх явцтай холбоотой хүлэмжийн хийн (ХҮХ) ялгаралтаас зайлсхийх, бууруулах үүднээс техникийн хувьд боломжтой, санхүүгийн үр ашигтай хувилбаруудыг анхааран авч үзнэ. Эдгээр хувилбарууд нь төсөл хэрэгжих өөр байршил, арга, техник, үйл явц болоод сэргээгдэх эрчим хүч, эсвэл хүлэмжийн хий бага ялгаруулдаг эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах, тогтвортой хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон мал аж ахуйн менежментийн туршлага, дэгдэмхий хийг бууруулах, хийн шаталтыг бууруулах зэрэг арга хэмжээ байж болох ба эдгээрээр мөн хязгаарлагдахгүй болно.
15. Одоогийн байдлаар жилд 25,000 тонноос их CO₂ ялгаруулж байгаа эсвэл ийм хэмжээний хий ялгаруулах хөрөнгө оруулалт шаардаж болзошгүй төслийн хувьд зээлдэгч тэдгээр ялгаралтыг ЕСБХБ-ны Хүлэмжийн хий ялгаруулалтын үнэлгээний

аргачлалын дагуу тооцоолно. ХүХ-н үнэлгээний хамрах хүрээ нь төслийн эсвэл системийн нэгжийн бүх тоног төхөөрөмж, үйл ажиллагаанаас ялгарч буй төслийн ашиглаж байгаа эрчим хүчний үйлдвэрлэлийг авч үзнэ. ХүХ-н ялгаралтын хэмжээг тооцох ажлыг жил бүр зээлдэгч хийх ба ЕСБХБ-д тайлагнана.

Ус

16. Зээлдэгчид төслийн усны хэрэглээг багасгах арга замыг эрэлхийлэх шаардлагатай ба хэрэв тухайн төсөлд зориулсан усан хангамжийг бий болгох хэрэгцээ үүссэн тохиолдолд зээлдэгч нь аль болох ундны хэрэгцээнд тохиромжгүй, техникийн зориулалтаар ашиглаж болохуйц усыг ашиглах боломжийг эрэлхийлэх нь зүйтэй.
17. Олон улсын сайн туршлагад заасны дагуу ус багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах техникийн болон санхүүгийн хувьд боломжтой, үр ашигтай хувилбаруудыг төслийг боловсруулах явцад тооцон үзнэ.
18. Ус их ашиглах (өдөрт 5000 шоо метрээс их) төслийн хувьд дараах арга хэмжээг авна. Үүнд:
 - усыг тогтвортой ашиглах хувилбарыг нарийвчлан боловсруулж төслийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ЕСБХБ-д жил бүр тайлагнах,
 - усыг үр ашигтай ашиглах боломжийг тасралтгүй эрэлхийлэх,
 - тусгай зориулалтаар ашиглаж буй ус ашиглалтыг үнэлдэг байх (нэгж үйлдвэрлэл тутам ашиглах усны эзлэхүүнээр хэмжигдсэн),
 - ус ашиглалтын стандартыг жишиг болгож үйл ажиллагаа явуулах.
19. Зээлдэгч нь гуравдагч талын ус ашиглагчид болон орон нутгийн экосистемтэй холбоотойгоор хуримтлагдах нөлөөлөл үүсч болзошгүйг анхааралдаа авах шаардлагатай. Шаардлагатай тохиолдолд зээлдэгч өөрийнх нь үйл ажиллагааны зүгээс усан хангамжид үзүүлэх нөлөөллийг үнэлэн гуравдагч этгээдэд тайлагнах ба зээлдэгчийн ашиглаж буй усны хэмжээ, технологи нь гуравдагч этгээдийн болон экосистемийн усны нөөцөд сөргөөр нөлөөлөхгүй талаар таниулан ойлгуулах шаардлага үүснэ. Байгаль орчны үнэлгээний хүрээнд зээлдэгч нь нөлөөллийг шат дараатайгаар бууруулах аргачлал болон олон улсын сайн туршлагатай уялдуулан нөлөөллийг багасгах, бууруулахаас илүүтэйгээр нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хаягдал⁴⁵

20. Зээлдэгч нь аюултай болон аюулгүй хог хаягдлын хэмжээг багасгах, хаягдал гаргахгүй байхын зэрэгцээ хаягдлын хор уршгийг аль болох багасгах арга хэмжээг авна. Хог хаягдал бий болохоос зайлсхийх боломжгүй боловч хаягдлын хэмжээ нь багассан тохиолдолд зээлдэгч нь дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээх, эсвэл эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглах ба хог хаягдлыг сэргээх буюу дахин ашиглах боломжгүй тохиолдолд зээлдэгч, байгаль орчинд ээлтэй байдлаар хаягдлыг зайлуулах арга хэмжээ авна.

⁴⁵ Энэхүү ГШ-ын хүрээнд хаягдал гэж байгаль орчинд хаяхаас (байгаль орчинд халгүй байдлаар) өмнө физик, хими, биологийн зохистой арга замаар боловсруулсан хийн, шингэн ба хатуу бодис, материалын холимог зүйлсийг хэлнэ.

21. Гарсан хаягдлыг аюултай гэж үзвэл зээлдэгч хил дамжуулан тээвэрлэх болон бусад хууль эрх зүйн шаардлагад заасан холбогдох хязгаарлалтыг харгалзан хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах техникийн ба санхүүгийн хувьд боломжтой зардал багатай хувилбаруудыг хайна.
22. Зайлуулсан хог хаягдлыг талбайгаас шилжүүлсэн ба/эсвэл гуравдагч этгээдээр энэ ажлыг хийлгэсэн бол, зээлдэгч хаягдлыг хаях эцсийн байршил хүртэл хамгаалалтын баримт бичгийг авах ба тусгай зөвшөөрөлтэй нэр хүндтэй, хууль ёсны байгууллагаар баталгаажсан гэрээлэгчээр тус ажлыг гүйцэтгүүлнэ. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон хаягдал зайлуулах цэгүүд нь хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу ажиллаж байгаа эсэхийг зээлдэгчийн зүгээс шалгах шаардлагатай. Хэрэв энэ шаардлага хангагдаагүй тохиолдолд зээлдэгч төслийн талбайд өөрсдийн хаягдал сэргээх, зайлуулах байгууламжийг байгуулах өөр хувилбаруудыг авч үзэх нь зүйтэй.

Аюултай материал болон бодисыг зохистой ашиглах менежмент

23. Төсөлтэй шууд холбоотой бүхий л үйл ажиллагаанд, зээлдэгч аюултай бодис, материалын хэрэглээг багасгах буюу зайлсхийх ба хүний эрүүл мэнд байгаль орчныг хамгаалах үүднээс аюул багатай бодис, материалыг илүүтэйгээр ашиглах нь зүйтэй. Зайлсхийх, эсвэл орлуулах боломжгүй бол зээлдэгч нь төсөлтэй холбоотойгоор аюултай материал үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, ашиглах, зайлуулах явцад агаар, ус ба/эсвэл хөрсөнд аюултай материал алдагдах ажиллагааг багасгах болон хяналт тавих зорилгоор холбогдох эрсдэлийн менежментийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
24. Зээлдэгч нь амьд организм болон байгаль орчныг хордуулах, био хуримтлал үүсгэх, озоны үе давхаргыг задлах өндөр аюул бүхий олон улсын хоригт багтсан, аажмаар хэрэглээнээс хасагдаж буй аюултай бодисын үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээнээс зайлсхийнэ.

Пестицидийн хэрэглээ ба менежмент

25. Пестицидтэй харьцаж, эсвэл ашиглаж байгаа зээлдэгчид хортон шавьжийн нэгдсэн менежмент (IPM-integrated pest management) болон/буюу халдвар тараагчтай тэмцэх нэгдсэн менежмент (IVM-integrated vector management)-ийг боловсруулж хэрэгжүүлнэ. Зээлдэгчийн IPM болон IVM хөтөлбөр нь зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн пестицидийн хохирлоос урьдчилан сэргийлэх үүднээс уламжлалт арга, биологийн болон генетик арга, бүр боломжгүй тохиолдолд химийн зэрэг одоогоор ашиглагдаж буй пестицидийг хянах аргуудыг ашиглан пестицидийн хэрэглээг холбогдох болон бусад байгаль орчны мэдээллийг хүргэн зохицуулна. Пестицидийн менежментийн ажиллагааны хүрээнд пестицид ашиглахаар бол зээлдэгч нь биологийн олон янз байдал болон хүний эрүүл мэнд, цаашлаад байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг багасгах арга хэмжээ авах ба пестицидийн тогтвортой хэрэглээг бий болгох, мөн ургац хамгаалах арга, технологитой уялдуулан пестицидийн эрсдэл, хэрэглээг багасгах тал дээр анхаарч ажиллана.
26. Пестицидийн тогтвортой хэрэглээг дэмжих зорилгоор дараах арга хэмжээг авна. Үүнд:
 - биологийн олон янз байдал, хүний эрүүл мэндэд пестицидийн үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй бол багасгах,

- хортой бодисыг аюул багатай бодисоор (химийн бус бодис зэргээр) орлуулах байдлаар аюулын түвшинг бууруулах хувилбаруудыг хайх,
- тоос хүртээгч шавж, байгаль орчин зэргийг бага хордуулах чанартай тухайн устгахаар зорьж буй хортон шавжид үр дүнтэй нөлөөлдөг пестицидийг сонгож ашиглах,
- пестицид бага хэрэглэдэг, эсвэл пестицид ашигладаггүй газар тариаланг дэмжих,
- хортон шавжийг устгагч биологийн төрөл зүйлд үзүүлэх хохирлыг багасгах, хортон шавж дасан зохицох орчныг бий болгохоос урьдчилан сэргийлэх.

27. Зээлдэгч нь пестицидийг олон улсын сайн туршлагын дагуу зохицуулах, хадгалах, хэрэглэх, зайлуулах үүрэгтэй.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 4

Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа

Танилцуулга

1. Энэхүү гүйцэтгэлийн шаардлага нь (ГШ) төслийн нөлөөлөлд өртсөн олон нийт, хэрэглэгчид болон ажиллагсдад үзүүлэх төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан аливаа асуудал болон эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны сөрөг нөлөөллийг бууруулах буюу зайлсхийх нь чухал ач холбогдолтой болохыг онцлон авч үзлээ.
2. Төслийн бүтээн байгуулалт, хэрэгжилт, татан буулгалт, түүхий эд болон бэлэн материалын тээвэрлэлт зэрэг төслийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, дэд бүтэц нь ажиллагсад, олон нийтийг эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны эрсдэл, нөлөөлөлд өртөх боломжийг нэмэгдүүлж болзошгүй юм.
3. Зээлдэгч өөрсдийн ажиллагсдад эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны талаар мэдээлэх, сургалт явуулах, зөвлөх мөн хяналт тавих ба ажиллагсдыг эрүүл, аюулгүй нөхцөлөөр хангах анхан шатны хариуцлага хүлээнэ. Ажиллагсад ажил олгогчтойгоо идэвхтэй хамтран ажиллаж, өөрсдийн болон бусдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд анхаарал тавих үүрэгтэй.
4. Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хангах нь холбогдох эрх бүхий байгууллагын гүйцэтгэх үүрэг болохыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ зээлдэгч нь төслөөс үүсэж болзошгүй нөлөөлөлд өртсөн олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны сөрөг нөлөөлөл, эрсдэлийг тодорхойлох, зайлсхийх, багасгах болон бууруулах үүрэгтэй.

Зорилго

5. Энэхүү ГШ-ын зорилго нь:
 - төсөлтэй холбоотой аливаа эрсдэл, асуудалд тохирсон эрүүл, аюулгүй удирдлагын тогтолцоог бий болгох, эрүүл, аюулгүй ажлын нөхцлийг бүрдүүлэх замаар ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг дэмжих, хамгаалах,
 - төслийг хэрэгжүүлэх бүхий л хугацааны туршид төслийн хэвийн болон гэнэтийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн олон нийт, хэрэглэгчдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэх, бууруулах, урьдчилан сэргийлэх асуудлууд болно.

Үйлчлэх цар хүрээ

6. Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн үнэлгээг гүйцэтгэх явцад төслийн зүгээс дагаж мөрдөх энэхүү ГШ-ын холбогдох шаардлагыг тодорхойлох, эдгээр шаардлагуудыг төслийн үе шатуудад хэрхэн биелүүлж хэрэгжүүлэх талаар авч үзнэ. Энэхүү ГШ-ыг хангахын тулд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг зээлдэгч нь ГШ 1-д заасны дагуу өөрийн байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС), түүнчлэн тухайн төсөлд зориулан боловсруулсан байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ)-нд тусгана.
7. Ажиллагсад болон нөлөөлөлд өртсөн олон нийтэд учирч болох эрсдэл, сөрөг нөлөө нь төслийн барилгын ажил, төслийг эхлүүлэх, хэрэгжүүлэх, татан буулгах зэрэг үе шатанд явагдах үйл ажиллагаанаас шалтгаалан үед өөр өөр байж болно. Бохирдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж болзошгүй

нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хянах талаарх нарийвчилсан шаардлагыг ГШ 3, ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанаас бусад хөдөлмөр эрхлэлт ба ажиллах нөхцөлтэй холбоотой шаардлагуудыг ГШ 2-д тус тус оруулав.

8. Энэхүү ГШ-д дурдсан "ажиллагсад" гэсэн ойлголтод зээлдэгч байгууллагын ажиллагсдыг авч үзэж байгаа бөгөөд төслийн гол үйл ажиллагаатай холбоотой шууд ажил гүйцэтгэх буюу гэрээлэгч, бусад зуучлагчдаар дамжуулан зээлдэгчтэй холбогдон ажиллаж буй хагас цагийн, түр зуурын, улирлын, шилжин ирсэн ажиллагсад болон гэрээт ажиллагсад мөн орсон болно.

Шаардлага

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны менежментийн ерөнхий шаардлага

9. Зээлдэгч төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор бий болсон аливаа осол, гэмтэл болон өвчлөлийг илрүүлэх, эдгээрээс ажиллагсад, нөлөөлөлд өртсөн олон нийтийг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ба олон улсын сайн туршлага, нөлөөллийг шат дараатайгаар бууруулах аргачлалтай уялдуулан эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны эрсдэлийг удирдах төлөвлөгөө болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.
10. Зээлдэгч нь ажиллагсад, нөлөөлөлд өртсөн олон нийтэд холбогдох мэдээлэл, удирдамж өгөх ба эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны аюул, эрсдэлээс хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд, мөн төслийн явцад аюулгүй ажиллагаанд шаардлагатай яаралтай тусламжийн зохицуулалтын талаар сургалт явуулна.
11. Төслийн үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн өвчин, осол, гэмтэл гарсан эсвэл гарч болзошгүй тохиолдолд зээлдэгч үйл явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, тухайн үр дүнд хяналт тавин баримтжуулж, дүн шинжилгээ хийн хуулийн дагуу холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэж хамтран ажиллана.

Хөдөлмөрийн эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа

12. Зээлдэгч нь ажиллагсдыг эрүүл, аюулгүй ажлын байраар хангах ба тодорхой салбар, ажлын онцлогоос шалтгаалан үүсэж болзошгүй аюулыг харгалзан үзнэ. Зээлдэгч нь Европын холбооны холбогдох ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа (АБЭМАА)-ны стандарт⁴⁶ болон олон улсын сайн туршлагын дагуу төслийн мөн чанар, цар хүрээ, үе шатанд тохирсон эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны эрсдэл, хамгаалалтын арга хэмжээг тодорхойлно. Зээлдэгч нь өөрийн БОНМС-д нэгтгэн хэрэгжүүлэхэд тохирох төслийн онцлогоос шалтгаалсан эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна.
13. Зээлдэгч хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд, (i) аюултай нөхцөл, эсвэл бодисыг хувиргах, солих, өөрчлөх, устгах зэрэг урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах, (ii) эрсдэлийг

⁴⁶ Европын холбооны АБЭМАА (OHS)-ны стандартад ажиллагсдыг хамгаалах зорилготой наад захын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлагуудыг тогтоосон ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба Европын холбооны хууль тогтоомжид тусгагдсан шаардлагууд багтана.

багасгах тоног төхөөрөмж хэрэглэх, энэ төрлийн төхөөрөмжийг хэрэглэхийг шаардах, (iii) ажиллагсдаас ямар нэгэн төлбөр авахгүй хувийн хамгаалах хэрэгслээр хангах, болон (iv) ажиллагсадад шаардлагатай эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны сургалт хийх арга хэмжээнүүд багтана. Зээлдэгч төслийн талбайд эсвэл шууд үндсэн чиг үүрэгт нь хамаарах ажил гүйцэтгэж буй өөрийн, гэрээт болон гуравдагч этгээдийн ажиллагсдыг эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны төлөвлөгөө дагаж мөрдөхийг шаардана.

14. Зээлдэгч нь төсөлтэй холбоотой бүхий л ажиллагааны явцад ажиллагсад эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны арга хэмжээг хангалттай, тогтмол хэрэгжүүлж буй эсэхийг хариуцан ажиллана.
15. Зээлдэгч өөрийн ажиллагсдын эрүүл мэндэд хяналт тавих ба ажиллагсдыг ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаатай холбоотой арга хэмжээнд оролцохыг дэмжинэ. Үүнд, ослыг мөрдөн шалгах, эрсдэлийг үнэлэх, ажил сонгох болон бусад арга хэмжээнүүд орно.
16. Нас, хүйс, хөдөлмөрийн чадвар, богино болон урт хугацааны эрүүл мэндийн байдал зэрэг эмзэг байдалтай ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх зарим үйл ажиллагаанд онцгой эрсдэлүүд байгаа бол, зээлдэгч эрсдэлийн үнэлгээ хийж, гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зохицуулалт хийнэ.

Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа

17. Зээлдэгч төслийн нөлөөлөлд өртсөн олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд нөлөөлж болохуйц эрсдэл, сөрөг нөлөөллийг тодорхойлох, үнэлэх ба төслийн үе шат, цар хүрээ, шинж чанарт нийцсэн болон уг эрсдэл, нөлөөлөлд тохирсон урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээг боловсруулна. Зээлдэгч бууруулах арга хэмжээ болон төлөвлөгөөний талаар холбогдох эрх бүхий байгууллага, бусад оролцогч талуудтай хамтран ажиллана. Эдгээр арга хэмжээ нь сөрөг нөлөөллийг шат дараатай бууруулах арга зам болон олон улсын сайн туршлагад нийцсэн байвал зохино.
18. Төслийн үйл ажиллагаанаас олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд учрах нөлөөллийг бууруулах буюу зайлсхийх арга хэмжээ нь холбогдох төрийн байгууллагын үүрэг хариуцлага байж болно. Энэ тохиолдолд зээлдэгч өөрийн үүрэг хариуцлагыг тодорхойлж холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны менежменттэй холбоотой тусгай шаардлага

Дэд бүтэц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн зураг төсөл болон эдгээрт аюулгүй ажиллагааны асуудлыг тусгах

19. Зээлдэгч гуравдагч этгээд болон нөлөөлөлд өртсөн олон нийтийн аюулгүй ажиллагааны эрсдэлийг харгалзан олон улсын сайн туршлагад заасны дагуу төслийг боловсруулах, төслийн бүтээн байгуулалтын ажил, төслийг хэрэгжүүлэх, гол байгууламжийг татан буулгах зэрэг бүхий л үе шатанд эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны асуудлыг тусган авч үзнэ. Төслийн гол байгууламжуудыг мэргэшсэн, туршлагатай мэргэжилтнээр төлөвлүүлж гүйцэтгүүлнэ. Гуравдагч этгээдийн амь

нас, галын аюулгүй ажиллагааны дотоод хяналтыг нийтийн зориулалтаар одоо ашиглаж байгаа барилга болон ашиглалтанд өгөхийн өмнө шинэ барилгын аль алинд нь хийх шаардлагатай.

20. Нийтийн зориулалтаар ашиглах байгууламжийн барилга болон томоохон засварын ажлууд бүх нийтэд хүртээмжтэй буюу аль ч тохиолдолд чөлөөтэй нэвтрэх боломжтой⁴⁷ байхаар төлөвлөгдсөн байвал зохино.
21. Далан, хаягдлын далан эсвэл үнсний цөөрөм зэрэг барилгын хийцийн элемент буюу бүрэлдэхүүн хэсгүүд нь өндөр эрсдэл бүхий газар байрладаг ба тэдгээрийн эвдрэл, гэмтэл нь ажиллагсад болон олон нийтийн аюулгүй байдалд аюул занал учруулж болзошгүй тохиолдолд зээлдэгч нь ижил төрлийн төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай нэг буюу түүнээс дээш мэргэжилтнийг татан оролцуулж барилга, зураг төсөл хариуцсан мэргэжилтнүүдээс тусдаа байдлаар төслийг боловсруулах, төслийн бүтээн байгуулалт, хэрэгжилт, дуусгах бүхий л шатанд аль болох эртнээс хяналт шалгалтыг барилгын бүрэлдэхүүн хэсэгт хийнэ.

Аюултай материалын аюулгүй ажиллагаа

22. Зээлдэгч төслөөс гарч болох аюултай материалд ажиллагсад болон олон нийтийн өртөх боломжийг багасгах буюу урьдчилан сэргийлнэ. Ажиллагсад болон нөлөөлөлд өртсөн олон нийт аюулд өртөж болзошгүй тохиолдолд зээлдэгч нь аюул үүсгэж буй нөхцөл, эсвэл аюултай бодисыг өөрчлөх, орлуулах болон арилгах байдлаар тухайн аюулаас урьдчилан сэргийлэх буюу багасгах арга хэмжээг авна.
23. Төслийн одоо байгаа барилга байгууламж, эсвэл үйл ажиллагаанд аюултай материал ашиглах тохиолдолд зээлдэгч нь үйл ажиллагаа эхлэх болон хаалтын ажлын үеэр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллагсад, олон нийтийг аюултай материалын эрсдэлээс сэргийлнэ. Ийм материалаас шалтгаалсан аюулаас зайлсхийх боломжгүй бол зээлдэгч нь олон улсын сайн туршлагын дагуу тухайн материалыг боловсруулах, хадгалах, тээвэрлэхэд шаардлагатай арга хэмжээ авна.
24. Зээлдэгч түүхий эд материал, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, мөн хог хаягдлыг тээвэрлэх, хаяхтай холбоотойгоор олон нийтэд үүсэх эрсдлийг хянах, зайлсхийх үүднээс аюулгүй ажиллагааны тал дээр хүчин чармайлт гарган ажиллаж холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Бүтээгдэхүүний аюулгүй байдал

25. Өргөн хэрэглээний барааны болон/эсвэл худалдаа, үйлдвэрлэл эрхэлж буй төслийн хувьд зээлдэгч нь үйлдвэрлэлийн үйл явц, төлөвлөлтийг сайжруулах замаар бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангана. Үүнд, бүтээгдэхүүнийг үйлчлүүлэгчдэд тараах үед хадгалалт, түгээлт, тээвэрлэлтийн явцыг хянана. Тухайн улс орон, бизнесийн салбарын туршлага, дүрэм, бүтээгдэхүүний аюулгүй байдлын стандарт, аюулгүй байдлын ерөнхий шаардлагууд зэрэг олон улсын сайн туршлагыг дагаж мөрдөнө.

⁴⁷ Бүх нийтэд хүртээмжтэй гэж бүх насны болоод ямар ч чадвартай хүмүүс бүхий л тохиолдолд болон ямар ч нөхцөл байдалд чөлөөтэй нэвтрэх боломжтой байхыг хэлнэ.

26. Зээлдэгч нь төслийн үнэлгээний явцад бүтээгдэхүүнээс хэрэглэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, нөлөөллийг тодорхойлно. Бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахдаа үүсэж болзошгүй нөлөөллийг шат дараатайгаар бууруулж, бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлаас үүсэх эрсдэлийн талаар хангалттай мэдээллийг хэрэглэгчдэд хүргэнэ. Эрүүл мэндэд ноцтой аюул занал учруулж болзошгүй нөхцөл үүссэн тохиолдолд зээлдэгч бүтээгдэхүүнийг эргүүлэн татах буюу тухайн бүтээгдэхүүнийг устгах бодлого, журам баримтлан ажиллана.

Үйлчилгээний аюулгүй байдал

27. Төслийн үйл ажиллагааны хүрээнд олон нийтэд үйлчилгээ үзүүлэх тохиолдолд зээлдэгч тухайн үйлчилгээ нь ажиллагсад, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд нөлөөлөл, эрсдэл учруулахгүй байх тал дээр анхаарч зохих чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх замаар тухайн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллах нь зүйтэй.
28. Төсөл нь олон нийтэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулах тохиолдолд зээлдэгч нь тухайн үйлчилгээ бүх нийтэд хүртээмжтэй байх зарчмыг тусгаж ажиллана.

Замын хөдөлгөөн болон замын аюулгүй ажиллагаа

29. Зээлдэгч төслийг хэрэгжүүлэх хугацаанд нөлөөлөлд өртсөн олон нийт болон ажиллагсадд учирч болзошгүй замын хөдөлгөөн, замын аюулгүй ажиллагааны эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, мониторинг хийх ба шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээ, төлөвлөгөө боловсруулна. Нийтийн зам болон бусад дэд бүтэц байрлах талбайд хөдөлгөөнт тоног төхөөрөмж ажиллуулж буй төслийн хувьд зээлдэгч нь эдгээр тоног төхөөрөмжийн ашиглалттай холбоотойгоор олон нийтийн осол, гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
30. Зээлдэгч Европын холбооны холбогдох зам, замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааны менежментийн стандартыг⁴⁸ харгалзан үзэж замын аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээг тодорхойлох, орон нутгийн нөлөөлөлд өртсөн олон нийтэд учирч болзошгүй замын аюулгүй ажиллагааны нөлөөллийг бууруулах зорилгоор техникийн болон эдийн засгийн хувьд боломжтой, зардал багатай замын аюулгүй ажиллагааны арга хэмжээг төслийг хэрэгжүүлэх загварт тусгаж өгнө. Шаардлагатай тохиолдолд зээлдэгч нь төслийн үе шат бүрт нь замын аюулгүй ажиллагааны аудит хийх ба аюулгүй ажиллагаатай холбоотой сөрөг асуудлыг тодорхойлж шийдвэрлэх зорилгоор осол, гэмтлийг тогтмол хянах ажлыг гүйцэтгэнэ. Тээврийн хэрэгсэл буюу тээврийн хэрэгслийн бааз (эзэмшдэг буюу лизингээр авсан) ажиллуулж буй зээлдэгч нь жолоочийн болон тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны талаар ажиллагсдын дунд зохих сургалтыг зохион байгуулна. Зээлдэгч төслийн бүх тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг тогтмол хангана.

⁴⁸ Европын холбооны Автозамын дэд бүтцийн аюулгүй ажиллагааны менежментийн тухай 2008.11.19-ний 2008/96/ЕС тоот захирамжийн зорилгод нийцсэн байх.

Байгалийн аюул

31. Зээлдэгч нь газар хөдлөлт, хөрсний нуралт, үер зэрэг байгалийн аюулын улмаас төсөлтэй холбоотой учирч болзошгүй нөлөөлөл, эрсдэлийг тодорхойлж, үнэлнэ.
32. Зээлдэгч нь байгалийн аюул, газар ашиглалтын өөрчлөлтөөс үүдэлтэй ч төслийн үйл ажиллагаа нэмэрлэснээс тухайн үүссэн нөлөөлөл ихсэхээс зайлсхийх буюу нөлөөллийг багасгах арга хэмжээ авна.

Өвчлөлд өртөх

33. Ажиллагсад болон олон нийт өвчлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор зээлдэгч нь эмзэг бүлгийн өвчлөлд өртөх мэдрэмтгий болон ялгаатай байдлыг тооцон үзэж, холбогдох эрх бүхий байгууллагатай зөвшилцөний үндсэн дээр тохирсон бууруулах арга хэмжээг боловсруулна. Зээлдэгч төслийн түр зуурын болон/эсвэл байнгын ажиллагсдын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой гарч болзошгүй халдварт өвчний тархалтыг багасгах, зайлсхийх арга хэмжээ авна.
34. Төслийн нөлөөлөлд өртсөн олон нийтийн дунд өмнө нь тодорхой өвчин тархсан байгаа тохиолдолд зээлдэгч нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд тухайн өвчин ажиллагсад, олон нийтийн дунд цаашид тархах нөхцлийг бууруулах боломжийг тодорхойлно. Зээлдэгч түр зуурын болон/эсвэл байнгын төслийн ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнтэй холбоотой үүсч бий болох халдварт өвчний тархалтыг багасгах, түүнээс зайлсхийх арга хэмжээ авна.

Онцгой байдлын бэлэн байдал ба хариу арга хэмжээ

35. Зээлдэгч нь төсөлтэй холбоотой аливаа гэмтэл, осол болон онцгой нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах бэлтгэлтэй байх шаардлагатай ба энэхүү бэлтгэл нь төсөлтэй холбоотой ажиллагаанаас үүсэх эрсдэл, үүсэж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах хэрэгцээ шаардлага, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байвал зохино.⁴⁹
36. Зээлдэгч томоохон ослын аюулыг үнэлж ажиллагсад, нөлөөлөлд өртсөн олон нийт болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг хязгаарлах, үр дүнтэй байдлаар аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч аюулгүй ажиллагааг хангана. Энэхүү арга хэмжээг зээлдэгчийн БОНМС-тэй уялдуулан томоохон ослоос сэргийлэх/онцгой байдалд баримтлах бодлого болон тохирсон менежментийн төлөвлөгөөнд тусган оруулна. Уг төлөвлөгөө нь дээрх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгууллагын бүтэц, үүрэг хариуцлага, дүрэм журам, харилцаа холбоо, сургалт, нөөц зэрэг асуудлыг багтаасан байх ба мөн төсөлтэй холбоотой онцгой байдал үүсэхэд зээлдэгч нь уг асуудалд үр дүнтэйгээр харуй арга хэмжээ авах нөхцлөөр хангана. Түүнчлэн дээрх төлөвлөгөө нь:
- хүн, байгаль орчин, эд хөрөнгөд учруулах хохирлын нөлөөг багасгах, хянах, урьдчилан сэргийлэх,
 - том ослын үр дагавраас хүн, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх,

⁴⁹ Европын зөвлөлийн 96/82/EC (EU SEVESO III Directive) тоот захирамжийг шинэчилж, улмаар түүний оронд хүчин төгөлдөр болсон, аюултай бодистой холбоотой ослын аюулыг хянах тухай 2012.07.04-ний 2012/18/EU тоот захирамжид тодорхой тайлбарласан.

- шаардлагатай мэдээллийг онцгой байдлын асуудал хариуцсан холбогдох олон нийтийн үйлчилгээний болон эрх бүхий байгууллага, мөн нөлөөлөлд өртсөн ажиллагсад болон олон нийтэд мэдээлэх,
- томоохон ослын дараах нөхөн сэргээх, байгаль орчныг цэвэрлэх ажлыг гүйцэтгэх зорилготой болно.

Томоохон осол гарч болзошгүй төслийн хувьд зээлдэгч онцгой байдлын нөхцөл байдалд үр дүнтэй хариу арга хэмжээ авахад нь холбогдох эрх бүхий байгууллага болоод олон нийтэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. Орон нутгийн засаг захиргаа, эсвэл онцгой байдалд өртсөн олон нийт нь тухайн нөхцөл байдалд үр дүнтэй хариу арга хэмжээ авах маш бага буюу ямар ч нөөц бололцоогүй тохиолдолд, зээлдэгч нь төсөлтэй холбоотойгоор үүсэж болзошгүй онцгой байдалд үзүүлэх хариу арга хэмжээг сайжруулахад идэвхтэй үүрэг гүйцэтгэж, мөн ослын үед шууд болон шууд бусаар хариу үйлдэл үзүүлэх чадавхийг хэрхэн бий болгосныг баримтаар нотлон үзүүлнэ.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 5

Газар чөлөөлөх, албадан нүүлгэн суурьшуулах ба эдийн засгийн хохирол амсах

Танилцуулга

1. Албадан нүүлгэн суурьшуулах үйл ажиллагаанд төсөлтэй холбоотой газар чөлөөлөх⁵⁰ болон/буюу газар ашиглалтыг хязгаарласнаас үүдэн биет нүүлгэн шилжүүлэлт явуулах (өөр газар луу нүүлгэх эсвэл орон байраа алдах) болон эдийн засгийн хохирол амсах⁵¹ (эд хөрөнгө, нөөц боломжоо алдах буюу эд хөрөнгө буюу нөөц боломжийг ашиглах боломжгүй болсноор орлогын буюу амьжиргааны эх үүсвэрээ алдах) асуудал хоёулаа багтана.
2. Нөлөөлөлд өртсөн хувь хүн, олон нийт нь газраа чөлөөлөх эсвэл газраа хязгаарлагдмал байдлаар ашиглахаас татгалзах эрхгүйгээс тухайн газраас нүүж буй тохиолдлыг албадан нүүлгэн суурьшуулалт гэж үзнэ. Албадан нүүлгэн суурьшуулалтыг (i) хууль, журмын хүрээнд газрыг албадан чөлөөлөх, эсвэл ашиглах эрхийг хязгаарлах⁵², (ii) газрын эзэдтэй хийх зөвшилцөл бүтэлгүйтсэнээс газрыг албадан худалдаж авах, эсвэл газар ашиглалтыг хуулийн хүрээнд хязгаарлах зэрэг хэлэлцэж тохирсон үйлдлүүдийн хүрээнд явуулна.
3. Энэхүү ГШ нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн сахих, ялангуяа өөрт тохирсон орон байртай байх, мөн амьдралын нөхцлийг тогтмол сайжруулах зэрэг нийтлэг эрхийг хангах асуудлыг дэмжинэ⁵³. Зөрчил, маргааны улмаас нүүлгэн шилжүүлэлт нэгэнт явагдсан тохиолдолд энэхүү ГШ нь Нүүлгэн шилжүүлэлтийг чиглүүлэх зарчмыг удирдлага болгоно.⁵⁴
4. Албадан нүүлгэн суурьшуулалтыг зөв явуулаагүй тохиолдолд нөлөөлөлд өртсөн хувь хүн, олон нийтийн амьдралыг доройтуулах, байгаль орчинд хохирол учруулах, мөн нүүлгэн шилжүүлэлт хийсэн газар нутагт нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөлөл үүсэх зэрэг урт хугацааны бэрхшээл үүсэж болох юм. Зарим нөхцөлд муу зохион байгуулсан албадан нүүлгэн суурьшуулалт нь зээлдэгчийг хуулийн арга хэмжээ авахуулахад хүргэж мэднэ. Эдгээр шалтгааны улмаас албадан нүүлгэн суурьшуулалтаас зайсхийх хэрэгтэй. Хэрэв зайлсхийх боломжгүй бол нөлөөлөлд өртсөн хүн ам болон шилжин очсон орон нутагт⁵⁵ учрах сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн зохих арга хэмжээг сайтар төлөвлөж

⁵⁰ Газар чөлөөлөх гэдэгт нь өмч хөрөнгийг албадан худалдаж авах, дайран өнгөрөх эрх, хөрөнгийг ашиглах эрхийг худалдан авахын аль алиныг багтаана.

⁵¹ Жишээлбэл улсын өмч болох газрын гадаргуу доорх ашигт малтмал ашиглах эрхийг гар аргаар ашигт малтмал олборлогчид алдах, төслийн үйл ажиллагааны улмаас далайн загасны нөөц ашиглах эрхгүй болох, зээлдэгч өөрийн биш, улсаас тогтоосон онцгой бүсэд байршилтай нөөц баялагт нэвтрэх эрхийг хязгаарлах, төслөөс үүдэлтэй сөрөг асуудал ба/эсвэл бохирдолоос шалтгаалан хөдөө аж ахуй, мал аж ахуй, ой мод, ан агнуур болон загасны аж ахуйн үр өгөөж мэдэгдэхүйц буурсан явдал орж болно.

⁵² Энэхүү хязгаарлалтанд хуулийн хүрээнд хамгаалсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, биологийн олон янз байдлын хувьд чухал газруудад нэвтрэх эрхийг хязгаарлах асуудал багтаж болно.

⁵³ Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948) ба Эдийн засаг, нийгэм ба соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966).

⁵⁴ Хүний эрхийн дээд комиссарын газар: Нүүлгэн шилжүүлэлтийг удирдах зарчмууд

⁵⁵ Хүлээн авагч олон нийт нь шилжин ирсэн хүмүүсийг хүлээн авч байгаа аливаа нийгмийн бүлэг.

хэрэгжүүлэх хэрэгтэй. Өнгөрсөн туршлагаас харахад нүүлгэн суурьшуулах үйл ажиллагаан дахь зээлдэгчийн шууд оролцоо, төсөл боловсруулах эхний үе шатанд хийх үнэлгээ нь эдгээр үйл ажиллагааг өртөг багатай, үр ашигтай, цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд үр дүнтэй байлгах ба нөлөөлөлд өртсөн хүн амын амьдралын стандарт болон амьжиргааны түвшинг сайжруулах шинэ арга барилыг дэмждэг талтай.

Зорилго

5. Энэ ГШ-ын зорилго нь:

- төслийг хэрэгжүүлэх өөр хувилбаруудыг судлах замаар албадан нүүлгэн суурьшуулалтаас зайлсхийх, гарцаагүй тохиолдолд багасгах,
- нөлөөлөлд өртсөн хүн амын газар ашиглах эрхийн хязгаарлалт, эсвэл газар чөлөөлөлтөөс үүсэх нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг (i) алдсан эд хөрөнгөө дахин шинээр бий болгоход шаардагдах зардлыг нөхөн олгох⁵⁶, (ii) нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ мэдээллийг ил тод байлгах, зөвлөлдөх, нөлөөлөлд өртсөн хүн амыг мэдээллээр ханган оролцуулах замаар бууруулна.
- нөлөөлөлд өртсөн хүн амын⁵⁷ амьдралын стандарт болон амьжиргааны түвшинг нүүлгэн шилжүүлэлтийн өмнөх түвшинд аваачих, боломжтой бол сайжруулах,
- нүүн очсон газар нутагт газар эзэмших баталгаат эрх⁵⁸, тохирсон орон байраар⁵⁹ хангах замаар биет нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүн амын амьдралын нөхцлийг сайжруулах асуудлууд болно.

⁵⁶ Ихэвчлэн хөрөнгийн зах зээлийн үнэ дээр эд хөрөнгийг сэргээхтэй холбоотой эрх шилжүүлэх зардал зэргийг нэмэж тооцдог. Газрын ялгаатай шинж чанар, газар эзэмшигч, газрын зах зээлийн хөгжлийн түвшин гишүүн орнуудад өөр өөр байдгаас шалтгаалан нөхөн орлуулах өртгийн тооцоо нарийн төвөгтэй байдаг. Иймээс зээлдэгч газар чөлөөлөх үйл ажиллагааны улмаас нүүлгэн шилжүүлэлтэнд өртөж буй бүх хүн, нийгмийн бүлгийг тодорхойлж, тэдэнтэй зөвлөлдөхийн хамт нүүн шилжсэн хүмүүсийг хүлээн авагч нийгмийн бүлгүүдтэй мөн зөвлөлдөж, газрын эрх, ашиглалтын талаар хангалттай мэдээлэл олж авах хэрэгтэй. Нөхөн орлуулах зардлыг хэрхэн тооцоолсон аргачлалыг холбогдох нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааны болон амьжиргааг нөхөн сэргээх төлөвлөгөөнүүдэд баримтжуулж тусгана. Газрын зах зээл дөнгөж хөгжиж буй газарт зээлдэгч үнэлгээг хөндлөнгийн бие даасан мэргэжлийн үнэлгээчнээр хийлгэх нь зүйтэй (эсвэл мэргэжлийн үнэлгээчин байхгүй тохиолдолд ЕСБХБ болон зээлдэгчдэд хүлээн зөвшөөрөгдсөн холбогдох мэдлэг, туршлагатай мэргэжлийн хүмүүсээр хийлгэнэ). Мөн доорх 12, 14-р зүүлтийг үзнэ үү.

⁵⁷ Эдгээр нь хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн газар эзэмших эрхтэй хүмүүс, уламжлалт газар ашиглах эрхтэй хүмүүс, хуулиар газар эзэмших эрхгүй хүмүүс, мал хариулах/загас барьдаг гэр бүлүүд, анчин, мөөг, жимс цуглуулагчид зэрэг улирлын нөөцийг ашигладаг хүмүүсийг багтааж болох бөгөөд тэд төслийн бүсэд байрлаж байгаа нийгмийн бүлгүүдтэй харилцан хамаатай байж болно.

⁵⁸ Нүүлгэн суурьшуулалтанд өртсөн хүмүүсийг албадан хөөх асуудлаас хамгаалах үүднээс нүүн очсон газарт газар ашиглах аль болох баталгаат эрхээр хангах шаардлагатай.

⁵⁹ Тохиромжтой байр буюу орн сууцыг чанар, аюулгүй байдал, төлбөрийн чадавхи, оршин суугчдын суурьшил, соёл, зан заншлын тохиромжтой байдал, хүртээмж болон байршлын шинж тэмдгээр хэмжиж болно. Тохиромжтой орон сууц нь ажил эрхлэх боломж, зах зээл, ус, цахилгаан, бохир зайлуулах байгууламж, эрүүл мэнд ба боловсролын байгууллага зэрэг үндсэн дэд бүтэц ба үйлчилгээнд хүрэх бололцоогоор хангах ёстой. Зээлдэгч нь нүүлгэн суурьшуулж буй газарт амьдралын нөхцлийг сайжруулах, ялангуяа тухайн газрыг хууль ёсны дагуу ашиглах эрхгүй хүмүүст дэмжлэг үзүүлэх үүднээс тохиромжтой орон сууцны асуудлыг онцлон авч үзвэл зохино.

Үйлчлэх цар хүрээ

6. Энэ ГШ-ыг дараах нөхцлүүдээс хамааран бүрэн, хэсэгчилсэн, байнга буюу түр зуурын биет нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн хохирол үүссэн үед авч ашиглаж болно. Үүнд,
 - албадан худалдаж авах, албадан чөлөөлөх зэрэг бусад журмын дагуу төслийн үйл ажиллагаанд зориулан газар ашиглах эрхийг шилжүүлэх,
 - газрыг албадан худалдаж авах журмын дагуу бүтэлгүйтсэн тохиолдолд хөрөнгийн өмчлөгч, хуулиар зөвшөөрсөн эрхтэй газрын эзэн, тухайн улс орны хуулиар зөвшөөрдөг уламжлалт ба эдэлж заншсан газрын эрхтэй хүмүүстэй зөвшилцөх замаар газрын эрхийг шилжүүлэх,
 - зөвшилцөл, албадан чөлөөлөх, албадан худалдаж авах, эсвэл төрийн зохицуулалтын арга хэмжээний үр дүнд хязгаарласан эсэхээс үл хамааран хүмүүсийг биет хөрөнгө буюу байгалийн нөөцөд хүрэх боломжоо алдахад хүргэж буй аливаа хязгаарлалтын үед ашиглана.
7. Амьдарч буй газраа эзэмших хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны эрхгүй нөлөөлөлд өртсөн хүн амд тавих шаардлагууд болон хариуцлагыг доорх §18, 32 ба 37-р зүйлд тусгав.
8. Энэхүү ГШ нь сайн дурын үндсэн дээрх газар чөлөөлөлтөөс үүдсэн нүүлгэн суурьшуулалтанд хамаарахгүй (өөрөөр хэлбэл, газраа заавал хүчээр худалдах албагүй, худалдан авагч хэрэв хэлэлцээ бүтэлгүйдвэл албадан худалдан авах буюу бусад албан журмыг ашиглахгүй) ба газрын эрхээ шилжүүлснээр зөвхөн хууль ёсны эрхтэй эрх шилжүүлсэн талууд л нөлөөлөлд өртөнө.
9. Энэхүү ГШ-ыг хангах шаардлагатай эсэхийг 6-8-р зүйлийн заалтуудтай уялдуулан байгаль орчин, нийгмийн үнэлгээний явцад тодорхойлно. Албадан нүүлгэн суурьшуулалт нэгэнт явагдсан тохиолдолд, үнэлгээ нь энэхүү ГШ-ыг хангахад шаардлагатай аливаа (i) орхигдсон болон (ii) засч залруулах арга хэмжээ байгаа эсэхийг тогтооно. Үнэлгээний үр дүнд үндэслэн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна.

Шаардлага

10. Зээлдэгч нь газраа худалдаж буй хувь хүнээс зөвшөөрөл авалгүйгээр тухайн газрыг авах хууль ёсны бололцоо байгаа тохиолдолд ч яриа хэлэлцээний замаар зөвшилцөж газрын эрх олж авах нь зүйтэй. Яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх нь газар албадан чөлөөлөх, төрийн хүчээр хүмүүсийг газраас нь нүүлгэх нөхцөлд хүргэхгүй байхад тус дөхөм болно. Нөлөөлөлд өртсөн хүмүүс, олон нийтэд шударга, зохих ёсны нөхөн төлбөр олгох, бусад ашиг, урамшуулал олгох, мөн мэдээлэл болон яриа хэлэлцээ хийх чадварын тэгш бус байдлыг бууруулах замаар харилцан тохиролцоонд хүрч болно.

Нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх буюу багасгах

11. Зээлдэгч нь биет нүүлгэн шилжүүлэлтэд өртөх болон/эсвэл эдийн засгийн хохирол амсхийхээс зайлсхийх, багасгах талаарх боломжит хувилбаруудыг төслийг боловсруулах үед авч үзэх бөгөөд ингэхдээ байгаль орчин, нийгэм болон санхүүгийн өртөг, ашиг тусыг тэнцвэржүүлэхийг эрмэлзэнэ.

Зөвшилцөл

12. Нүүлгэн суурьшуулалтын үйл ажиллагааны эхний үе шатнаас зээлдэгч шилжин очсон орон нутгийн иргэд, нөлөөлөлд өртсөн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцоог хангана. Энэ талаар ГШ 10-д тусгагдсан ба нүүлгэн суурьшуулалттай холбоотой шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөлд өртсөн иргэдийг эртнээс мэдээллээр ханган оролцуулна. Үүнд,
- нөлөөлөлд өртсөн хүн амыг нөхөн олговор авах эрх, нөхөн олговрын багцын талаар хэлэлцэх, нүүлгэн суурьшуулалттай холбоотой туслалцаа, санал болгож буй суурьшуулах газрын таарамж болон санал болгож буй цаг хугацаа зэргийг хэлэлцэхэд тэгш эрхтэйгээр оролцох боломжийг олгох,
 - нэмэлт шаардлагын дагуу (ГШ 7-г заасаны дагуу) нутгийн уугуул иргэд, мөн эмзэг бүлэгт хамаардаг хувь хүмүүстэй⁶⁰ зөвлөлдөх,
 - энэ ГШ-ын зорилгод нийцсэн үр дүнд хүрэхийн тулд нүүлгэн суурьшуулалт явуулах, нөхөн олговор олгох үед хийгдэх үнэлгээ, мониторинг, хэрэгжилтийн шатанд уг зөвлөлдөөнийг үргэлжлүүлэн явуулах арга хэмжээг авна.
13. Зээлдэгч хөдөлмөрийн чадваргүй эсвэл эмзэг байж болох аливаа хувь хүн, бүлгийг анхааран авч үзнэ. Тухайлбал, зээлдэгч нүүлгэн суурьшуулах үйл явцад эмзэг бүлгийн хүмүүсийг хүндрэлтэй нөхцөлд оруулахгүй байх, тэдний эрхийг ойлгуулсан, бүрэн мэдээллээр хангасан, нүүлгэн суурьшуулалтаас үүсэх боломж, ашиг тусыг тэнцүү хүртэх боломжоор хангахад шаардлагатай арга хэмжээ авна. Эдгээр бүлгүүдийг байгаль орчин, нийгмийн үнэлгээний үйл явцад (ГШ 1-д заасны дагуу) тодорхойлсон байна.

Нийгэм, эдийн засгийн үнэлгээ ба тооллого

14. Зээлдэгч газар чөлөөлөх болон газар ашиглах эрхийг хязгаарлахтай холбоотой нөлөөлөл, мөн төслийн нөлөөлөлд өртсөн хүн амын талаар нийгэм, эдийн засгийн суурь үнэлгээг хийнэ. Энэхүү үнэлгээгээр төслөөс үүдэн нийгмийн хүрээнд гарах нөлөөлөл, нөлөөлөлд өртсөн хүмүүсийн эрх ба тэдний хэрэгцээг тодорхойлж нүүлгэн суурьшуулалтын нөлөөллийг бууруулах, багасгах зохистой арга хэмжээг боловсруулах шаардлагатай.
15. Зээлдэгч нарийвчилсан тооллого буюу суурь үнэлгээг хийх ба үүнд, (i) төслийн нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүн амыг тодорхойлох, (ii) нөхөн олговор, нүүлгэн суурьшуулалтын туслалцаа авах эрхтэй хүнийг тодорхойлох, (iii) нөлөөлөлд өртсөн газар, өмч хөрөнгийн бүртгэлийг хийх ажлууд багтана. Энэхүү тооллогын үед төслийн бүс нутагт байх боломжгүй улирлын нөөцийг ашигладаг буюу нүүдэллэдэг иргэдийн байдлыг харгалзан авч үзэж тооллогыг явуулбал зохино.

⁶⁰ Энэхүү бодлогын баримт бичгийн хувьд «эмзэг бүлэг» гэж жендэр, бэлгийн чиг хандлага, шашин шүтлэг, яс үндэс, уугуул иргэншил, нас, хөгжлийн болон санхүүгийн бэрхшээл, нийгмийн статус зэргээс хамааран бусадтай харьцуулахад төслийн нөлөөлөлд илүүтэйгээр өртсөн, төслийн үр ашгаас хүртэх боломж, чадвар багатай хүмүүсийг хэлнэ. Эмзэг бүлгийн хүмүүст ядуурлын түвшнээс доогуур амьжиргаатай, өөрийн гэсэн газаргүй хүмүүс, ахмад настан, өрх толгойлсон эмэгтэйчүүд, хүүхдүүд, албадан нүүлгэсэн хүмүүс, үндэстний цөөнх, амьжиргаа нь байгалийн баялгаас хамааралтай бүлэг хүмүүс зэрэг тухайн улс орны болон олон улсын хууль тогтоомжоор хамгаалагдаагүй байж болох бусад хүмүүс бас багтаж болно.

16. Засгийн газрын тодорхой журам байхгүй бол, зээлдэгч зохих хууль тогтоомж, төслийн хэрэгжилтийн хугацааг тооцон үзсэний үндсэн дээр тасалбар болгох өдрийг тогтоож өгнө. Тасалбар болох өдрийг тогтоох хамгийн боломжит хугацаа нь ихэнхдээ суурь үнэлгээ буюу тооллого хийх явцад тохиодог. Тасалбар болгох өдрийн талаарх мэдээллийг төслийн талбай орчимд сайтар тараан баримтжуулна. Тасалбар болох өдрийг тогтоосноор нөхөн олговор, туслалцаанд хамрагдах эрхийг тодорхой болгож өгдөг. Тасалбар болгох өдрөөс хойш төслийн талбай руу нүүж ирэх хүмүүс нөхөн олговор болон бусад туслалцаа авах эрхгүй буюу энэ эрхэд хамрагдахгүй болно.

Нөлөөлөлд өртсөн хүмүүсийн нөхөн олговор

17. Зээлдэгч нөлөөлөлд өртсөн хүн ам болон тухайн олон нийтэд эд хөрөнгөө алдсаны нөхөн олговор болгон тухайн эд хөрөнгийг дахин бий болгох зардал⁶¹ болон бусад туслалцааг санал болгоно. Энэ нь нөлөөлөлд өртсөн хүн амын амьдралын стандарт болон/буюу амьжиргааны түвшинг⁶² нүүлгэн шилжүүлэлтийн өмнөх түвшинд аваачих, боломжтой бол сайжруулах зорилготой. Уг арга хэмжээ нь газар, нөөц, цалин хөлс болон /эсвэл бизнесийн үйл ажиллагаа дээр тулгуурласан байна. Нөхөн олговрын стандарт нь ил тод бөгөөд төслийн хүрээнд нийцсэн байна. Нөхөн олговрыг нүүлгэн шилжүүлэлт буюу тухайн газар дээр холбогдох хязгаарлалт хийгдэхээс өмнө олгоно. Нөлөөлөлд өртсөн хүмүүсийн амьжиргаа нь газарт суурилсан буюу газраас хүртэх ашиг тусаас хамаардаг бөгөөд газрыг хамтран эзэмшдэг бол, зээлдэгч улирлын болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хугацааг харгалзан үзэж боломжтой бол газарт суурилсан нөхөн олговор санал болгоно. Зээлдэгч нөлөөлөлд өртсөн хувь хүн, олон нийтэд төслийн үйл ажиллагаанаас зохих ашиг тусыг олох боломжийг олгоно.
18. Нөлөөлөлд өртсөн хүн амыг дараах байдлаар ангилж болно. Үүнд, (i) тухайн орны хуулиар хүлээн зөвшөөрөгддөг заншлын болон уламжлалт эрх гэх мэт газар эзэмших албан ёсны хуулийн эрхтэй хүн, (ii) албан ёсны хүн амын тооллогын үеэр газар эзэмших эрхгүй байсан ч тухайн орны хууль, тогтоомжийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдөх газрын эрх авах боломжтой хүмүүс, (iii) амьдарч байгаа газраа хуулийн дагуу эзэмшээгүй эсхүл нэхэмжлээгүй хүмүүс орно.
19. Эзэмших эрхийн болон түрээсийн гэрээ гэх мэт өмчлөл буюу эзэмшилтэй холбоотой баримт бичиг нь (нөхөн төлбөр авах зорилгоор нээсэн банкны данс зэрэг) гэр бүлийн эхнэр нөхрийн аль алины нэр дээр, эсвэл ганц бие өрх толгойлсон өрхийн тэргүүн байгаа тохиолдолд тухайн өрх толгойлогчийн нэр дээр олгогдох ёстой. Ур чадварын сургалт, зээл, ажлын байр олж авах зэрэг бусад нүүлгэн шилжүүлэх туслалцаа нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст адил тэгш хүртээмжтэй, тэдний хэрэгцээ шаардлагад зохицсон байх ёстой.

⁶¹ Алдсан эд хөрөнгийн нөхөн олговрыг тухайн хөрөнгийг шинээр бий болгох өртөг болон газрын эрх шилжүүлэх зэрэг нэмэлт зардлыг тооцон тодорхойлох нь зүйтэй. Амархан үнэлж болохооргүй, эсвэл мөнгөн нөхөн олговор олгох боломжгүй алдагдлын хувьд мөнгөн нөхөн олговор олгох нь зохимжтой байж болох юм. Гэхдээ энэхүү мөнгөн бус нөхөн олговор нь тухайн алдагдалтай тэнцүү, эсвэл илүү үнэ цэнэтэй бараа, нөөц баялаг байж болох ба нөлөөлөлд өртөгчийн уламжлал, зан заншилд тохирсон байдлаар олгогдох ёстой. 7, 14-р зүүлтийг харна уу.

⁶² Амьжиргаа нь цалинд түшиглэсэн орлого ба/буюу хувь хүн, айл өрх, олон нийтийн аливаа нөөц ашигласнаас олох орлогоос бүрдэж болно.

20. Зээлдэгч нь ялангуяа эмэгтэй хүн албан ёсны санхүүгийн байгууллагад хандах боломж ба/эсвэл банкинд данстай байх магадлал бага байдаг улс орон, бүс нутагт нөхөн олговор авах өөр арга болон/эсвэл хэлбэрийг авч үзнэ. Тухайн орны хууль тогтоомж, газар эзэмших тогтолцоо нь эмэгтэйчүүдийн өмч хөрөнгө эзэмших, солилцох эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол, эмэгтэйчүүдийг газар эзэмших боломжоор хангах нөхцлийг бүрдүүлнэ.

Санал гомдлын механизм

21. Зээлдэгч нүүлгэн суурьшуулах үйл явцын үед аль болох эрт үр дүнтэй санал гомдлын механизмыг бий болгоно. Шилжин очсон орон нутгийн иргэд болон/эсвэл нөлөөлөлд өртсөн хүмүүсийн нөхөн олговор, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотойгоор тавьсан асуудлыг цаг тухайд нь хүлээн авч шийдвэрлэхийн тулд ГШ 10-ын зарчмууд болон зорилгыг энэхүү ГШ-тай нийцүүлнэ. Энэ нь хараат бус байдлаар маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай нөөцийг хуваарилах асуудлыг багтаана.

Нүүлгэн суурьшуулах болон/буюу амьжиргааг нөхөн сэргээх үйл ажиллагааны хамрах хүрээ

22. Төсөл боловсруулах үе шатнаас хамааран төсөлтэй холбоотойгоор биет нүүлгэн шилжүүлэлт хийгдэх болон/эсвэл эдийн засгийн хохирол амсах эсэх нь мэдэгдэхгүй байгаа үед газар ашиглах эрхийг хязгаарлах, газар чөлөөлөх асуудлыг нүүлгэн суурьшуулах болон/буюу амьжиргааг нөхөн сэргээх үйл ажиллагааг явуулах хамрах хүрээг тодорхойлно. Энэхүү хамрах хүрээний ерөнхий зарчмууд, журам, нөхөн олговор авах эрхийг тодорхойлох шаардлагууд нь энэ ГШ-тай нийцсэн байна. Бие даасан төслийн бүрэлдэхүүн хэсгүүд тодорхойлогдон, шаардлагатай мэдээллийг авах боломжтой болсон тохиолдолд энэхүү хамрах хүрээг §26-39 дүгээр зүйлд заасны дагуу дэлгэрэнгүй нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааны төлөвлөгөө (НСҮАТ), амьжиргааг нөхөн сэргээх төлөвлөгөө (АНСТ)-г боловсруулахад суурь болгон ашиглана.

Хяналт шинжилгээ

23. Нүүлгэн суурьшуулалт болон амьжиргааг нөхөн сэргээх үйл явцад хийх хяналт шинжилгээ нь ГШ 1-ын дагуу буюу нөлөөлөлд өртсөн олон нийтийн оролцуулсан гол оролцогч талуудын оролцоотой хийгдэнэ.
24. Төслийн нүүлгэн суурьшуулалтын хэмжээнээс хамааран ГШ-ын заалтуудын биелэлтийг хангаж байгааг тодорхойлох үүднээс зээлдэгчид НСҮАТ/АНСТ-ний гүйцэтгэлийн тайланг бэлтгэх нь зүйтэй. Аливаа хөгжлийн санаачилгыг хэрэгжүүлэх үед орсон саналуудыг тусгасны дараа гүйцэтгэлийн тайланг боловсруулж байх шаардлагатай. Тайлан нь зээлдэгчийн гүйцэтгэх цаашдын арга хэмжээг тодорхойлох боломжтой. Ихэнх тохиолдолд, гүйцэтгэлийн тайланд орсон засч залруулах арга хэмжээний биелэлт нь зээлдэгчийг нүүлгэн суурьшуулалт, нөхөн олговор, амьжиргааг нөхөн сэргээх болон хөгжлийн ашиг тусын талаарх хариуцлагаа биелүүлэх нөхцлийг хангадаг.

Нүүлгэн шилжүүлэлт

25. Төсөлтэй холбогдолтой газар чөлөөлөх болон/эсвэл газар ашиглах эрхийг хязгаарлах үйл ажиллагааны дүнд биет нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн

хохирол амсах асуудлууд үүсдэг. Тиймээс биет нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн хохирол учрахтай холбоотой энэхүү ГШ-ын шаардлагуудыг нэгэн зэрэг авч ашиглаж болно. Гэхдээ эдийн засгийн хохирол учрахтай холбоотой тусгай шаардлагууд §36-39-р зүйлд тусгагдсан бөгөөд нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааны төлөвлөгөө буюу хамрах хүрээний баримт бичгүүдэд тус тус тусгасан байх ёстой.

Биет нүүлгэн шилжүүлэлт

26. Хүмүүсийг биетээр нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой тохиолдлыг §6-д дурдсан ба зээлдэгч нөлөөлөлд өртсөн хүн амын тооноос үл хамааран наад зах нь энэхүү ГШ-д заасан холбогдох шаардлагуудыг тусгасан НСҮАТ боловсруулна. Энэхүү төлөвлөгөө нь нүүлгэн шилжүүлэлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, боломжит үр ашгийг тодорхойлох, эмзэг бүлгийн хэрэгцээнд анхаарал хандуулсны дүнд нөлөөлөлд өртсөн хүмүүсийн нөхөн олговор авах эрхийг (түүний дотор хүлээн авагч талын) тодорхойлон гаргаж өгнө. Уг төлөвлөгөөнд газар эзэмших эрх олж авах, мөн нөхөн төлбөрийн арга хэмжээ, шилжүүлэн байршуулах үйл ажиллагаа зэрэг бүхий л үйл явцыг баримтаар тусгана. Мөн нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт, үнэлгээ хийх, шаардлагатай үед засаж залруулах арга хэмжээ авах журмыг тогтооно.
27. НСҮАТ-ны нарийвчлалын түвшин, цар хүрээ нь сөрөг нөлөөллийг бууруулахад шаардлагатай арга хэмжээний төвөгтэй байдал, нүүлгэн шилжүүлэлтийн хэмжээнээс шалтгаалан янз бүр байна. Энэхүү ГШ-ын зорилтуудыг хэрэгжүүлэх арга зам, хэрэгслийг бүхий л нөхцөлд тайлбарласан байх ёстой.
28. НСҮАТ-нд нөлөөлөлд өртсөн хүмүүст хуулийн зөвлөгөө өгөх замаар газраа чөлөөлөхийн өмнө захиргааны шаардлагуудыг хангахад туслах, шаардлагатай бол нөхөн төлбөр олгох шүүхийн шийдвэр гаргуулахад туслах арга хэмжээнүүдийг тусгах ёстой.
29. Зээлдэгч НСҮАТ-г боловсруулахдаа нөлөөлөлд өртсөн хүмүүстэй зөвлөлдөж, тус төлөвлөгөөний тоймыг нийтэд ил болгон, нөлөөлөлд өртсөн хүмүүс нөхөн төлбөрийн журам, төслийн янз бүрийн үе шатанд ямар хүлээлттэй байх, төслөөс тэдэнд юу санал болгох, хариу өгөхөд хэдий хугацаа шаардагдах, санал гомдлын механизм, хэрэв хэлэлцээ амжилтгүй болвол ашиглагдах хууль эрх зүйн журмын талаар ойлголттой байх хэрэгтэй.
30. Хэрэв төслийн бүсэд амьдарч байгаа хүмүүс өөр тийшээ нүүх шаардлагатай бол зээлдэгч, (i) нөлөөлөлд өртсөн хүмүүст нүүлгэн суурьших газрын боломжит хувилбаруудаас сонголт хийхийг санал болгох, үүнд орон байрыг дахин сэлгэх эсвэл зохистой бол мөнгөн нөхөн олговор олгох, (ii) нөлөөлөлд өртсөн хувь хүн/бүлгийн хэрэгцээнд тохирсон нүүлгэн шилжүүлэх тусламж, ингэхдээ ядуу, эмзэг бүлгийн хүмүүсийн хэрэгцээнд илүү анхаарал хандуулна. Боломжит орон байрны болон/буюу мөнгөн нөхөн олговор нь нүүлгэн шилжүүлэлтээс өмнө олгогдоно. Шинээр баригдаж байгаа нүүлгэн суурьшуулах газар нь нөлөөлөлд өртсөн хүмүүст нүүлгэн шилжүүлэлтээс өмнөх амьдралын нөхцөл, амьдралын стандартыг нь сайжруулсан хүртээмжтэй, тогтвортой, зардал багатай боломжуудыг санал болгосон байна.
31. §18-ын (i) эсвэл (ii) зүйлд хамаарах биет нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийн хувьд зээлдэгч ижил эсвэл илүү өндөр үнэтэй өмч хөрөнгө авах

буюу тухайн эд хөрөнгийг дахин бий болгох зардалтай тэнцэх мөнгөн нөхөн олговор авах сонголтыг санал болгоно⁶³.

32. §18-ын (iii)-т хамаарах биет нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийн хувьд зээлдэгч газар эзэмших баталгаат эрхээр хангагдсан, тохиромжтой орон байрны хувилбаруудаас сонголт хийж, хуулийн дагуу нүүн орж, албадан хөөх эрсдэлгүй байх нөхцлийг санал болгоно.
- Хэрэв 60 дугаар зүүлтэд тусгасан нэмэлт мэдээллээр тайлбарласан нөхцөл биш л бол мөнгөн нөхөн олговрын оронд нь мөнгөн бус нөхөн олговрыг санал болгоно. Энэ нь тухайн улс орны хууль тогтоомжийн дагуу хүлээн зөвшөөрсөн зан заншлын болон уламжлалт эрхтэй хүмүүст хамаарна. Тасалбар болгох өдрөөс өмнө газар эзэмших албан ёсны эрхгүй байсан ч тэрхүү газар ба эд хөрөнгийг албан бусаар эзэмшиж⁶⁴ байсан нэхэмжлэгчдэд хамаатай бөгөөд §18 дугаар зүйлд дурдсан мэргэшил чадвараас шалтгаалан байрлаж байгаа газрын хувьд хүлээн зөвшөөрөгдөх хуулийн эрх эсвэл нэхэмжлэх байхгүй хүмүүст мөн хамаатай.
 - Тийм нүүн шилжсэн хүмүүстэй хийсэн зөвлөлдөөнийг үндэслэн зээлдэгч нь тэдэнд нүүн шилжих туслалцааг боломжийн талбайд⁶⁵ өөрсдийн амьжиргааны стандартыг сэргээн босгоход хангалттай хэмжээгээр үзүүлнэ.
33. Хэрэв нөлөөлөлд өртсөн хүмүүс энэхүү ГШ-д нийцсэн нөхөн олговрыг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд үүнээс үүдэн албадан хуулийн дагуу нүүлгэх ажлыг эхлэх ба зээлдэгч холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллах боломжийг эрэлхийлнэ. Хэрэв тухайн төрийн байгууллага зөвшөөрвөл зээлдэгч нь нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлт, хэрэгжилт, мониторинг хийхэд голлох үүрэг хүлээнэ.
34. Нүүлгэн суурьшуулах ажиллагаанд өртсөн хүлээн авагч олон нийтэд учирч болох сөрөг үр дагаврыг зээлдэгч тодорхойлон үнэлгээ өгөх ёстой. Хүлээн авагч хамт олонд тохирсон бууруулах аливаа арга хэмжээг НСҮАТ-нд тусган оруулна.
35. Нутгийн уугуул иргэдийг тэдний хамтран уламжлалт байдлаар ашиглаж ирсэн газраас нь биетээр нүүлгэн шилжүүлэхэд хүрвэл зээлдэгч энэ ГШ болон ГШ 7-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

Эдийн засгийн хохирол амсах

36. Зөвхөн эдийн засгийн хохирол учруулах тухай §6 дугаар зүйлд заасан тохиолдлын хувьд зээлдэгч нь амьжиргааг нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулан

⁶³ Алдагдсан эд хөрөнгөд бэлэн мөнгөөр нөхөн олговрыг олгох нь дараах тохиолдолд зохимжтой байна. Үүнд, (i) аж амьдрал нь газраас олох орлогоос хамаардаггүй, (ii) аж амьдрал нь газраас олох орлогоос хамаардаг ч төсөлд зориулан авсан газар нь тухайн газрын өчүүхэн хэсэг болох бөгөөд үлдсэн газар нь эдийн засгийн ашиг авчрах боломжтой, (iii) газар, орон сууц, хөдөлмөрийн зах зээл сайн хөгжсөн бөгөөд нүүн шилжсэн хүмүүс зах зээлд оролцох боломжтой, мөн эдгээр зах зээлд газар, орон сууцны хангалттай нийлүүлэлт байдаг. Мөнгөн нөхөн олговрын хэмжээ нь алдагдсан газар болон бусад хөрөнгийг орон нутгийн зах зээлээс дахин худалдан авч орлуулан нөхөх бүрэн өртөгт хүрэлцэхүйц байх ёстой.

⁶⁴ Тодорхой нөхцөлтэйгээр хуулиар тогтоосон хугацаанд хөрөнгийг эзэмших замаар бодит хөрөнгийн эрхийг эзэмших арга.

⁶⁵ Хот суурин газарт зөвшөөрөлгүй албан бус суугчдыг нүүлгэн суурьшуулах нь эерэг, сөрөг талтай. Жишээлбэл, нүүн суурьшсанаар айл өрхүүд нь газар эзэмших баталгаат эрхээр хангагддаг ч газрын байршлын давуу талаа алдаж мэднэ.

хэрэгжүүлнэ. Амьжиргааг нөхөн сэргээн төлөвлөгөө нь нөлөөлөлд өртсөн хүмүүс, олон нийтийн хөрөнгийн эрхийг тогтоох бөгөөд эдгээрийг ил тод, тууштай, эрх тэгш байдлаар явуулах нөхцөлийг хангаж өгнө.

37. §6 дугаар зүйлд тодорхойлсон эрх шилжүүлэх төрлүүд нь тухайлбал нөлөөлөлд өртсөн хүнийг биетээр нүүлгэн шилжүүлсэн эсэхээс үл хамааран ажил эрхлэх, эсвэл хөрөнгө бий болгох боломжийг хаах, хязгаарлах, байнгын болон түр зуурын амьжиргаа буюу орлогын алдагдалд хүргэж байвал, зээлдэгч:

- Өмч хөрөнгөө буюу өмч хөрөнгөд хүрэх боломжоо алдсан эдийн засгийн хохиролд өртсөн хүнд яаралтай нөхөн олговор олгох шаардлагатай. Энэ үйл явц нь нүүлгэн шилжүүлэлтийн өмнө хийгдсэн байх ёстой. Хэрэв нөхөн олговрыг засгийн газрын байгууллага төлөх бол зээлдэгч төлбөрийг яаравчлуулахын тулд тухайн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай.
- Газар чөлөөлөлтөөс үүдэн арилжааны объектод нөлөөлөл үзүүлэх тохиолдолд (i) хаа нэгэн газарт аж ахуйн үйл ажиллагааг дахин нээж ажиллуулах зардал, (ii) нүүлгэн шилжүүлэх хугацаанд алдсан цэвэр орлого, ба (iii) үйлдвэр, машин механизм болон бусад тоног төхөөрөмжийг зөөвөрлөж, дахин угсрахад гарах зардлыг нөлөөлөлд өртсөн бизнес эрхлэгчид нөхөн олговор болгон олгох.
- Ижил эсвэл илүү үнэтэй орлуулах эд хөрөнгө (жишээлбэл, хөдөө аж ахуйн ба арилжааны талбай)-ийг гаргаж өгөх, эсвэл зохимжтой бол мөнгөн нөхөн олговрыг тухайн улсын хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөгдсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдөх хууль ёсны эрхтэй, эсвэл нэхэмжлэл бүхий хүмүүст өгөх (§18-р зүйлийн (i), (ii)-т заасны дагуу).
- Олон нийтийн хамтарч эзэмшдэг нөөцийн⁶⁶ алдагдлыг нөхөн олгох туслалцаа олгох. Энэ нь олон нийтийн үлдсэн нөөцийн үр шимийг нэмэгдүүлэх санаачилга, алдагдсан нөөцийг хүртэх хувилбаруудын эх үүсвэрийг бий болгох мөнгөн болон мөнгөн бус нөхөн олговор хэлбэрээр байж болно.
- Хуулиар олгогдсон газрын эрхгүй эдийн засгийн хохирол амссан хүнд газраас бусад нөхөн олговор өгөх (§18-р зүйлийн (iii)-г харах) ба энэхүү олговор нь тухайн хохирлыг бүрэн сэргээх хэмжээнд байна. Зээлдэгч тасалбар болгох өдрөөс хойш ашиг хонжоо олохоор төслийн талбайд суурьшсан хүмүүст нөхөн олговор олгох, туслах шаардлагагүй.
- Нэмэлт зорилтот туслалцаа (жишээлбэл: зээлийн үйлчилгээ, ажил эрхлэх боломж буюу сургалт) болон тэдний орлого олох чадавхи, үйлдвэрлэлийн түвшин, амьдралын стандартыг хэвээр нь хадгалах боломжтой бол, дээшлүүлэх тусламжийг үзүүлэх. Төсөлтэй холбоотой нүүлгэн шилжүүлэлтийн улмаас бизнес доройтох, эсвэл хаагдахад хүрэх тохиолдолд орлого, ажил эрхлэлтээ алдаж байгаа бизнес эрхлэгч болон түүний ажилтнууд энэхүү туслалцааг авах эрхтэй.
- Эдийн засгийн хохирол амссан хүмүүсийн орлого олох чадавхи, үйлдвэрлэлийн түвшин ба амьдралын стандартыг хэвээр нь хадгалах шаардлагатай цаг хугацааны тооцооллыг үндэслэн тэдэнд шаардлагатай бол шилжилтийн үеийн тусламжийг олгох.

38. Зээлдэгч амьжиргааг нөхөн сэргээх төлөвлөгөөнд орсон мэдээллийг тоймлон олон нийтэд ил болгох бөгөөд нөлөөлөлд өртсөн иргэд нөхөн олговрын журмыг

⁶⁶ Үүний жишээнд бэлчээр, гуалин бэлтгэх боломжгүй ой модны нөөц (тухайлбал, эм зүйн ургамал, барилгын болон гар урлалын материал), гуалин бэлтгэх боломжтой ойн эдэлбэр газар ба түлшний мод эсвэл загасчлах газар орно.

ойлгож, төслийн үе шатуудад ямар хүлээлттэй байх вэ гэдгийг мэдэж авахад нь туслана.

39. Төсөлтэй холбоотой газар чөлөөлөлтийн үр дүнд нутгийн уугуул иргэдэд эдийн засгийн хохирол учирсан (гэхдээ шилжин суурьшаагүй) бол зээлдэгч энэхүү ГШ болон ГШ 7-д заасан зарчмуудыг дагаж мөрдөнө.

Олон нийттэй сайн харилцаагаа алдах⁶⁷

Төсөл нь олон нийттэй сайн харилцаагаа алдахад хүрвэл зээлдэгч нь ГШ 10-т заасны дагуу орон нутгийн нөлөөлөлд өртсөн олон нийтийн дунд үр дүнтэй зөвлөлдөөнийг зохион байгуулж, тохирсон хувилбаруудыг тодорхойлж, боломжтой бол харилцан зөвшилцөлд хүрнэ.

Төрийн байгууллагаас удирдан зохион байгуулж буй нүүлгэн суурьшуулах үйл ажиллагаанд хувийн салбарын хүлээх үүрэг, хариуцлага

40. Газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулалт нь хүлээн авагч засгийн газрын хариуцлага байх тохиолдол байж болно. Энэ тохиолдолд зээлдэгч нь энэхүү ГШ-ын зорилгуудтай нийцэх үр дүнд хүрэхийн тулд төрийн байгууллагаас зөвшөөрсөн хэмжээнд засгийн газрын холбогдох байгууллагатай хамтран ажиллана. Үүнээс гадна засгийн газрын чадавхи хязгаардмал тохиолдолд зээлдэгч нь нүүлгэн суурьшуулалтын төлөвлөлт, хэрэгжилт болон мониторинг явуулах ажлуудад гол үүрэг хүлээнэ. Зээлдэгч энэхүү ГШ-ын заалтуудыг хангахын тулд засгийн газрын холбогдох байгууллагаас боловсруулсан баримт бичгийн хамт нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөө (эсвэл хамрах хүрээ) боловсруулна. Зээлдэгч энэхүү төлөвлөгөөнд дараах зүйлүүдийг оруулах хэрэгтэй байж болно. Үүнд, (i) холбогдох хууль, журмын дагуу нөлөөлөлд өртсөн хүмүүсийн эрхийг тодорхойлох, (ii) энэхүү ГШ-ын заалтууд болон энд дурдсан эрхийн хоорондын аливаа орхигдлыг холбосон санал болгож буй арга хэмжээ, ба (iii) засгийн газрын холбогдох байгууллага болон/эсвэл зээлдэгчийн санхүүгийн болон хэрэгжүүлэх хариуцлага орно.

⁶⁷ Соёлын өвийн алдагдлын тухай ГШ 8-д тусгасан.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 6

Биологийн олон янз байдлыг хадгалах, байгалийн амьд нөөцийг тогтвортой ашиглах

Танилцуулга

1. Энэхүү Гүйцэтгэлийн шаардлага (ГШ)-д биологийн олон янз байдлыг⁶⁸ хадгалах, байгалийн амьд нөөцийг⁶⁹ тогтвортой ашиглах явдал нь байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг хангахад тулгуур үүрэгтэй болохыг онцлон авч үзлээ.
2. Энэхүү ГШ нь экосистем болон биологийн олон янз байдлыг тэтгэж буй экологийн суурь үүрэг функцийг хадгалан тордох нь ихээхэн ач холбогдолтой болохыг мөн онцлон анхаарч үзсэн болно. Бүх экосистем нь амьд организмыг тэтгэн тэжээх ба өөрийн баялаг байдал, төрөл зүйлийн онцлогоос хамааран янз бүр байдаг.
3. Биологийн олон янз байдлыг хадгалах, амьд нөөцийг тогтвортой ашиглах асуудлыг биологийн төрөл зүйл, байгалийн амьд нөөцийн эдийн засаг, нийгэм, соёлын олон талын үнэ цэнийг хамгийн оновчтой, үр ашигтай байдлаар гарган ашиглах боломжтой уялдуулах нь зүйтэй.
4. Түүнчлэн, (i) төслийн үйл ажиллагааны улмаас нутгийн уугуул иргэд, нөлөөлөлд өртсөн олон нийтийн биологийн төрөл зүйл, эсвэл байгалийн амьд нөөцийг ашиглах боломж нь хумигдсанаас эдгээр иргэдийн амьжиргаа нөлөөлөлд өртөж болзошгүй, (ii) эдгээр орон нутгийн иргэд биологийн олон янз байдлыг хадгалах, байгалийн амьд нөөцийг удирдан зохицуулахад нааштай үүрэг гүйцэтгэх боломжтой болохыг мөн онцлон авч үзсэн болно.

Зорилго

5. Энэхүү ГШ-ын нь:
 - урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах замаар биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах,
 - биологийн олон янз байдалд цэвэр алдагдал учруулахгүй байх, боломжтой бол цэвэр эерэг нөлөө авчрах зорилгоор нөлөөллийг шат дараатайгаар бууруулах⁷⁰, байгалийн амьд нөөцийг тогтвортой удирдан зохицуулах, ашиглах талаарх олон улсын сайн туршлагыг хөхиүлэн дэмжих зорилготой болно.

⁶⁸ Тус ГШ-д биологийн олон янз байдал гэж Биологийн олон янз байдлын тухай конвенцид «хуурай газар, далай тэнгисийн болон бусад усны экосистемүүд, экологийн цогцолборууд, өөр бусад бүхий л эх үүсвэрүүдийн амьд организмын төрлүүд ба энэхүү ойлголт нь зүйлийн хүрээнд дэх төрөл зүйлүүд ба экосистемийн хоорондын төрөл зүйлийг өөртөө агуулна» хэмээн тодорхойлсныг хэлнэ.

⁶⁹ «Байгалийн амьд нөөц» гэж «зэрлэгээр болон гаршуулсан байдлаар хүний болоод амьтны хэрэглээнд зориулан үржүүлсэн ургамал, амьтан. Үүнд, ой мод, био түлш, нэг наст болоод олон наст ургамал, мал аж ахуй зэрэг хөдөө аж ахуйн холбогдолтой бүхий л төрөл зүйл; байгалийн болоод үржүүлгийн загас, түүний дотор далай, цэвэр усны сээр нуруут, сээр нуруугүй амьтад орно.

⁷⁰ Нөлөөллийг бууруулах үе шатуудад төслийн үйл ажиллагаа эхлэх үеэс байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй тохиолдолд нөлөөллийг багасгах, бууруулах, эцэст нь үүсэж болзошгүй үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн олговор олгох зэрэг арга хэмжээнүүд багтана.

Биологийн олон янз байдлыг хадгалах

Үйлчлэх хүрээ

6. Зээлдэгч өөрийн байгаль орчин, нийгмийн үнэлгээний хүрээнд энэхүү ГШ-ын холбогдох шаардлагууд болон тэдгээрийг төслийг хэрэгжүүлэх нийт хугацаанд хэрхэн биелүүлэх талаар тодорхойлно. Уг ГШ-тай нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд зээлдэгч өөрийн Байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС) болон төслийн онцлогт тохируулан боловсруулсан Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ), түүний дотор Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө (БОЯБМТ), эсвэл тусгайлсан Биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө⁷¹-ий дагуу ажиллаж, тогтсон хугацаанд багтаан энэхүү ГШ-ыг хангахаар төслийг зохион байгуулна. Байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон менежментийн шаардлагын талаар ГШ 1-д тодорхойлов.

Ерөнхий шаардлага

Асуудал болон нөлөөллийн үнэлгээ

7. Үнэлгээг гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй эрсдэл, нөлөөллийн цар хүрээнд нийцэн уялдахуйц байдлаар төслийн талбайн суурь нөхцөл байдлыг тодорхойлно. Суурь судалгаагаар амьдрах орчны⁷² алдагдал, доройтол, хуваагдал, уугуул бус амьтан, шавж давамгайлах, нөөцийг хэт ашиглах, амьтдын нүүдлийн зам, гидрологийн өөрчлөлт, экосистемийн тэжээгдэл, бохирдол, уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицохтой холбоотой нөлөөлөл зэргийг авч үзнэ. Биологийн олон янз байдлын суурь судалгаа болон нөлөөллийн үнэлгээг гүйцэтгэхдээ зээлдэгч холбогдох сайн туршлагатай нийцүүлэн, суурин болоод хээрийн судалгааны аргуудыг ашиглана. Төслөөс үүсэж болзошгүй нөлөөллийн цар хүрээг илүү тодорхой болгох зорилгоор нэмэлт судалгаа шаардлагатай тохиолдолд зээлдэгч нь бууруулах боломжгүй аливаа нөлөөлөл үүсэхээс сэргийлэх үүднээс үйл ажиллагаа явуулахаасаа өмнө нэмэлт арга хэмжээ авч, мониторинг хийнэ.
8. Үнэлгээний үйл явцад, зээлдэгч нь төслийг хэрэгжүүлж эхлэх үеэс төслөөс биологийн олон янз байдалд үзүүлэх боломж, эрсдэл, нөлөөллийг тодорхойлон дүгнэнэ. Үнэлгээний хүрээнд нөлөөллийн эрчим, цар хүрээг тодорхойлон, мөн нөлөөлөлд өртөж болзошгүй олон нийт, бусад талуудын санал бодлыг тусгана. Мөн төслийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй шууд, шууд бус, хуримтлагдах нөлөөллийг авч үзнэ, тэдгээрийг бууруулах арга хэмжээний үр дүн, үндэслэлд дүгнэлт өгнө. Цаашлаад, үнэлгээгээр бүс нутгийн түвшний нөлөөлөл, мөн тухайн

⁷¹ Биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө (БОЯБҮАТ) нь биологийн голлох чухал төрөл зүйл, эсвэл амьдрах чухал орчинд цэвэр эерэг/сөрөг-өөр нөлөөлөхгүй байх үүднээс үлдэгдэл нөлөөллийг бууруулах зорилт, зорилго, менежментийн арга хэмжээг агуулна. Эдгээр зорилт, зорилго нь хэрэгжүүлж, мөн хэмжиж болохуйц байвал зохино. Зорилт бүрийн хүрээнд цуврал арга хэмжээнүүдийг тодорхойлж, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд, эсвэл мониторингийн зорилтууд, хариуцах эзэн, хэрэгжүүлэх хугацааг багтаана. БОЯБҮАТ-г холбогдох талууд, түүний дотор Засгийн газар, хөндлөнгийн мэргэжилтнүүд, орон нутаг болон олон улсын байгаль хамгаалах байгууллагууд, төслийн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдтэй зөвлөлдөн боловсруулна.

⁷² Амьдрах орчин гэж хуурай газар, ус, эсвэл далай тэнгисийн хэсэг, эсвэл амьд организмын идээшин амьдрах агаарын орчин, тэдний амьгүй орчинтой зохицон амьдрах нөхцлийг хэлнэ.

газар нь тусгай хамгаалалттай эсэх, мөн эвдрэл, доройтлын түвшнээс нь үл хамааран экосистемийн цогц байдалд үзүүлэх нөлөөллийг авч үзэх нь зүйтэй.

9. Үнэлгээгээр олон нийт, нутгийн уугуул иргэдийн биологийн төрөл зүйлийн нөөцийг ашиглах боломж нь төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж болзошгүй нөхцөл байдал, цаашлаад үүнээс үүдэлтэй экосистемийн үйлчилгээ, хамаарлыг авч үзнэ. Түүнчлэн, эдгээр экосистемээс төслийн үйл ажиллагаа хэрхэн хамаарах нөхцлийг судална. Төслийн зүгээс эдгээр экосистемд аливаа нөлөөлөл үзүүлж болзошгүй, мөн зээлдэгч нь тухайн төслийг шууд хянаж буй, эсвэл нөлөөлөх боломжтой тохиолдолд төслийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ авна. Хэрэв сөрөг нөлөөллөөс зайсхийх боломжгүй бол зээлдэгч нь тэдгээрийг багасгах, бууруулах арга хэмжээ авч, экосистемийн үйлчилгээ, зохицуулалтыг хадгалах шаардлагатай.
10. Нутгийн уугуул иргэд, орон нутагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй төслүүдийн хувьд зээлдэгч нь байгалийн амьд нөөцийг ашигласнаас олох ашиг тусыг шударга, тэгш хуваалцах боломжийг тэдэнд олгоно. Ингэхдээ, (i) ГШ 5-д заасан эдийн засгийн хохирол амсахтай холбоотой шаардлага, (ii) ГШ 7-д тодорхойлсон нутгийн уугуул иргэдэд үзүүлэх нөлөөллийн асуудлыг зохицуулахтай холбогдсон онцгой шаардлага болон (iii) ГШ 10-т заасан талуудыг оролцуулах шаардлагыг хангасан байвал зохино.

Биологийн олон янз байдлыг хамгаалах шаардлага

11. Үнэлгээгээр төслийн зүгээс биологийн олон янз байдалд нөлөөлөл үзүүлэх нь тогтоогдвол, зээлдэгч нөлөөллийг шат дараатайгаар бууруулах арга болон олон улсын сайн туршлагад тулгуурлан эрсдэлийг бууруулна. Зээлдэгч урьдчилан сэргийлэх байдлаар менежментийн зохицсон арга хэмжээг ашиглана. Үүнд, төслийг хэрэгжүүлэх бүхий л хугацаанд гарах өөрчлөлтүүд болон явуулах мониторингийн үр дүнд зохицсон нөлөөллийг бууруулах менежментийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
12. Дээр зааснаас үл хамааран, төслийн нөлөөлөлд өртсөн зарим нутаг дэвсгэрийг «биологийн чухал төрөл зүйл»⁷³ хэмээн тодорхойлж болох бөгөөд үүнд (i) аюулд өртсөн амьдрах орчин, (ii) эмзэг төрөл зүйл, (iii) талууд, эсвэл Засгийн газраас тодорхойлсноор биологийн чухал төрөл зүйлүүд (тухайлбал, биологийн олон янз байдлын чухал нутаг дэвсгэр, эсвэл шувуудад чухал газар г.м.), (iv) энд тодорхойлсон биологийн голлох чухал төлөр зүйлийг хадгалахад шаардлагатай экосистемийн бүтэц, функцийг тус тус багтаана.
13. Үнэлгээгээр төсөл нь биологийн чухал төрөл зүйлд ихээхэн сөрөг болоод бууруулах боломжгүй нөлөөлөл үзүүлэх нь тогтоогдвол, зээлдэгч дараах нөхцөл байдлаас бусад тохиолдолд төслийн холбогдолтой аливаа үйл ажиллагаа явуулахгүй байвал зохино. Үүнд:
 - техникийн болон эдийн засгийн хувьд боломжит, үндэслэлтэй хувилбарууд байхгүй бол,
 - төслийн нийт ашиг тус биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс илүү гарахаар бол,
 - ГШ 10-ын дагуу талуудтай зөвлөлдөж шийдсэн бол,

⁷³ Биологийн чухал төрөл зүйл гэдэг нь биологийн олон янз байдлын нэг хэсэг бөгөөд эмзэг хэдий ч устаж буй ангиллаас доогуур ангилалд багтах (§14-т тодорхойлсон) төрөл зүйл юм.

- биологийн чухал төрөл зүйлд нөлөөлөл үзүүлэх нь тодорхой ч байгаль орчны холбогдох хууль тогтоомжийн дагуу тухайн төслийг хэрэгжүүлэхээр зөвшөөрсөн бол,
 - холбогдох бууруулах арга хэмжээг нөлөөллийг шат дараатайгаар бууруулах аргын⁷⁴-ын дагуу авч хэрэгжүүлэн, урт хугацаанд биологийн чухал төрөл зүйлийн алдагдалд хүргэхгүй байх, болж өгвөл ашигтай байх, байгаль хамгаалах тал дээр хэмжигдэхүйц үр дүнд хүрэх нөхцлийг хангах төслүүд тус тус орно.
14. Биологийн хамгийн эмзэг төрөл зүйлийг байгальд устаж байгаа ангилалд оруулдаг бөгөөд үүнд (i) дээд зэргээр аюулд өртсөн, эсвэл цорын ганц экосистем, (ii) устаж болзошгүй⁷⁵, эсвэл устаж байгаа төрөл зүйлийн хувьд нэн чухал амьдрах орчин, (iii) зөвхөн тухайн орон нутгийн уугуул, эсвэл газар зүйн хувьд хязгаарлагдмал зөвхөн тодорхой нутаг дэвсгэрт нутагладаг төрөл зүйлд нэн чухал амьдрах орчин, (iv) дэлхий дахинаа ач холбогдол бүхий нүүдлийн, эсвэл бөөнөөр цуглардаг төрөл зүйлд нэн чухал амьдрах орчин, (v) эволюцийн гол үйл явцтай холбоотой нутаг; эсвэл (vi) энэ хэсэгт тодорхойлсон биологийн чухал төрөл зүйлийг хадгалахад ихээхэн үүрэгтэй экологийн үйл явц болдог газар тус тус орно.
15. Үнэлгээгээр тухайн төслөөс устаж буй төрөл зүйлд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй нь тогтоогдвол зээлдэгч хөндлөнгийн туршлагатай мэргэжилтнүүдээр тухайн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлүүлнэ.
16. Устаж буй төрөл зүйлийг экологийн нэгдмэл байдал, биологийн төрөл зүйлийн үнэ цэнэд нөлөөлөх хэмжээнд хүртэл нь хуваах, хувиргах, доройтуулахыг хориглоно. Тиймээс устаж буй төрөл зүйлд чухал амьдрах орчинд дараах нөхцлийг хангаагүй тохиолдолд зээлдэгч нь аливаа төслийн үйл ажиллагаа явуулахгүй байвал зохино. Үүнд:
- тухайн бүс нутагт биологийн олон янз байдлын хувьд ач холбогдол арай багатай төсөл хэрэгжүүлж болохуйц өөр боломжит нутаг дэвсгэр байхгүй,
 - ГШ 10-ын дагуу холбогдох талуудтай зөвлөлдөж шийдсэн,
 - биологийн чухал төрөл зүйлд нөлөөлөл үзүүлэх нь тодорхой ч байгаль орчны холбогдох хууль тогтоомжийн дагуу тухайн төслийг хэрэгжүүлэхээр зөвшөөрсөн,
 - тухайн төсөл §14 дүгээр хэсэгт буюу байгальд устаж байгаа ангилалд орсон биологийн төрөл зүйлд хэмжигдэхүйц сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй,

⁷⁴ Томоохон үлдэгдэл нөлөөлөл хэвээр байгаа тохиолдолд хамгийн эцсийн хэрэгжүүлж болох арга хэмжээ болгон зээлдэгч нь нөхөн төлөх арга хэмжээ авч болох ба үүнд, тухайлбал биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах асуудлыг авч үзэж болох юм.

⁷⁵ Байгаль хамгаалах олон улсын холбоо (IUCN)-ны Ховордсон төрөл зүйлийн Улаан дансанд жагсаасан төрөл зүйлүүд орно. Устаж байгаа төрөл зүйлийг (i) IUCN-ны аргачлалыг ашигладаг улс орнуудад, үндэсний, бүс нутгийн хэмжээнд устаж байгаа эсвэл устаж болзошгүй хэмээн тодорхойлогдсон төрөл зүйлүүдийн хувьд холбогдох туршлага бүхий мэргэжилтнүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр төсөл тус бүрээр устаж байгаа төрөл зүйлүүдийг тодорхойлно, (ii) хэрэв тухайн улсын ашигладаг ангилал IUCN-ны ангилалтай тохирохгүй байх тохиолдолд (зарим улс орнуудад "хамгаалагдсан", эсвэл "хязгаарлагдсан" зэрэг ерөнхий ангиллыг ашиглах нь бий) тухайн ангиллыг ямар үндэслэлээр гаргасан болохыг үнэлж тодорхойлно. Энэ тохиолдолд энэхүү үнэлгээнд үндэслэн устаж байгаа төрөл зүйлийг тодорхойлно.

- нөлөөлөлд өртсөн устаж байгаа төрөл зүйлд цэвэр эерэг нөлөө тус⁷⁶ хүргэхээр төслийг боловсруулсан,
- тодорхой хугацааны туршид⁷⁷ тухайн төслийн үр дүнд устаж болзошгүй болон устаж байгаа төрөл зүйлийн тоо толгой⁷⁸ хорогдохооргүй байгаа,
- устаж байгаа төрөл зүйлийн үнэлгээг гүйцэтгэх зорилготой биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээний урт хугацааны, чанартай хөтөлбөрүүдийг зээлдэгчийн хэрэгжүүлэх менежментийн хөтөлбөрт суулгаж өгсөн байх шаардлага тус тус орно.

17. §16-д заасан шаардлагыг зээлдэгч хангаж чадах тохиолдолд төслийн нөлөөллийг бууруулах стратегийг Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө, эсвэл Биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох байдлаар тусгана.

18. Биологийн чухал болон устаж байгаа төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төслийн зүгээс авахаар төлөвлөсөн тохиолдолд зээлдэгч нь төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан биологийн олон янз байдалд үзүүлэх их хэмжээний үлдэгдэл нөлөөллийг §13 болон §15-17-д заасан шаардлагын дагуу зохих ёсоор бууруулах боломжтой болохыг үнэлгээ хийх замаар нотлох хэрэгтэй. Энэ тохиолдолд тухайн төсөлд дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх талаар мэдлэг, туршлагатай хөндлөнгийн мэргэжилтнүүдийг ажиллуулна.

Хуулиар хамгаалсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн биологийн олон янз байдлын үнэ цэнэ бүхий газар нутаг

19. Хууль болон бусад хэлбэрээр хамгаалагдсан⁷⁹, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн⁸⁰, эсвэл тухайн улс орны Засгийн газраас хамгаалахаар төлөвлөж буй газар нутагт үйл ажиллагаа явуулах, эсвэл тийм газарт сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй төсөл хэрэгжүүлэх тохиолдолд зээлдэгч нь төслийн холбогдолтой нөлөөллийг тодорхойлон үнэлж, тийм газар нутгийн цогц байдал, хамгаалж буй

⁷⁶ Цэвэр эерэг нөлөө тус гэдэг нь устаж байгаа төрөл зүйлд чухал амьдрах орчин хэмээн тодорхойлсон тухайн газар нутгийн биологийн олон янз байдлын үнэ цэнийг нэмэгдүүлэхээр хэрэгжүүлсэн хамгааллын арга хэмжээний нэмэлт үр дүн юм. Цэвэр эерэг нөлөөллийг биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар бий болгож болно. Түүнчлэн, зээлдэгч энэхүү ГШ-ын §16-д заасан шаардлагыг дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ явуулалгүй хангаж чадах тохиолдолд, амьдрах орчныг сайжруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах, хадгалах зорилгоор тухайн газар нутагт аливаа хөтөлбөр хэрэгжүүлэх замаар цэвэр эерэг нөлөөллийг бий болгож болно.

⁷⁷ Тухайн тохиолдол бүрт хөндлөнгийн мэргэжилтнүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр устаж байгаа, мөн устаж болзошгүй төрөл зүйлд төслийн зүгээс "цэвэр сөрөг нөлөө үзүүлээгүй" болохыг батлах хугацаа.

⁷⁸ Цэвэр сөрөг нөлөө гэдэг нь урт хугацаанд дэлхий дахинаа болон бүс нутаг, тухайн улс орны түвшинд төрөл зүйлийн оршин тогтнох боломжийг алдагдуулах хэмжээнд тоо толгой нь хорогдохыг хэлнэ. Цэвэр сөрөг нөлөөллийн цар хэмжээг (дэлхий дахинаа, бүс нутагт, улс үндэстний хэмжээнд) IUCN-ны Ховордсон төрөл зүйлийн Улаан дансанд орсон жагсаалт, эсвэл бүс нутаг, улс орны жагсаалтад тухайн төрөл зүйл багтсан эсэх дээр тулгуурлан тогтооно. Цэвэр сөрөг нөлөөллийн тоо хэмжээг үндэсний болон бүсийн тоо толгойн тооцоон дээр суурилан гаргана.

⁷⁹ Энэхүү ГШ-д «Хамгаалалттай газар»-ын тухай IUCN-ны тодорхойлолтыг удирдамж болгов.

⁸⁰ ЮНЕСКО-ийн Дэлхийн байгалийн өвийн газар, ЮНЕСКО-ийн Хүн ба шим мандлын нөөц газар, Олон улсын ач холбогдол бүхий намгархаг газрын Рамсарын жагсаалт зэрэг олон улсын гэрээ, конвенциор тодорхойлогдсон газар нутаг.

зорилго, биологийн олон янз байдлын ач холбогдлыг алдагдуулахгүйгээр үүсэх нөлөөллийг шат дараатайгаар бууруулна.

20. Хэрэв үнэлгээгээр тухайн төсөл нь хуулиар хамгаалагдсан, эсвэл олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн биологийн олон янз байдлын үнэ цэнэ бүхий газар нутгийн биологийн чухал болон устаж байгаа төрөл зүйлд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй нь тогтоогдвол, зээлдэгч нь §13 болон §15-17-д тус тус заасны дагуу нөлөөллөөс зайлсхийх хэрэгтэй. Түүний дээр, зээлдэгч нь:

- тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт хэрэгжүүлж байгаа аливаа төслөөс үзүүлэх нөлөөллийг тухайн улс орны хууль, тогтоомжоор шаардсаны дагуу нарийвчилсан үнэлгээ гүйцэтгэж тодорхойлсон буюу хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл нь хуулийн дагуу зөвшөөрөгдсөн болохыг нотлох,
- дээр дурдсан тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжүүлж буй төслийн хувьд Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн, аливаа менежментийн төлөвлөгөөний дагуу ажиллах,
- ГШ 10-ын дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлага, эрх бүхий байгууллага, орон нутаг болон бусад талуудтай санал болгож байгаа төслийн талаар зөвлөлдөх,
- шаардлагатай үед, тусгай хамгаалалттай газрыг хадгалан хамгаалах зорилтыг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүлвэл зохино.

Харь амьтан шавж

21. Биологийн олон янз байдалд үлэмж сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй харь амьтан шавжийг уугуул орчинд тохиолдлоор эсвэл санаатайгаар алдах, нутагшуулахаас зайлсхийх. Ялангуяа:

- зээлдэгч нь холбогдох хууль, журмын дагуу зориудаар энэ төрлийн арга хэмжээг аваагүй л бол аливаа харь амьтан шавжийг тэдний өмнө нь байгаагүй нутаг дэвсгэрт санаатайгаар тараан нутагшуулахыг хориглоно. Ямар ч нөхцөл байдалд түрэмгийлэн эзлэх хандлагатай харь амьтан шавжийг шинэ газар нутагшуулах ёсгүй,
- харь амьтан шавжийг⁸¹ санамсаргүй тээвэрлэсэн, алдсан тохиолдолд үүсэх эрсдэл, нөлөөлөл, нөлөөллийг бууруулах арга хэмжээг зээлдэгч тодорхойлсон байх шаардлагатай,
- төлөвлөсөн төсөл хэрэгжих улс орон, бүс нутагт харь амьтан шавж нутагшсан тохиолдолд тэдгээрийг шинэ нутаг дэвсгэрт нэвтрүүлэхгүй байх талаар зээлдэгч хариуцлагатайгаар холбогдох арга хэмжээг авах шаардлагатай. Зээлдэгч өөрийн менежментийн хяналтад байдаг, биологийн олон янз байдлын ач холбогдол бүхий нутаг дэвсгэрээс тийм харь амьтан шавжийг устган зайлуулах арга хэмжээ авах хэрэгтэй.

⁸¹ Бараа ба үйлчилгээний олон улсын усан тээвэрлэлтийн хувьд энэхүү ГШ-д Усан онгоцны усан тохируулагч дайвар болон тунадасны хяналт ба менежментийн тухай олон улсын конвенц (BWM)-ийг удирдлага болгоно. Тийм тээвэрлэлт шаардагдах төсөлд ЕСБХБ-ны санхүүжилт хүсч байгаа зээлдэгч тус конвенцийн хүрээнд тогтоосон үүрэг хариуцлагыг биелүүлэх ёстой.

Байгалийн амьд нөөцийн тогтвортой менежмент

Үйлчлэх хүрээ

22. Энэхүү ГШ нь байгалийн амьд нөөцийн үйлдвэрлэл эрхэлж буй төслүүд, эсвэл байгалийн амьд нөөц гол үйл ажиллагаа нь болж буй төслүүдэд хамаарна.⁸²
23. Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн үнэлгээний хүрээнд энэхүү ГШ-ын холбогдох шаардлагууд болон тэдгээрийг төслийн бүхий л үе шатанд хэрхэн биелүүлэх талаар тодорхойлно. Түүнчлэн, зээлдэгч нь төслийн Байгаль орчин, нийгмийн менежментийн систем болон Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд энэхүү ГШ-ыг биелүүлэх талаар холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. Байгаль орчин, нийгмийн үнэлгээ, менежментийн шаардлагуудыг ГШ 1-д тодорхойлов.

Шаардлага

Нийтлэг шаардлага

24. Зээлдэгч нь байгалийн амьд нөөцийг ашиглахдаа тухайн улс орны хууль, тогтоомжид тусгагдсан шаардлага, ЕХ-ны байгаль орчны стандартыг төслийн түвшинд баримтлана.
25. Зээлдэгч нь олон улс, бүс нутаг, тухайн улс орны хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн холбогдох стандартыг тодорхой цаг хугацаанд нэвтрүүлэн хэрэгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгнө. Байгалийн амьд нөөцийг ашиглах талаар төслийн хувьд дагаж мөрдөх шаардлагатай аливаа стандарт байхгүй тохиолдолд, зээлдэгч нь тухайн салбарын холбогдолтой тогтвортой менежментийн зохих туршлагыг нэвтрүүлэн ашиглах үүргийг хүлээнэ.

Асуудал болон нөлөөллийн үнэлгээ

26. Байгалийн амьд нөөцийг ашиглаж буй төслийн хувьд зээлдэгч нь тухайн нөөцийн тогтвортой байдалд үнэлгээ хийж, эдгээр нөөцтэй уялдаа холбоо бүхий экосистем болон биологийн олон янз байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг анхааралдаа аван, дараах зарчмуудыг баримталж ажиллана. Үүнд:
- аливаа байгалийн амьд нөөцийг ашиглахдаа экосистемид⁸³ гүйцэтгэх тухайн нөөцийн экологийн суурь үүргийг тооцон авч үзэх,
 - шууд, шууд бус, хуримтлагдах нөлөөллийг тооцон авч үзэх,
 - байгалийн амьд нөөцийг ашиглахын өмнө шат дараатайгаар нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах, бусад хэрэглэгчдийн хүртэх ашиг тусыг нэмэгдүүлэхийг хичээх,
 - тухайн газар нутагт уугуул бус, эсвэл нутаг дэвсгэрийг эзлэн авч, тус газрын бусад амьтан, ургамлыг дарангуйлах хандлагатай эсэхийг нь тогтоогоогүй төрөл зүйлийг үйлдвэрлэх, ашиглах явдлыг хязгаарлах, эсвэл зохих судалгаа, холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр үйлдвэрлэл явуулах нь зүйтэй.

⁸² Тариа буудай, мал аж ахуйн үйлдвэрлэл, байгалийн болон таримал модны аж ахуй, загасны аж ахуй, биомасс, биотүлшний үйлдвэрлэл эрхэлж буй төсөл энэ ГШ-д хамаарна.

⁸³ Жишээ нь, ойн мод тайрах, цэвэрлэх явдал нь биологийн олон янз байдал, хөрсний элэгдэл, усны хагалбарын гидрологи, усны чанар, загасны аж ахуйд сөргөөр нөлөөлж болзошгүй. Мөн, нэг төрлийн загасыг хэт их барих нь экологийн тэнцвэртэй байдал, экосистемийн урт хугацааны цогц байдалд нөлөөлж болзошгүй юм.

Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл

27. Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй зээлдэгч нь төслийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, нөөцийн хэрэглээг багасгах үүднээс олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх явдлыг хангах шаардлагатай.
28. Мах, бусад дайвар бүтээгдэхүүн (сүү, өндөг, ноос) үйлдвэрлэх зорилгоор мал өсгөх, нядлах, тээвэрлэх ажил эрхэлж буй зээлдэгч нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн талаарх тухайн улс орны хууль, тогтоомжийн холбогдох шаардлага, ЕХ-ны хөдөө аж ахуйн холбогдох стандарт болон олон улсын сайн туршлагын аль хатуу шаардлагатайг нь авч нэвтрүүлэх ёстой.

Загас болон далайн амьтан, ургамлын үржүүлгийн аж ахуй

29. Загас болон бусад далайн төрөл зүйлийг үржүүлэх, барих, боловсруулах төсөл хэрэгжүүлж буй зээлдэгчид энэхүү байгалийн амьд нөөцийг тогтвортой байдлаар ашиглах эсэхээ нотлох шаардлагатай. Энэхүү шаардлагыг зээлдэгч нь бие даасан мэргэжлийн байгууллагаар баталгаажуулах⁸⁴, эсвэл төслийн үнэлгээг гүйцэтгэх явцад нэмэлт судалгаа хийх байдлаар хэрэгжүүлж болно. Загасны аж ахуй нь зөвхөн загасны үйлдвэрлэлээр хязгаарлагддаггүй. Дахин үржүүлэх, эсвэл өөр төрөл зүйл, популяцийг нутагшуулахдаа (ялангуяа нуур шиг хаалттай орчинд) шинэ зүйл нь одоогийн орон нутгийн загасны төрөл зүйлсийг устгахгүй, тухайн амьдарч буй орчноос нь шахан зайлуулахгүй байх явдлыг хангах ёстой.
30. Далайн амьтан, ургамлыг үржүүлэх төслийн хувьд зээлдэгч нь тухайн газар уугуул бус төрөл зүйл далайн орчинд алдагдах эрсдэлийг үнэлэх, цаашлаад эрсдэлийг багасгах шаардлагатай. Мөн байгаль орчинд өвчин, паразит үүсгэх эрсдэлийг үнэлж, бууруулах хэрэгтэй.

Байгалийн ба таримал ой модны аж ахуй

31. Ойн аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл эрхэлж буй зээлдэгчийн төслийн үйл ажиллагаа нь эдгээр ойн сан бүхий газартай уялдаа холбоо бүхий биологийн чухал болон устаж байгаа төрөл зүйлийг хувиргах, хуваах, эсвэл доройтуулж болзошгүй тохиолдолд экосистем, биологийн олон янз байдалд учруулах нөлөөллөөс зайлсхийх, багасгах, мөн §11, §§13-15-д заасан шаардлагыг хангасан байхаар төслийн үйл ажиллагаагаа төлөвлөх шаардлагатай.
32. Зээлдэгч нь өөрийн удирдлагын дор үйл ажиллагаа явуулан ой мод, ургамал ашиглаж буй төслийн үйл ажиллагаанд олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд болон тогтвортой ойн менежмент⁸⁵-ийн стандартуудыг мөрдөж байгаа болохыг бие даасан байгууллагаар баталгаажуулан гэрчилгээ авсан байх шаардлагатай. Ойн менежментийн үйл ажиллагаа нь холбогдох стандартад нийцэхгүй байгааг үнэлгээгээр тодорхойлсон тохиолдолд зээлдэгч нь тодорхой хугацааны дотор дээрх батламж, гэрчилгээг авах талаар менежментийн төлөвлөгөө гаргаж ажиллана.

⁸⁴ Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрсөн тогтвортой загасны аж ахуйн хөтөлбөрийн хүрээнд Далайн удирдах зөвлөлийн гэрчилгээ олгодог.

⁸⁵ Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрсөн ойн аж ахуйн гэрчилгээний хөтөлбөрийн хүрээнд Ойн удирдлагын зөвлөл (FSC), Ойн гэрчилгээг зөвшөөрөх хөтөлбөр (PEFC) ордог.

Эрчим хүчний зорилгоор биомасс ашиглах болон био түлшний үйлдвэрлэл

33. Биомасс үйлдвэрлэж ашиглаж буй зээлдэгч нь тухайн үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн экосистем, биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ авах, түүний дотор (i) техник, санхүүгийн хувьд боломжтой, зардлын үр ашигтай тохиолдолд үлдэгдэл, хаягдал материалыг биомасс түлш үйлдвэрлэх анхны эх үүсвэр болгох, (ii) ЕХ-ны холбогдох зарчим, стандартыг авч нэвтрүүлэх, шаардлагатай бол үйл ажиллагаагаа тодорхой хугацааны дотор тийм стандартад нийцүүлэх хэрэгтэй.
34. Био түлш үйлдвэрлэх ажиллагаа явуулж буй зээлдэгч нь аж үйлдвэрийн түүхий эд хэрэглэх ба энэ түүхий эдийг экосистем, биологийн олон янз байдалд, мөн эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглагддаг газар, ус, бусад нөөц баялагт учрах сөрөг нөлөөллийг багасгах байдлаар тогтвортой үйлдвэрлэх шаардлагатай. Зээлдэгч нь био түлшний аж үйлдвэрийн түүхий эд үйлдвэрлэх ЕХ-ны холбогдох зарчим, стандарт, удирдамжийг авч нэвтрүүлэх бөгөөд шаардлагатай бол үйл ажиллагаагаа тодорхой хугацааны дотор тийм стандартад нийцүүлэн гэрчилгээ авах хэрэгтэй.

Ханган нийлүүлэлтийн сүлжээ

35. Хэрэв (i) төсөл өөрийн шууд хяналтанд байдаггүй байгалийн амьд нөөцийг ханган нийлүүлэгчдээс авдаг бол, (ii) тэдгээр нөөц баялаг нь төслийн үндсэн үйл ажиллагаанд багтдаг бол, (iii) ханган нийлүүлэгчид нь экосистем, биологийн олон янз байдалд ихээхэн нөлөөлөл үзүүлэхээр байвал, зээлдэгч нь өөрийн байгаль орчин, нийгмийн менежментийн систем, байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд анхан шатны ханган нийлүүлэгчдээсээ дээрх бүтээгдэхүүнийг гэрээлэн авах тогтвортой бодлого, менежментийн үйл явц, шалган баталгаажуулах системийг бий болгох шаардлагатай. Тус системийн хүрээнд:
- зөвхөн хууль ёсны ба тогтвортой гарал үүсэлтэй байгалийн амьд нөөцийг худалдаж авах,
 - байгалийн амьд нөөцийн эх сурвалжид мониторинг хийж баримтжуулах,
 - байгалийн амьд нөөцийн эх сурвалж нь холбогдох экосистем, тусгай хамгаалалттай газар, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн биологийн олон янз байдлын үнэ цэнэ бүхий газар нутгийн экологийн үндсэн функц болон биологийн чухал болон устаж байгаа төрөл зүйлд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх тухай зааж өгөх шаардлагатай.
36. Зээлдэгч нь аль болох тогтвортой хөгжлийн олон улсад хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартад нийцсэн байгалийн амьд нөөцийг худалдан авахыг урьтал болгох шаардлагатай. Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тус салбарт явуулж буй үйл ажиллагааг баталгаажуулах систем байгаа тохиолдолд, зээлдэгч өөрийн ажиллагаа, ханган нийлүүлэлтийн сүлжээний менежментийн системийг энэ төрлийн стандартад тодорхой хугацаанд нийцүүлэн гэрчилгээжүүлэхэд анхаарах бөгөөд олон улсын сайн туршлага, технологийг нэвтрүүлнэ.

Хувиргасан амьд организм (GMOs)

ЕХ-ны улсуудад хувиргасан амьд организм (ХАО)-ыг холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хэрэглэх, байгальд нутагшуулахыг хориглодог. ЕСБХБ-ны

үйл ажиллагаа явуулж буй бусад улс оронд ХАО-ыг ЕХ-ны тодорхой стандартын дагуу зохицуулан, энэ стандартын дагуу эрсдэлийн үнэлгээ хийлгүйгээр ашиглах, байгальд нутагшуулахыг хязгаарлаж болно.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 7

Нутгийн уугуул иргэд

Танилцуулга

1. Энэхүү Гүйцэтгэлийн шаардлага (ГШ)-д нутгийн уугуул иргэд нь төслийн үйл ажиллагаанд оролцох, ашиг тусаас хүртэх замаар өөрсдийн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дээшлүүлэх хүсэл тэмүүлээ биелүүлэх боломжтой хэмээн онцолж байна. Засгийн газар гол төлөв нутгийн уугуул иргэдийн асуудлыг зохицуулах үүргийг гүйцэтгэдэг тул зээлдэгч нь энэ асуудлыг хариуцсан эрх бүхий байгууллагууд болон холбогдох олон нийттэй хамтарч ажиллан төслийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэл, нөлөөллийг зохицуулна.
2. “Нутгийн уугуул иргэд” хэмээх ойлголтыг тайлбарласан нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт байдаггүй. Нутгийн уугуул иргэдийг улс орон бүрт өөр өөр утга санаагаар илэрхийлсэн байж болно. Аль нэг улс орон, бүс нутагт хэсэг бүлэг хүмүүсийг нутгийн уугуул иргэд гэж авч үзэхгүй байхад нөгөө улс оронд эдгээр хүмүүсийг нутгийн уугуул иргэд хэмээн тооцож болно гэдэгтэй энэхүү ГШ санал нийлж байна.
3. Энэхүү ГШ болон тус бодлогын баримт бичигт “Нутгийн уугуул иргэд” гэж тухайн нийгэмд байгаа хүн амын зонхилох бүлгээс ялгаатай нийгэм-соёлыг авч яваа бүлэг хүмүүсийг хэлэх ба тэдгээр нь дараах шинж чанарыг ямар нэг хэмжээгээр агуулж байна. Үүнд:
 - өөрсдийгөө тусдаа ястан, эсвэл соёлын хувьд бусдаас ялгаатай уугуул бүлэг хэмээн тодорхойлдог ба үүнийг бусад нь хүлээн зөвшөөрсөн,
 - төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт газар зүйн хувьд ялгаатай амьдрах орчин, уламжлалт газар нутаг, эсвэл өвөг дээдсээс уламжилж ирсэн нутаг, тухайн амьдрах орчин, газар нутагт⁸⁶ байгаа байгалийн баялагт хамт олноороо татагдан ашиг шим хүртэж амьдардаг,
 - уламжлал ёсоор⁸⁷ цалингүй амьдрах амьжиргааны хэв маягтай (нүүдлийн/бэлчээрийн аж ахуй эрхэлдэг) ба энэхүү хэв маяг нь өөрсдийн ёс заншил, уламжлал, эсвэл тусгай хууль тогтоомжоор зохицуулагдсан хүн амын удам угсаа,
 - уламжлан ирсэн соёл, эдийн засаг, нийгэм болон улс төрийн ёс жаяг нь хүн амын зонхилох хэсгийг хамарсан нийгэм, соёлын ёс журмаас салангид байдаг,

⁸⁶ Төслийн нөлөөлөлд өртсөнөөс үүдэн төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт байрлаж буй газар зүйн хувьд ялгаатай амьдрах орчин, уламжлалт газар нутгийн байгалийн нөөцөөс ашиг тус хүртэх боломжоо хүчээр алдсан тохиолдолд энэхүү ГШ-ын заалтууд мөн үйлчилнэ. Ашиг тус хүртэх боломжоо хүчээр алдах тохиолдлуудад аливаа зөрчил маргаан үүсэх, газар зүйн хувьд ялгаатай амьдрах орчин, уламжлалт газар нутгаас Засгийн газраас явуулж буй нүүлгэн суурьшуулалтад өртөн нүүх, газраа эзэмших эрхээ алдах, байгалийн гамшигт өртөх, тухайн газрыг хот суурины зориулалтаар ашиглахаар шийдвэрлэсэнээс тухайн газраас ашиг тус хүртэж чадахгүйд хүрэх тохиолдлууд орно. Энэ ГШ-д "хот суурины газар" гэдэгт хот буюу томоохон суурин газар/тосгоныг ойлгох ба мөн дараах шинжүүдийг агуулна (аль нэг шинжээр хот сууриныг дангаар тодорхойлохгүй). Үүнд, (i) тухайн орны хууль тогтоомжийн дагуу хот суурин газарт багтсан, (ii) хүн амын нягтрал өндөр, (iii) хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай харьцуулахад хөдөө аж ахуйн бус эдийн засгийн үйл ажиллагаа давамгайлсан шинж чанарууд орно.

⁸⁷ Өмнө тайлбарласанчлан, уламжлал нь одоо орхигдсон байсан ч энэ ойлголт үйлчилнэ.

- тухайн улс орон эсвэл бүс нутгийн албан ёсны хэл, нутгийн аялгаас өөр ялгаатай хэл, нутгийн аялгаар ярих шинж чанарууд багтана.
4. Нүүдлийн, эсвэл бэлчээрийн аж ахуйд тулгуурласан амьдралын хэв маягтай байсан нэг хэсэг бүлэг хүмүүс, эсвэл тэдний гишүүд холимог орчин буюу хот газар амьдарч, өөрийн уламжлалт нутаг оронд улирлын чанартай очдог байвал энэхүү ГШ-ыг хангах шаардлагыг үгүйсгэх шууд шалтгаан болохгүй.
 5. Энэ ГШ нь нутгийн уугуул иргэдийг түнш хэмээн хандаж, тэдний үнэт зүйлс нь өөрсдийнх нь болон улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулах боломжтой ард түмэн гэж хүндэтгэн үзнэ. Гэхдээ энэхүү ГШ-д нутгийн уугуул иргэд нь тухайн нийгэм дэх үндсэн бүлгүүдээс ялгагдаж, хүн амын хамгийн орхигдсон, нийгмийн эмзэг бүлэгт багтаж байж болзошгүй гэдэгтэй санал нийлж байна. Нутгийн уугуул иргэдийн эдийн засаг, нийгэм, эрх зүйн байдал нь ихэвчлэн газар, байгалийн болон соёлын нөөц дэх өөрсдийнх нь ашиг сонирхол, эрхийг хамгаалах (хувь хүн болон/буюу хамтын аль аль нь байж болох юм) чадавхийг нь хязгаарладаг бөгөөд хөгжлийн үйл ажиллагаанд оролцох, ашиг тус хүртэх боломжийг нь бас хязгаарладаг талтай. Тэдний газар нутаг, нөөц баялгийг бусад хүмүүс зөвшөөрөлгүй ашиглах, эзэмших тохиолдолд нутгийн уугуул иргэдийн нөхцөл байдал улам эмзэг болдог.
 6. Энэхүү ГШ нь нутгийн уугуул иргэдийн нэгдмэл шинж чанар, соёл, газар нутаг болон нөөц баялаг нь хосгүй уялдаа холбоотой бөгөөд тухайн орчинд хийгдэх зарим хөрөнгө оруулалтын үр нөлөөнөөс тэдний хэл, соёл, шашин шүтлэг, итгэл үнэмшил, ёс журамд аюул учирч болзошгүй болохыг хүлээн зөвшөөрч байна. Энэ төрлийн үйл ажиллагаанаас шалтгаалан нутгийн уугуул иргэдийн нэгдмэл шинж чанар, соёл, байгалийн баялагт суурилсан амьжиргаа алдагдах, мөн ядуурал, өвчинд нэрвэгдэх зэрэг янз бүрийн эрсдэл, хатуу ширүүн нөлөөлөлд өртөж болзошгүй юм. Цаашлаад, нутгийн уугуул соёлд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд болон хүүхдийн үүрэг нь хүн амын зонхилох бүлгүүдээс өөр байж болох, мөн нутгийн уугуул иргэдийн зан заншил, нийгмийн орчинд болон нийгмийн илүү өргөн хүрээнд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд ялгаатай хандаснаас үүдэн ялгаварлан гадуурхах асуудлууд үүсэж болзошгүй болохыг тус ГШ-ын хүрээнд мөн онцолж байна. Хүүхдийн байр сууринаас авч үзвэл хүүхдүүд өөрийн эмзэг нөхцөл байдлаас шалтгаалан үл тоомсорлогдох, нутгийн уугуул иргэний хувьд мөн адил ялгаварлан гадуурхагдаж болзошгүй юм. Эдгээр нөхцөл байдлын улмаас нутгийн уугуул иргэдийн асуудлууд байнга төвөгтэй байдаг. Түүнээс гадна хүн амын зонхилох хэсгийн дунд тархсан соёл нь тодорхой бүлэг хүмүүсийн дунд тогтсон нутгийн уугуул байр суурийг зарим үед хүлээн зөвшөөрөх дургүй эсвэл зарим нь мэдээгүй байж болно. Тиймээс нутгийн уугуул эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийг хохироохгүй, тэднийг Банкны дэмжлэгтэй төслүүдээс зохих ёсоор ашиг тус хүртэх явдлыг хангахын тулд тусгай арга хэмжээг авах шаардлагатай.
 7. Энэ ГШ нь ЕСБХБ-ны үйл ажиллагаа явуулж байгаа улс орнуудын нутгийн уугуул иргэд нь түүхийн уламжлалаасаа хамааран онцлог болохыг хүлээн зөвшөөрч байна. Нутгийн уугуул иргэд дан ганц уламжлалт аж амьдрал, амьдралын хэв маягаар өвөрмөц байдлаа хадгалж чадахгүй бөгөөд хэвшсэн амьдралын хэв маягаа дангаараа удаан хугацаанд авч явж чадахгүй. Цаашилбал тус ГШ нь нутгийн уугуул иргэд ихэвчлэн холимог угсаатны суурин газарт амьдарч байгааг анхааран үзлээ. Нүүдэлчний тогтсон уламжлал, бэлчээрийн мал оторлолт, албадан нүүлгэн суурьшуулалтын туршлагаас харахад асуудлыг зөвхөн тодорхой нутаг дэвсгэртэй шууд холбон үзэх нь тэр бүр оновчтой шийдэл биш гэдгийг харуулж

байна. Энэ ГШ-д нутгийн уугуул иргэдийн амьдралын арга барил, амьжиргааны хэв маяг нь хүн амын зонхилох хэсгийн дунд тархсан соёлоос нилээд ялгаатай байж болох ба цаг хугацааны явцад өөрчлөгдөж болохыг мөн анхааран авч үзсэн болно.

Зорилго

Энэхүү ГШ-ын зорилго нь:

- шилжилтийн үйл явц нь нутгийн уугуул иргэдийн нэр хүнд, хүндэтгэл, хүний эрх, хүсэл тэмүүлэл, соёл болон байгалийн нөөц дээр суурилсан амьжиргааны байдлыг дэмжих,
- нутгийн уугуул иргэдийн аж амьдрал, амьжиргаанд үзүүлэх төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ба зайлхийх, хэрэв зайлхийлэх боломжгүй бол түүнийг багасгах, бууруулах эсвэл нөхөн олговор төлөх,
- төслийн үр дүнд бий болох ашиг тусаас хүртэх боломжийг нутгийн уугуул иргэдэд олгох, энэхүү боломжийг тэдний уламжлал, зан заншилд тохируулан бий болгох,
- төслийн бүхий л үйл ажиллагааны хугацаанд төслийн нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдтэй байнгын харилцаа тогтоон хадгалахад зээлдэгчид дэмжлэг үзүүлэх,
- нутгийн уугуул иргэдийн ашигладаг уламжлалт газар нутаг дээр төсөл хэрэгжих, уламжлалт, уламжлалт бус амьжиргаа нь төслийн нөлөөлөлд өртөх, нутгийн уугуул иргэдийн соёлын нөөцийг арилжааны зориулалтаар ашиглах тохиолдлуудад нутгийн уугуул иргэдтэй зээлдэгч нь харилцан сайн итгэлцлийн хэлэлцээ хийж тэдний оролцоог хангах шаардлагатай.
- төслийн⁸⁸ сөрөг нөлөөлөлд өртөх нутгийн уугуул иргэдийн эмзэг байдлыг бодолцон, §30-34-д заасан буюу нутгийн уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын тунхаглалд⁸⁹ тусгасан төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийг мэдээллээр урьдчилан хангаж оролцуулах шаардлагыг хангах,
- төслийн зүгээс жендерийн хувьд гарч болох сөрөг нөлөөллийг бууруулах болон жендерийн асуудлыг шийдвэрлэх замаар нутгийн уугуул иргэдийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдийн тусгай хэрэгцээг хүлээн зөвшөөрөх,
- нутгийн уугуул иргэдийн уламжлалт хууль, ёс заншлыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх хийгээд тэдгээрийг бүрэн анхааралдаа авах,
- нутгийн уугуул иргэдийн хүсэлтийн дагуу тэдний соёл, мэдлэг, туршлагыг хүндэтгэн хамгаалах асуудлууд болно.

Үйлчлэх цар хүрээ

9. Төсөл нутгийн уугуул иргэдэд нөлөөлж болзошгүй тохиолдолд энэ ГШ-ын заалтуудыг ханган ажиллана. Энэхүү ГШ-д зориулан тодорхой нэг бүлгийг нутгийн

⁸⁸ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 169 дүгээр конвенц (Уугуул болон омог аймгийн иргэдийн тухай конвенц)-д уугуул иргэдтэй холбоотой өргөн хүрээний асуудлууд орсны дотор газар нутаг, ажил эрхлэлт, эрүүл мэнд, нийгмийн халамж, ёс заншил, хууль зэрэг орж байна. Конвенцийн гол агуулга нь зөвлөлдөх, оролцоог нь хангах тухай юм.

⁸⁹ 2007.09.13-нд баталсан Уугуул ард түмний эрхийн тухай НҮБ-ын Ерөнхий ассамблейн тунхаглал.

уугуул иргэд гэж үзэх эсэхийг баталгаажуулах үүднээс зээлдэгчид мэргэжилтнүүдийн зөвлөгөө авах шаардлага үүсэж болно.

10. Энэхүү ГШ-ын заалтуудад биелүүлэх эсэхийг дээрх §2-7 зүйлд дурдсан шалгуурын дагуу байгаль орчин, нийгмийн үнэлгээний явцад тодорхойлно. Тус ГШ-ын заалтуудыг хангах үүднээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг энэ ГШ болон ГШ 1, 5, 8, 10-тай уялдуулна.

Шаардлага

11. Нутгийн уугуул иргэд өртөх магадлалтай⁹⁰ төслүүдийн хувьд зээлдэгчийн зүгээс нутгийн уугуул иргэдэд учирч болох нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагатай. Энэ үнэлгээний үр дүнгээс шалтгаалан зээлдэгч эхлээд сөрөг нөлөөллөөс зайлсхийх оролдлого хийх бөгөөд боломжгүй тохиолдолд сөрөг нөлөөллийг багасгах ба/буюу бууруулах, төслөөс гарах ашиг тусыг тодорхойлох үүднээс 19-р зүйлд тусгагдсан нутгийн уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулна. Зээлдэгч нь нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийг мэдээллээр ханган зөвлөлдөж үйл ажиллагаандаа оролцуулах ба санал гомдлыг барагдуулах тодорхой механизмыг бий болгох, тохирсон нөхөн олговрын багц болон олон нийтэд төслөөс ашиг тус хүртэх боломжийг тодорхойлох арга хэмжээ авна. Зөвлөлдөх үед зээлдэгч нь нутгийн уугуул иргэдийн амьдарлын хэв маяг зарим тохиолдолд улирлын нүүдлийн шинж чанартай болохыг анхааран үзэж нутгийн уугуул иргэдэд үзэл бодлоо илэрхийлэх хангалттай цаг хугацааг олгох байдлаар тэдний саналыг төслийг төлөвлөх асуудалд тусгавал зохино.
12. Зээлдэгч нутгийн уугуул иргэдэд нөлөөлсөн эсвэл нөлөөлж болзошгүй төслийн ажиллагааг эхлүүлсэн бол дээр дурдсан үнэлгээнд энэхүү ГШ-ын биелэлтийг хангахад шаардлагатай аливаа (i) орхигдсон болон (ii) засаж залруулах арга хэмжээ байгаа эсэхийг тусгана. Ингэснээр холбогдох Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байх шаардлагатай.
13. Зээлдэгчийн байгууллагад зохих нөөц, чадвар байхгүй бол туршлагатай, бие даасан нийгмийн мэргэжилтнүүдийн зөвлөгөөг төслийг боловсруулах болон хэрэгжүүлэх бүхий л хугацаанд авах нь зүйтэй.

Үнэлгээ

14. Энэхүү ГШ-д заасан нэмэлт нийгмийн үнэлгээг гүйцэтгэхээс гадна тухайн улс орны хууль, тогтоомжийн дагуу тодорхой төрлийн нийгмийн үнэлгээ хийх шаардлага тавигдсан бол зээлдэгч нь энэ шаардлагыг биелүүлнэ.
15. Төсөл эхлээгүй байгаа тохиолдолд зээлдэгч нь нийгмийн үнэлгээгээр дамжуулан төсөлд шууд ба шууд бусаар, мөн эерэгээр болон сөргөөр нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн уугуул иргэдийн бүлгийг тодорхойлох, мөн тэдэнд учирч болзошгүй нийгэм, соёлын (соёлын өвийг оруулан), байгаль орчны нөлөөллийг тогтооно. Энэ үнэлгээ нь хүрээлэн буй орчин, амьдралын хэв маягт үүссэн өөрчлөлтөд өртөх нутгийн уугуул олон нийтийн эмзэг байдлыг тооцон авч

⁹⁰ Нийгэм-эдийн засгийн байдал ба/эсвэл уламжлалт соёл болон амьдралын хэв маяг нь төслийн нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийг төслийн нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэд гэнэ.

үзэхийн зэрэгцээ зээлдэгч нь (i) сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, (ii) төсөлтэй холбоотой аливаа ашиг тусыг хуваалцах талаар арга хэмжээг төлөвлөнө.

16. Төлөвлөж буй төслийн хувьд барилгын ажил, төсөлтэй холбоотой үйл ажиллагаа, хэрэгжилт эхэлсэн тохиолдолд зээлдэгч эрх бүхий байгууллагад холбогдох бүх мэдээлэл, бичиг баримтыг (зээлдэгчийн өнгөрсөн хугацаанд явуулсан төслийн гүйцэтгэлийн хамтаар) өмнө нь явуулсан баримт бичгийн тайлангын хамт бэлдэж өгөх бөгөөд тэдгээр нь зээлдэгч төсөлд өртсөн нутгийн уугуул иргэдийн санал бодол дээр үндэслэн ажилласан ба боломжийн хэрээр энэ ГШ-д тусгасан үйл явцыг дагаж мөрдсөнийг харуулах юм.
17. Хэрэв §16 зүйлийн шаардлагыг хангаагүй бол зээлдэгч төслийн талаар нутгийн уугуул иргэдэд үзүүлэх нөлөө, төслийн талаарх тэдний санал бодлыг тусгасан бодитой, бие даасан судалгаа явуулна. Энэхүү судалгааг уламжлал, зан заншилд нийцсэн байдлаар явуулах бөгөөд нутгийн уугуул иргэдийн амьжиргаа, амьдралд үзүүлж байгаа үр нөлөө, сөрөг нөлөөллийг бууруулах зээлдэгчийн хүчин чармайлт, мөн төслийн ашиг тусыг хуваалцаж буй байдал болон төслийн төлөвлөлт, хэрэгжилт дэх нутгийн уугуул иргэдийн оролцооны түвшин зэргийг хянаж нягтлах болно.

Сөрөг нөлөөнөөс зайлсхийх

18. Бүх чармайлт юуны өмнө нутгийн уугуул иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийхэд чиглэгдэх ёстой. Хэрэв сөрөг нөлөөллөөс зайлсхийх боломжгүй бол зээлдэгч тэр нөлөөллийг багасгах, бууруулах эсвэл зохистой, шударга байдлаар эдгээр нөлөөллийг тооцож нөхөн олговор олгоно.

Нутгийн уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах

19. Сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах, нөхөн олговор олгох, төслөөс хүртэх ашиг тусыг тодорхойлон хуваалцах зэрэг зээлдэгчийн санал болгож буй арга хэмжээнүүдийг нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийг урьдчилан мэдээллээр ханган оролцуулж хамтран тодорхойлох ба хэрэгжүүлэх хугацааг заасан нутгийн уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөө, эсвэл нутгийн уугуул иргэдийн асуудлыг тусгайлан бүлэг болгон оруулсан олон нийтийн хөгжлийн илүү өргөн хүрээний төлөвлөгөөнд тусган оруулах шаардлагатай. Зээлдэгч нутгийн уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөөг бэлтгэх холбогдох техникийн зохих мэдлэгтэй, туршлагатай, мэргэшсэн нийгмийн салбарын ажилтнуудыг авч ажилуулна. Нутгийн уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөө нь жендерийн хамаарал, өөр өөр насны хүн амын асуудлыг хамруулсан төслийн ялгаатай нөлөөллийг үнэлэх ба олон нийтийн бүлгүүдэд дээрх асуудлаар гарах нөлөөллийг шийдвэрлэх арга хэмжээг багтаасан байна.

Нутгийн уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөөний хамрах хүрээ болон нарийвчилал нь төслийн шинж чанар, төслийн үйл ажиллагааны цар хүрээнээс хамааран өөр өөр байна. Ерөнхийдөө нутгийн уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөө нь дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1-р хэсэг – Нийгмийн үнэлгээний тойм

- Суурь мэдээлэл: Нутгийн уугуул иргэдийн нийгмийн бүтэц болон өрхийн дотоод үүрэг, хариуцлагын талаарх ойлголтыг энэхүү суурь мэдээлэлд тусгах нь чухал. Энэ нь тохирсон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад туслах болно.
- Гол дүгнэлтүүд: нөлөөлөл, эрсдэл, боломжид хийсэн дүн шинжилгээ.

2-р хэсэг – Зөвшилцөл ба оролцоо

- Зөвлөлдөөний үр дүн ба цаашид явуулах зөвлөлдөх ажлын төлөвлөгөө.

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

- Сөрөг нөлөөллөөс зайлсхийх, багасгах, бууруулах арга хэмжээ ба эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх арга хэмжээ.
- Олон нийтэд тулгуурласан байгалийн нөөцийн менежментийг үргэлжлүүлэн хангах арга хэмжээ.
- Төслөөс бий болох ашиг тус болон/эсвэл боломжоос хүртэх арга хэмжээнд оролцох.
- Санал гомдлын механизм.
- Арга хэмжээг хэрэгжүүлэх зардал, төсөв, цаг хугацаа ба зохион байгуулах үүрэг, хариуцлага.
- Мониторинг, үнэлгээ ба тайлагнах ажлууд.

Мэдээллийг ил тод болгох, үр дүнтэй зөвлөлдөх ба мэдээллээр хангасан оролцоо

20. Зээлдэгч төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх хугацаанд аль болох эртнээс нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийн бүлгүүдтэй байнгын харилцааг бий болгох шаардлагатай. Үр дүнтэй оролцооны үйл явц нь нөлөөллийн мөн чанар, хугацаа, шууд нөлөөлөх асуудлаар мэдээллээр ханган оролцуулах, санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ, хөгжлийн үр ашиг, боломжийг хуваалцах, болон төслийн хэрэгжилтийн асуудлаар талаар ижил ойлголтонд хүрэх явдлыг хангана.
21. Зээлдэгч нь төсөлд өртсөн нутгийн уугуул иргэдэд холбогдох ГШ-ууд, мөн тэдэнд нөлөөлж болох төслийн төлөвлөгөөний талаар иргэдийн уламжлал, зан заншилд тохирсон байдлаар олон нийтийн бүхий л бүлгийг үр дүнтэй оролцуулан мэдээллээр хангана.
22. Олон нийтийн оролцооны үйл явцыг нутгийн уугуул иргэдийн соёл, зан заншилд тохирсон, тэдний шийдвэр гаргах үйл явцад хүндэтгэлтэй, үзүүлж болзошгүй эрсдэл, нөлөөллийн цар хүрээтэй уялдсан байхаар зохион байгуулна. Зээлдэгч нь оролцооны үйл явцыг зохих ёсоор хангаж байгааг баталгаажуулсан баримт нотолгоог харуулна.
23. Тухайлбал, оролцооны үйл явцад дараах арга хэмжээ багтана. Үүнд:
 - нутгийн уугуул иргэдийн төлөөллүүд, нутгийн уугуул иргэдийн байгууллагууд (тухайлбал, өндөр настны зөвлөл, тосгоны зөвлөл болон бусад), мөн нөлөөлөлд өртсөн хувь хүмүүсийн оролцоог хангах,
 - уламжлалт хууль, тогтоомжийг ойлгож хүндэтгэх,
 - нутгийн уугуул иргэд хамтаар шийдвэр гаргахад нь хангалттай хугацаа олгох,

- нутгийн уугуул иргэдийн сонгосон хэл дээрх өөрсдийн санал бодол, асуудал, саналыг гадны заль мэх, хөндлөнгийн оролцоогүй, ямар ч сүрдүүлэггүй, зан заншилд нийцсэн байдлаар илэрхийлэхэд нь дэмжлэг үзүүлэх,
- нутгийн уугуул иргэдэд нөлөөлж болзошгүй нийгэм, экологийн нөлөөллийн талаар холбогдох бүх төлөвлөгөө, мэдээллийг тэдний уламжлал, зан заншилд нийцсэн байдлаар ойлгомжтой хэлээр мэдээлж тайлбарлах,
- дараах асуудлуудыг бодолцон олон нийтийн бүлгүүдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, үүнд:
 - нутгийн уугуул иргэд уугуул бус хүмүүстэй хамт амьдардаг,
 - нутгийн уугуул иргэд олон үзэл бодолтой ба зөвлөлдөөн, оролцооны арга хэмжээнд бүхий л насны, хүйсийн болон нийгмээс тусгаарлагдсан бүлгүүдийг татан оруулах ёстой,
 - холбогдох мэдээллийг ЕСБХБ-д хүргүүлэх, боломжтой бол зөвлөлдөх үйл явцад ЕСБХБ-ыг оруулах асуудлууд орно.
- зөвлөлдөөний үйл явцыг бүрэн баримтжуулах⁹¹ арга хэмжээ орно.

Санал гомдлын механизм ба үндэс угсаанаас шалтгаалсан ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх

24. Зээлдэгч нь ГШ 10-д заасны дагуу төсөлтэй холбоотой санал гомдлыг барагдуулах механизмыг бий болгох шаардлагатай ба энэхүү механизм нь нутгийн уугуул иргэдийн уламжлал, зан заншилд тохирсон, гомдол гаргахад хялбар хүртээмжтэй байх ба албан байдлаар бичигдсэн дүрэм, журамд бага тулгуурласан, харин гол төлөв амаар харилцдаг байхаар зохион байгуулагдсан байх нь зүйтэй.
25. Банкны санхүүжилттэй төслүүдэд нутгийн уугуул иргэд төслөөс бий болох ашиг тусаас хүртэх боломжийг хассан, тухайлбал үндэс угсаанаас хамааран ажил эрхлэх боломжийг алдагдуулж байгаа бол төслийн үйл ажиллагаанд дараах засч залруулах арга хэмжээг багтаана. Үүнд, (i) нутгийн уугуул иргэдийн байгууллага, хувь хүнд хөдөлмөрийн, нийгмийн, санхүүгийн болон бизнесийн хууль тогтоомжийн дагуу тэдний эдлэх эрх болон байгаа тусламж эрэх механизмын тухай мэдээлэх, (ii) зээл, ажил эрхлэлт, бизнесийн үйлчилгээ, эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээ, мөн төслүүдээс үүсэх бусад ашиг тус, баялгийг хүртэхэд саад, хорио болж байгаа зүйлсийг зохих, үр дүнтэй байдлаар мэдээлэл түгээх, сургалт явуулах зэрэг арга хэмжээгээр дамжуулах үгүй хийх, (iii) нутгийн уугуул ажилчид, бизнес эрхлэгчид болон ашиг хүртэгчдэд тухайн улсын хууль тогтоомжоор ижил төстэй салбар, нөхцөл байдалд байгаа хувь хүнд олгодогтой адил хамгаалалтыг олгох, ингэхдээ хүйсийн асуудал болон бараа, хөдөлмөрийн зах зээлд үйлчилж буй үндэс угсаагаар хуваах, хэлний хүчин зүйлийг анхааралдаа авах асуудлууд орно.

Нөхөн олговор ба ашиг тусыг хуваалцах

26. Оролцооны арга зам нь нөлөөллийг бууруулах, ашиг тусыг хуваалцах, уламжлалт амьдралын хэв маягийг дэмжих арга хэмжээг тодорхойлох үндэс суурь юм. Нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийн аж амьдрал төслийн үйл ажиллагаанаас үүдэн аливаа алдагдал, хохирол (энэ ГШ-ын дагуу тооцсон) амсах тохиолдолд Банк нь зээлдэгчээс шууд нөхөн олговор олгох, мөн нутгийн уугуул

⁹¹ Эдгээр нь бичсэн бичлэг ба тэмдэглэл ба/эсвэл дуун бичлэгийг багтааж болно.

иргэдтэй зөвлөлдсөний үндсэн дээр амьжиргааг нөхөн сэргээх арга хэмжээ авахыг шаардана. Нөхөн олговрыг хувь хүнд, хамт олонд, эсвэл тэдний дунд олгож болно. Нөхөн олговрыг уламжлалт аж амьдралд үзүүлэх сөрөг нөлөө, мөн цалин хөлс, ашиг орлого авчирдаг эдийн засгийн үйл ажиллагааны алдагдалд олгоно. Уламжлалт аж амьдрал хэмээх ойлголтыг өргөн хүрээнд авч үзэх нь зүйтэй (орчин үеийн угсаатны аялал жуулчлал, хүнсний үйлдвэрлэл зэрэг). Нөхөн олговрын хэмжээг тооцоолохдоо зээлдэгч нь төслийн үйл ажиллагаанаас уламжлалт аж амьдрал болон нутгийн уугуул иргэдийн гэр бүлд үзүүлэх нийгмийн сөрөг нөлөөллийг сайтар тооцон үзэх шаардлагатай. Мөн нөхөн олговрыг тодорхойлохдоо нутгийн уугуул иргэдийн төлөөлөл болон холбогдох мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх нь зүйтэй. Зээлдэгч нь орон нутаг болон бүсийн эрх бүхий байгууллагад нөхөн олговор олгох тохиолдлуудад мөн энэ заалт үйлчилнэ.

27. Хуулийн үндэслэлтэй, тохирсон нөхөн олговрыг олгох асуудал болон нутгийн уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөөний талаар нутгийн уугуул иргэдтэй хийх зөвлөлдөөний үеэр авч хэлэлцэнэ. Эдгээр зөвлөлдөөний үр дүнг үндэслэн нөхөн олговор болон нөөцийг нутгийн уугуул иргэд, байгуулахад олгох, шилжүүлэх механизмыг боловсруулан тохиролцоно. Газар, эсвэл нөөцийг нутгийн уугуул иргэд, байгууллага хамтран эзэмшиж байгаа тохиолдолд нөхөн олговор болоод нөөцийг бөөнд нь хамтран эзэмшиж буй талуудад шилжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд эдгээр нөөцөд менежмент хийх засаглалын тогтолцоог бий болгоход нь зээлдэгч нутгийн уугуул иргэдэд дэмжлэг үзүүлж болно.
28. Зээлдэгч үр дүнтэй зөвлөлдөөн болон нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийн бүлгүүдэд мэдээлэл хүргэн оролцуулах замаар дээрх §20-23-д заасан уламжлал, зан заншилд нь тохирсон байдлаар нутгийн уугуул иргэдийг төслөөс ашиг тус хүртэх боломжоор хангана. Энэхүү боломж нь төслөөс үзүүлэх нөлөөллийн цар хүрээтэй уялдсан, нутгийн уугуул иргэдийн амьжиргааны түвшин, аж амьдралыг зохистой хэв маягаар дээшлүүлсэн, мөн нутгийн уугуул иргэд ашиглан амьжиргаагаа залгуулан авч явж байж болзошгүй байгалийн нөөцийн урт хугацааны тогтвортой байдлыг дэмжихэд чиглэгдсэн байвал зохино. Зээлдэгч нь энэ ГШ-ын шаардлагын дагуу, төслөөс үүдэн бий болох хөгжлийн ашиг тусыг баримтжуулж, энэ мэдээллээр цаг тухай бүрт хангаж байна. Уламжлалт аж амьдралын үйл ажиллагааг сайтар дэмжих нь зүйтэй бөгөөд үүнд, уламжлалт эдийн засгийн үйл ажиллагаа болон орчин үед үүсч байгаа гар урлал ба угсаатны аялал жуулчлал багтана.

Тусгай шаардлага

29. Нутгийн уугуул иргэд, ялангуяа төслийн доор дурдсан нөхцөл байдалд эмзэг байж мэдэх тул дээр дурдсан ерөнхий шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангавал зохино. Зээлдэгч,
- нутгийн уугуул иргэдтэй сайн санааны хэлэлцээ хийх,
 - нутгийн уугуул иргэдийг мэдээллээр ханган оролцуулах,
 - доор заасан (§30-35р зүйлд) үйл ажиллагааг эхлэхийн өмнө нутгийн уугуул иргэдтэй чөлөөтэй, урьдчилан мэдээллээр хангах замаар зөвлөлдөн зөвшөөрөл⁹² авах зэрэг ерөнхий шаардлагуудыг хангасан байна.

⁹² Ийм зөвшөөрлийг нийтээр хүлээн зөвшөөрөх хэмжээнд тодорхойлсон зүйл байхгүй. Гэхдээ энэ ГШ-д энэхүү ойлголтын дор нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэд өөрсдийн уламжлал, зан заншлын дагуу хоорондоо зөвлөлдөн холбогдох шийдвэрт хүрч буй үйл явцыг ойлгоно.

Дараах аль нэг нөхцөл байдлын үед зээлдэгч нь §30-35-р зүйлд дурдсан үйл ажиллагааг явуулах, баримтжуулахад туслуулахаар мэргэшсэн, бие даасан нийгмийн мэргэжилтнүүдийг авч ажиллуулна.

Одоогоор ашиглаж буй уламжлагдан ирсэн газар нутагт үзүүлэх нөлөөлөл

30. Нутгийн уугуул иргэд ихэнх тохиолдолд өөрсдийн амьдарч буй эрт үеэс уламжлагдан ирсэн газар нутгийн ой мод, ус, зэрлэг амьтад болон бусад байгалийн нөөц баялагтай нягт холбоотой байдаг бөгөөд хэрэв төслөөс энэхүү амьдарлын хэв маягт нь нөлөөлөхөөр бол энэ асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагатай. Хэдийгээр тухайн улс орны хууль, тогтоомжийн дагуу ийм газар нутгийг хуулийн дагуу нутгийн уугуул иргэд эзэмшиж, өмчлөх эрхгүй байдаг ч энэ газрыг нутгийн уугуул иргэд аж амьдралаа залгуулах зорилгоор улирлын чанартайгаар, мөн тэдний нэгдмэл шинж, зан заншлын онцлогийг илэрхийлэх соёл, ёслол, сүсэг бишрэлийн зорилгоор ашигладаг ба энэ нь ихэвчлэн олон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл ямар нэг байдлаар баталгаажсан байдаг.

31. Хэрэв зээлдэгч нь өөрийн төслийг уламжлагдан ирсэн газар нутагт хэрэгжүүлэхээр сонгох юм уу, тухайн газрын байгалийн нөөцийг арилжааны зорилгоор ашиглах тохиолдолд нутгийн уугуул иргэдийн аж амьдрал болон тэдний нэгдмэл шинж чанар, онцлогийг илэрхийлдэг соёл, ёслол, сүсэг бишрэлийн уламжлалд төслийн ажиллагаа сөргөөр нөлөөлж⁹³ болзошгүй тул зээлдэгч дараах арга хэмжээг авах замаар дээрх эрхийг хүндэтгэнэ. Үүнд:

- зээлдэгч нутгийн уугуул иргэдийн нөлөөлөлд өртсөн олон нийттэй итгэлцэл, сайн санааны хэлэлцээ хийж тэдэнтэй чөлөөтэй, урьдчилан мэдээллээр ханган зөвлөлдсөн болохоо хэлэлцээний үр дүн болгон баталгаажуулах,
- зээлдэгч нутгийн уугуул иргэдийн ашиглаж эсвэл эзэмшиж буй газарт төслийн үйл ажиллагаа явуулахаас зайлсхийх, эсвэл өөрсдийн үйл ажиллагаа явуулах талбайн хэмжээг аль болохоор багасгах талаар авсан арга хэмжээг баримтжуулах,
- нутгийн уугуул иргэдийн ашиглаж буй газрыг холбогдох мэргэжилтнүүд болон нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдтэй хамтран тодорхойлж баримтжуулах, үүнд, бусад нутгийн уугуул иргэдийн газар ашиглах эрхийг үндэслэлтэйгээр тооцон үзэх,
- тухайн орны хууль, тогтоомжийн дагуу нутгийн уугуул иргэдэд тэдний газар ашиглах эрхийн талаар мэдээлэх, уламжлалт газар ашиглах эрхийг албажуулсан аливаа хууль, тогтоомж байгаа тохиолдолд энэ талаар мөн нутгийн уугуул иргэдэд мэдээлэх,
- нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийн газрыг арилжааны зорилгоор ашиглах тохиолдолд зээлдэгч нь тэдэнд хамгийн багадаа л гэхэд шударга нөхөн олговрыг уламжлал, зан заншилд нь тохируулан холбогдох хууль, журмын дагуу олгох ба төслөөс үүдэн бий болох хөгжлийн ашиг тусыг хүртэх боломжийг мөн олгоно. Цаашлаад, боломжтой тохиолдолд аль болох газраас ашиг тус хүртэж болох газарт түшиглэсэн нөхөн олговор, мөнгөн бус нөхөн олговрыг олгохыг илүүд үзэх,

⁹³ Сөрөг нөлөө нь төслийн ажиллагаанаас шалтгаалан хөрөнгө, баялгаа алдах, газар ашиглах боломжоо алдах, эсвэл уламжлалт хэв маягаараа үргэлжлүүлэн амьдрахад нь саад, хязгаар бий болох зэрэг нөлөөлөл орж болно.

- хууль, тогтоомжийн хүрээнд хориглоогүй тохиолдолд нутгийн уугуул иргэдийн зөвшөөрсний дагуу газар болон байгалийн нөөцийг хамтран өмчлөх эрхийг нөхөн олговор болгон олгох,
 - зээлдэгч нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдийн нийгмийн бүлгүүдэд дотроо тохиролцох хангалттай цаг хугацааг зээлдэгчээс өөрийн санааг шууд эсвэл шууд бус тулгалгүйгээр гарган өгөх,
 - зээлдэгч нь гомдол барагдуулагч (омбудсмен) ба/эсвэл холбогдох төрийн байгууллагын тогтолцооны хүрээнд ажилладаг ижил төстэй засаг захиргааны байгууллагын дэмжлэгтэйгээр төслийн үйл ажиллагааг явуулах, эсвэл төслийн зорилгоор тухайн газрыг ашиглах зөвшөөрлийг олон нийтээс авах,
 - нутгийн уугуул иргэдийг байгалийн нөөцийг үргэлжлүүлэн ашиглах боломжоор хангах, эсвэл энэхүү байгалийн нөөцийг орлуулан бий болгох, ийм боломжгүй тохиолдолд шийдвэрлэх эцсийн хувилбар болгон энэхүү байгалийн нөөцийг ашиглах эрхээ алдсаны нөхөн олговрыг олгох,
 - нутгийн уугуул иргэдийн уламжлал, амьжиргааны нэг хэсэг болсон байгалийн нөөцийг төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй тохиолдолд бий болох ашиг тусыг тэгш, шударгаар хуваах нөхцлийг хангах,
 - нутгийн уугуул иргэдийг төслийн зорилгоор ашиглаж буй газрыг ашиглах, дайран өнгөрөх боломжоор хангах, энэ тохиолдолд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын асуудлыг анхааран үзэх асуудлууд багтана.
32. Төслийн хэрэгжилтийн явцад нутгийн уугуул иргэд болон зээлдэгчийн хооронд үүссэн, төслийн санал гомдлын механизмаар орсон хэдий ч шийдвэрлэгдээгүй аливаа зөрчлийг зээлдэгч ЕСБХБ-ны анхааралд нэн даруй хүргэнэ. Зээлдэгч нь нөхцөл байдлыг үнэлж, асуудлыг шийдвэрлэх зохистой арга хэмжээг тодорхойлно.

Уугуул иргэдийг уламжлан ашиглаж ирсэн газар нутгаас нь нүүлгэн шилжүүлэх

33. Зээлдэгч нутгийн уугуул иргэдийг тэдний хамтаараа уламжлан ашиглаж ирсэн газар нутгаас нь нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнээс зайлсхийх боломжит хувилбаруудыг авч үзнэ. Нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх боломжгүй бол зээлдэгч нь итгэлцэл, сайн санааны хэлэлцээний үр дүнд буюу нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдтэй чөлөөтэй, урьдчилан мэдээллээр ханган зөвлөлдсөний үндсэнд тэднээс зөвшөөрөл авахаас өмнө аливаа нүүлгэн шилжүүлэлт явуулахгүй байх нь зүйтэй. Энэ төрлийн зөвшилцөл нь нутгийн уугуул иргэдийн хууль, уламжлал, ёс заншил, уламжлалт байдлаар газар ашиглах эрхийг анхааран үзэж иргэдийн оролцоог бүрэн хангана. Нутгийн уугуул иргэдийг нүүлгэн шилжүүлэх аливаа арга хэмжээг нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөө болон ГШ 5-т заасан шаардлагатай нийцүүлэн явуулна. Нутгийн уугуул иргэдийн уламжлан өмчилж, ашиглаж ирсэн газар нь тэдний зөвшөөрөлгүйгээр (чөлөөтэй, урьдчилан мэдээлэн зөвлөлдөх байдлаар авсан зөвшөөрөл) төслийн үйл ажиллагааны улмаас хураагдсан, чөлөөлөгдсөн, эзлэгдсэн, ашиглагдаж буй, эсвэл эвдэрч гэмтсэн тохиолдолд нутгийн уугуул иргэд эдгээр нутаг дэвсгэр, байгалийн нөөцөө алдсаны төлөө шударга, тэнш нөхөн олговор авбал зохино.
34. Боломжтой тохиолдолд нутгийн уугуул иргэдийн өмнө нь амьдарч байсан газрыг нөхөн сэргээж дахин амьдрах бололцоо бий болсон үед шилжин нүүсэн иргэд тухайн газарт эргэн очих боломжтой байвал зохино.

Соёлын өв

35. Хэрэв төсөл нь нутгийн уугуул иргэдийн соёлын баялаг, мэдлэг, шинэ санаачилга эсвэл туршлагыг арилжааны зорилгоор ашиглах тохиолдолд зээлдэгч нь нутгийн уугуул иргэдэд (i) тухайн улсын хууль болон олон улсын хуулиар олгогдсон тэдний эрх, (ii) санал болгосон арилжааны үйл ажиллагааны цар хүрээ ба шинж чанар, (iii) энэхүү үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй үр дагаврын тухай мэдээлнэ. Хэрэв дараах нөхцлийг хангаагүй тохиолдолд зээлдэгчийг дээрх арилжааны үйл ажиллагааг эхлүүлэхийг хориглоно. Үүнд, (i) нутгийн уугуул иргэдийн нөлөөлөлд өртсөн олон нийттэй итгэлцлийн хэлэлцээ хийх, (ii) үйл ажиллагаа явуулахдаа нутгийн уугуул иргэдтэй чөлөөтэй, урьдчилан мэдээллээр ханган зөвлөлдсөн болохыг баримтжуулсан байх, (iii) тэдний ёс заншил ба уламжлалтай холбоотой мэдлэг, шинэ санаачилга буюу туршлагыг ашиг орлого олох үйл ажиллагаанд ашигласнаар олох ашиг тусыг шударга, тэнцүү хуваах явдлыг хангах асуудлууд орно.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 8

Соёлын өв

Танилцуулга

1. Энэхүү Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) нь одоо болон ирээдүй үедээ соёлын өвийг хадгалан үлдээхийн ач холбогдолыг чухалчлан авч үзсэн болно. ГШ-ын зорилго нь соёлийн өвийг хамгаалах, мөн зээлдэгчдийн бизнесийн үйл ажиллагааны явцад соёлын өвд сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийх, багасгах арга хэмжээг чиглүүлэх явдал юм. Зээлдэгч нь соёлын өвийн менежмент, тогтвортой ашиглалтыг хангаж ажиллахдаа хянамгай хандах ёстой.
2. Соёлын биет болон биет бус өв нь нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал өв хөрөнгө бөгөөд соёлын онцлог, уламжлалыг (үүнд, уламжлалт зан заншил, мэдлэг, итгэл үнэмшил, нутгийн аялга, хэл яриа зэргийг оруулж болно) таслалгүй үргэлжлүүлэн авч явахад чухал үүргийг гүйцэтгэдэг.
3. Соёлын өвийг хадгалах, хамгаалах дээрх зорилгыг биелүүлэхдээ энэхүү ГШ нь холбогдох олон улсын конвенци, бусад баримт бичгийг мөрдлөг болгоно. Түүнчлэн, төслийн нөлөөллийн бүс нутагт соёлын өвд хамаатай хууль, журмыг бүх тал дагаж мөрдөх хэрэгтэй бөгөөд тухайн улс орны олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийг даган биелүүлнэ. Үүнд, соёлын өвийн болон эртний эд зүйлсийн тухай хууль, холбогдох төлөвлөлт буюу зөвшилцлийн тухай хууль, байгаль хамгаалах болон тусгай хамгаалалттай газрын тухай хууль, мөн түүх, соёлын барилга байгууламжийн талаарх бусад хууль, журам, нутгийн уугуул иргэдийн соёлыг хамгаалахтай холбоотой хуулиуд орно. Нутгийн уугуул иргэдийг хамгаалах тухай дэлгэрэнгүй шаардлагуудыг ГШ 7-д тусгав.

Зорилго

4. Энэхүү ГШ-ын зорилго нь:
 - соёлын өвийг хамгаалах, хадгалах ажлыг дэмжих,
 - төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс соёлын өвийг хамгаалахдаа нөлөөллийг шат дараатай бууруулах арга замыг ашиглах,
 - бизнесийн үйл ажиллагаанд соёлын өвийг ашигласнаас олох үр ашгийг тэнцүү хуваах явдлыг дэмжих,
 - хэрэв боломжтой бол, соёлын өвийн тухай ойлголт, үнэлэмж бахархлыг түгээн дэлгэрүүлэх асуудлууд болно.

Үйлчлэх цар хүрээ

5. Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн үнэлгээ гүйцэтгэх явцад энэхүү ГШ-ын дагаж мөрдвөл зохих холбогдох шаардлагуудыг тодорхойлох ба, мөн зээлдэгчийн БОНМС болон төслийн БОНМТ-ний хүрээнд эдгээр шаардлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгана. Байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон менежментийн шаардлагуудын талаар ГШ 1-д тусгасан болно. Мөн түүнчлэн зээлдэгч соёлын өвд (биет болон биет бус) төслөөс үүдэлтэй нөлөөлөл үзүүлж болзошгүй талаар өмнө нь тодорхойлоогүй байсныг шинээр тогтоосон тохиолдолд энэхүү ГШ-ыг ашиглана.

6. Энэхүү ГШ-д соёлын өвийг уламжлал, мэдлэг, итгэл үнэмшил, үнэт зүйл зэрэг өвийн хөгжлийн тусгал, илэрхийлэл ба хүмүүсийн тодорхойлсноор өмчлөл хамаарахгүйгээр өнгөрсөн үеэс өвлөсөн баялгийн бүрдэл хэмээн тодорхойлов. Соёлын өв нь биет (материаллаг) болон биет бус соёлын өвөөс бүрдэх ба орон нутаг, бүс, үндэсний түвшинд эсвэл олон улсын хамтын нийгэмлэгийн хүрээнд танигдсан байна.
- Биет соёлын өвд археологи, палеонтологи, түүх, архитектур, шашин, гоо зүй болон соёлын бусад үнэ цэнэ бүхий байгалийн өвөрмөц тогтоцууд, соёлын болон дархан цаазат газрууд, дурсгалт газрууд болох хөдлөх болон үл хөдлөх объектууд орно хэмээн тодорхойлсон байдаг.
 - Биет бус соёлын өвд нэг үе удмаас дараах үе удамд шилжин ирдэг, нутгийн иргэд, зарим тохиолдолд хувь хүмүүс өөрсдийн ёс заншил соёлын нэг хэсэг хэмээн үздэг туршлага, төлөөлөл, илэрхийлэл, мэдлэг, үр чадвар зэрэг өвийг оруулан ойлгоно.
7. Төслийг хэрэгжүүлэх явцад соёлын өвийн үнэ цэнэ эсвэл ач холбогдлыг илэрхийлсэн газар нутаг, эд зүйлс тохиолдлоор илэрч болзошгүй бөгөөд төслийн зүгээс дараах тохиолдлуудад энэхүү ГШ-ын биелүүлнэ. Үүнд,
- том талбайг хамарсан газар хөндөлт, барилга байгууламж буулгах, газар ухах, үер зэрэг газрын гадаргууд өөрчлөлт оруулах ажиллагаа багтаж байвал,
 - үйл ажиллагаа явуулж байгаа улс орны хүлээн зөвшөөрсөн соёлын өвийн талбай дотор, эсвэл ойролцоо байрлаж байгаа бол,
 - нутгийн уугуул иргэдийн биет бус соёлын өвд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тохиолдлууд тус тус орно.

Шаардлага

Үнэлгээний үйл явц

Соёлын өвд учирч болзошгүй нөлөөллийг үнэлэх

8. Байгаль орчин, нийгмийн үнэлгээний эхний үе шатанд зээлдэгч аливаа соёлын өв төслийн нөлөөлөлд өртөж болзошгүйг олж тогтоовол тохиолдлын олдвор тааралдах боломжийг үнэлнэ. Үнэлгээг гүйцэтгэхдээ зээлдэгч холбогдох яамд, эксперт болон орон нутгийн олон нийттэй уулзаж, зөвлөлдөнө. Соёлын үнэт зүйлсийн судалгаа нь төслөөс үүдэлтэй асуудлууд, үзүүлж болзошгүй нөлөөллийн мөн чанар болон талуудын санаа зовоосон асуудал зэргийг тусгасан байна.

Нөлөөллөөс зайлсхийх

9. Зээлдэгч үнэлгээний үр дүнд тулгуурлан соёлын өвд ноцтой хохирол учруулахгүй байхаар төслийг боловсруулж, мөн нөлөөлөл үзүүлэхээргүй газар нутагт төслийг хэрэгжүүлэхээр сонгоно. Хэрэв төслийг төлөвлөх эхний үе шатанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлсон бол, төслийн төлөвлөлт болон хэрэгжилтийн шатанд сөрөг нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээг илүүтэйгээр хэрэгжүүлнэ.

Зайлсхийх боломжгүй нөлөөллийг үнэлэх

10. Нөлөөллөөс зайлсхийх боломжгүй тохиолдолд зээлдэгч нь урьдчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн үүсэж болзошгүй нөлөөллийг судалгаа хийх, талуудтай зөвлөлдөх замаар тодорхойлох ба шаардлагатай гэж үзвэл зураг төсөлд холбогдох өөрчлөлтүүдийг оруулж болно. Энэ судалгаа, зөвлөлдөх арга хэмжээний цар хүрээг соёлын өвийн асуудал хариуцсан төрийн болон орон нутгийн байгууллагуудтай хамтран төслийн тохиолдол тус бүрийн хувьд тодорхойлно. Судалгааг мэргэжлийн, туршлагатай соёлын өвийн мэргэжилтнүүдийг хамруулан байгаль орчин, нийгмийн үнэлгээний нэг хэсэг болгон, эсвэл тусад нь гүйцэтгэнэ.
11. Соёлын өвд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ, нөлөөллийг бууруулах арга хэмжээг тухайн улс орны болон/эсвэл орон нутгийн хууль, журам болон тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө, олон улсын хууль ба олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн сайн туршлагын дагуу явуулна.

Соёлын өвд учрах нөлөөллийн менежмент

12. Зээлдэгч соёлын өвд учирч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах арга хэмжээг боловсруулах шаардлагатай. Бууруулах арга хэмжээ нь хээрийн судалгааны үр дүн, соёлын өвийн ач холбогдлын талаарх мэргэжилтнүүдийн үнэлгээ, тухайн улс орны хууль тогтоомж болон холбогдох олон улсын конвенциудын шаардлага, мөн нөлөөлөлд өртсөн олон нийттэй хийсэн зөвлөлдөөн болон бусад талуудын оролцооны үр дүнд суурилсан байна. Эдгээр арга хэмжээг төслийн БОНМС, төсөлд зориулан боловсруулсан БОНМТ, эсвэл арга хэмжээ бүрийг хэрэгжүүлэх хугацааа, нөөц хөрөнгийг тусгасан соёлын өвийн менежментийн төлөвлөгөөнд тусад нь тусгана. Зээлдэгч нь нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлтийг хянахад бэлтгэгдсэн, мэргэшсэн ажилтнууд, эсвэл гуравдагч этгээд буюу төсөл дээр ажиллаж байгаа аливаа гэрээт гүйцэтгэгчид энэ талаар шаардагдах үр чадвар, туршлагыг хуримтлуулсан эсэхийг шалгаж, тэдний менежмент ба мониторингийг ГШ 1-ын дагуу хянана.
13. Хэрэв төслийн талбай соёлын өвд нөлөөлөл үзүүлж буй, эсвэл урьд өмнө нь олон нийт нэвтрэх боломжтой байсан соёлын өв бүхий талбайд одоо нэвтрэх боломжийг нь хязгаарлаж байгаа тохиолдолд зээлдэгч нь тухайн талбайг нөлөөлөлд өртсөн олон нийт ашигласнаас үүсэж болзошгүй нөлөөллийн үнэлгээг гүйцэтгэнэ. Хэрэв тухайн өв газрыг өн удаан жилд соёлын зорилгоор ашиглаж ирсэн байвал, зээлдэгч зөвшилцсөний үндсэн дээр тухайн өв газрыг олон нийт үргэлжүүлэн ашиглахыг зөвшөөрөх ёстой, эсвэл эрүүл мэнд, аюулгүй байдлыг бодолцон өөр замаар хүрч очих боломжоор хангах ёстой.

Тохиолдлын олдворын журам

14. Зээлдэгч нь төслийг хэрэгжүүлэх явцад биет соёлын өв болох тохиолдлын олдвор санаандгүй олдсон үед авах арга хэмжээг чиглүүлэх дүрэм, журмыг боловсруулж үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна. Тус журманд олдсон эд зүйлс, талбайн талаар холбогдох эрх бүхий байгууллагуудад мэдээлэх, төслийн ажилтнуудад энэ төрлийн санаандгүй олдвор олдох боломжийн талаар мэдээлэх болон тухайн эд зүйлс, газрыг эвдрэл, сүйдлээс сэргийлэх арга

хэмжээг тусгана. Зээлдэгч мэргэжлийн мэргэжилтэнгээр үнэлгээг хийлгэж, тухайн орны хууль, тогтоомж болон энэ ГШ-тай нийцэх арга хэмжээг тодорхойлтол аливаа тохиолдлын олдворыг эвдэж сүйтгэхгүй хадгална.

Нөлөөлөлд өртсөн олон нийт болон бусад талуудтай зөвлөлдөх

15. Хэрэв төслөөс соёлын өвд нөлөөлөл үзүүлж болзошгүй тохиолдолд зээлдэгч нь өн удаан жил уламжлал, зан заншлынхаа хүрээнд соёлын өвийг ашиглаж ирсэн тухайн газар нутгийн нөлөөлөлд өртсөн олон нийттэй зөвлөлдөж тухайн соёлын өвийн ач холбогдлыг тодорхойлох ба, мөн олон нийтийн санаа бодлыг өөрсдийн шийдвэр гаргах үйл явцад тусгана. Зээлдэгч нь нөлөөлөлд өртсөн олон нийтэд төслийн цар хүрээ, байршил, хугацаа болон төслөөс соёлын өвд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаарх мэдээллийг ил тод, зохих хэл дээр хүргэнэ. Энэ талаарх зөлдөлдөх үйл ажиллагааг ГШ 10-ын дагуу явуулах ба төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн тухай зөвлөлдөх өргөн хүрээний хэлэлцүүлгийн нэг хэсэг болгон явуулж болно. Түүнчлэн зөвлөлдөх арга хэмжээнд соёлын өвийг хамгаалах үүрэг бүхий тухайн орны холбогдох төрийн, төрийн бус болон иргэний нийгмийн байгууллагууд, эсвэл орон нутгийн эрх бүхий байгууллагуудыг оролцуулна. Соёлын өвд учирч болох сөрөг нөлөөллийг нөлөөлөлд өртсөн олон нийтэд урьдчилан мэдээлэх замаар тэднийг оролцуулан, зохих ёсоор бууруулна.

Соёлын өвийг төслийн үйл ажиллагаанд ашиглах асуудлууд

16. Хэрэв төсөл нь уламжлалт амьдралын хэв маягийг агуулж байгаа нутгийн иргэдийн соёлын баялаг, мэдлэг, шинэ санаачилга эсвэл туршлагыг арилжааны зорилгоор ашиглах тохиолдолд зээлдэгч нь нутгийн иргэдэд (i) тухайн улсын хууль, тогтоомжоор олгогдсон тэдний эрх, (ii) санал болгосон арилжааны үйл ажиллагааны цар хүрээ, шинж чанар, (iii) тухайн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй үр дагаврын тухай мэдээлнэ. Зээлдэгч нь дээрх арилжааны үйл ажиллагааг дараах нөхцлүүдийг хангасан тохиолдолд л явуулна. Үүнд, (i) тухайн уламжлалыг авч явж буй нөлөөлөлд өртсөн нутгийн олон нийттэй сайн итгэлцлийн зөвшилцөл байгуулах, (ii) тэдний оролцоог хангаж буй талаар болон зөвшилцлийн үр дүнг баримтжуулсан байх, (iii) тэдний ёс заншил ба уламжлалтай нийцсэн байдлаар мэдлэг, шинэ санаачилга эсвэл туршлагыг нь арилжааны үйл ажиллагаандаа ашиглаж олсон ашиг тусыг шударга, тэнцүү хуваах асуудлууд орно. Хэрэв төсөл нь нутгийн уугуул иргэдийн соёлын баялаг, мэдлэг, шинэ санаа эсвэл туршлагыг ашиглах тохиолдолд ГШ 7-д заасан шаардлагуудыг хангасан байна.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 9

Санхүүгийн зуучлагчид

Танилцуулга

1. Энэхүү ГШ-д Санхүүгийн зуучлагчид (СЗ) нь тогтвортой санхүүгийн зах зээлийг хөхиүлэн дэмжих гол хэрэгсэл бөгөөд бичил болон жижиг, дунд үйлдвэрлэлийн (ЖДҮ) салбарт санхүүжилт олгох механизм болохыг онцлон тэмдэглэлээ. Ийм СЗ дотор янз бүрийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид, тухайлбал хувийн үнэт цаасны сан, банк, түрээслэгч компани болон тэтгэврийн сангууд ордог. СЗ нь бичил санхүү, ЖДҮ-д зээл олгох, худалдааны санхүүжилт, дунд ба урт хугацааны корпоратив, эсвэл төслийн санхүүжилт болон орон сууцны санхүүжилт зэрэг өргөн хүрээний ажиллагаанд оролцдог.
2. Зуучлалын санхүүжилтийн хувьд байгаль орчин, нийгмийн үнэлгээ, эрсдэлийн менежмент, мониторинг, төслийн менежментийн хариуцлагыг СЗ-д төлөөлүүлэн үүрүүлдэг. Санхүүжилтийн ямар хэлбэрийг ашигласан зэрэг хэд хэдэн хүчин зүйлсээс хамааран тухайн төлөөлж буй үүрэг, хариуцлага нь өөр өөр байж болно. СЗ-дын явуулах байгаль орчин, нийгмийн менежментийн арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд төсөл хэрэгжих бүхий л хугацааны туршид тогтмол үнэлгээ өгч, мониторинг хийдэг байна.

Зорилго

3. Энэхүү ГШ-ын зорилго нь:
 - СЗ-ын бизнесийн ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийг явуулах боломжийг тэдэнд олгох ба тэдний зээлдэгчдийн дунд байгаль орчны болон нийгмийн бизнесийн сайн туршлагыг дэмжин дэлгэрүүлэх,
 - СЗ-дын зүгээс хөрөнгө оруулалт хийх явцдаа арилжааны санхүүгийн салбар дахь сайн туршлагын дагуу, энэхүү ГШ-д нийцсэн байгаль орчин, нийгмийн хувьд тогтвортой туршлагыг нэвтрүүлэх арга замыг тодорхойлох,
 - СЗ-дын хүрээнд байгаль орчны болон хүний нөөцийн сайн менежментийг хөхиүлэн дэмжих арга хэмжээ болно.

Үйлчлэх хүрээ

4. Энэхүү бодлогын баримт бичигт “төсөл” гэж ЕСБХБ-аас санхүүжилт авахыг хүссэн, эсвэл ЕСБХБ-аас санхүүжилт авахаар дэмжигдсэн, санхүүжилтийн гэрээнд тусгагдсан, Захирлуудын зөвлөл, эсвэл шийдвэр гаргагч бусад байгууллагаар зөвшөөрөгдсөн бизнесийн цогц үйл ажиллагааг хэлэх ба “дэд төсөл” гэж СЗ-дын зүгээс санхүүжүүлж байгаа төслийг хэлнэ.
5. Хэрэв төслийн хүрээнд маш тодорхой бизнес үйл ажиллагаа (зээл, эсвэл бусад зорилтот санхүүгийн хэрэгсэл зэрэг)-г санхүүжүүлж байгаа бол тус ГШ-ын тусгай шаардлагуудыг бүх дэд төслүүд дагаж мөрдөнө.
6. Хэрэв төслийн хүрээнд дэд төслийн тодорхой санхүүжилтэнд хамаарах эсэх нь мэдэгдэхгүй үндсэн хөрөнгө, меззанин санхүүжилт, эсвэл дараалсан санхүүжилт зэрэг компаний ерөнхий санхүүжилтийн асуудал яригдаж байгаа бол энэхүү ГШ-ийн шаардлагууд СЗ-дын ирээдүйн бүх л дэд төсөлд үйлчилнэ.

7. Хэрэв СЗ-ийн төсөл нь хэрэглээний зээл олгох, валют хоорондын солилцоо (своп) хийх зэрэг байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл хамгийн бага, эсвэл огт байхгүй төсөл хэрэгжүүлэх тохиолдолд СЗ нь байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, эрсдэлд менежмент явуулах аливаа арга хэмжээ авах шаардлагагүй.
8. СЗ-дын бизнесийн үйл ажиллагааны мөн чанар, хэрэгжүүлж буй төслүүд, ажиллагаа явуулж буй орны онцлогоос хамааран, байгаль орчин, нийгмийн нэмэлт шаардлагыг авч хэрэгжүүлэхийг СЗ-аас шаардаж болно.

СЗ-ийн байгууллагын чадавхи

9. СЗ нь ГШ 2 (Хөдөлмөр эрхлэлт ба ажлын нөхцөл) болон ГШ 4 (Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа)-д заасан ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны холбогдох шаардлагын дагуу хүний нөөцийн бодлого, менежментийн систем, туршлагыг мөрдлөгө болгож, өөрийн ажиллагсад мэдээлнэ. СЗ нь ажиллагсад, гэрээт ажилчдыг ажлын аюулгүй, эрүүл нөхцлөөр хангана.
10. СЗ нь байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, нийгмийн асуудлуудыг бүхэлд нь, түүний дотор энэхүү ГШ 2, 4 (дээр заасанчлан)-ын хэрэгжилтийг хариуцсан төлөөлөгчийг удирдах ажилтнууд дотроосоо томилно. Тус удирдах ажилтан нь (i) байгаль орчин, нийгмийн талаас тавигдсан шаардлагын өдөр тутмын хэрэгжилтийг хариуцсан, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх ажилтныг томилно, (ii) байгаль орчин, нийгмийн асуудлаар шаардлагатай байгаа сургалтуудыг тодорхойлох, уг сургалтанд шаардагдах төсвийг тодорхойлно, (iii) байгаль орчин, нийгмийн ихээхэн сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй дэд төслийн үнэлгээг гүйцэтгэх, удирдах зохих техникийн мэдлэг, туршлагатай, байгууллагын болон хөндлөнгийн мэргэжилтнүүдийг бэлэн байлгах асуудлыг хариуцна.

Шаардлага

11. СЗ нь өөрийн байгууллагын мөн чанар, бизнес үйл ажиллагаатай холбогдолтой байгаль орчин, нийгмийн эрсдлийн түвшин, төсөл болон дэд төслийн онцлогт нийцсэн байгаль орчин, нийгмийн бодлого болоод байгаль орчин, нийгмийн холбогдох журмууд⁹⁴ бүхий тодорхой байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС)-тэй байх шаардлагатай.
12. Хэрэв СЗ нь аливаа БОНМС ашигладаг бол тухайн БОНМС байгааг зохих баримтаар нотлон харуулах шаардлагатай.
13. Байгаль орчин, нийгмийн журмууд нь дараах шаардлагыг хангасан эрсдэлийн үнэлгээ, мониторингийн механизмыг агуулах ёстой. Үүнд:

⁹⁴ БОНМС болон холбогдох журмуудыг боловсруулан хэрэгжүүлэхэд нь СЗ-д туслах зорилгоор ЕСБХБ байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийн гарын авлага гаргасан бөгөөд уг гарын авлагад төрөл бүрийн СЗ, санхүүгийн үйлчилгээнд зориулсан удирдамжуудыг багтаасан болно. Өөрийн гэсэн холбогдох журмууд байхгүй СЗ нь тус гарын авлагын холбогдох хэсгийг дэд төслүүддээ зориулан ашиглах нь зүйтэй.

- бүх зээлдэгч/дэд төслүүд нь байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)-ын баримт бичгийн Хавсралт 1-д орсон Байгаль орчин, нийгмийн хориглосон үйл ажиллагааны жагсаалтад заасан ажиллагааг явуулж байгаа эсэхийг шалгах,
- санал болгосон дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг (бага/дунд/өндөр) СЗ-д зориулсан ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн эрсдлийн ангиллын жагсаалтын дагуу ангилах,
- үнэлгээ хийх замаар дэд төслүүд тухайн улс орны байгаль орчин, нийгмийн асуудлаарх хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулж буй эсэхийг тодорхойлох, нийцээгүй тохиолдолд нийцүүлэх арга хэмжээ авах нөхцөлийг хангах,
- санхүүжилт авч байгаа дэд төслүүд нь ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлогын Хавсралт 2-д заасан «А» ангиллын төслийн жагсаалтын шалгууруудыг хангасан байх. Эдгээр дэд төслүүд нь ГШ 1-8, 10-ын шаардлагыг хангасан байх ёстой,
- дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн асуудлуудын талаарх мэдээллийг тогтмол шинэчилж байх,
- дэд төслүүд байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тухайн улс орны хууль, тогтоомжийн шаардлагатай нийцсэн байх нөхцөлийг хангах шаардлага тус тус орно.

Талуудын оролцоо

14. СЗ нь байгаль орчин, нийгмийн асуудлаар олон нийттэй харилцах механизмтай байх шаардлагатай. Тухайлбал, байгаль орчин, нийгмийн асуудалтай холбоотой олон нийтийн санал хүсэлт, санаа зовоосон асуудлуудыг хүлээн авч зохицуулах, энэ ажлыг хариуцсан ажилтантай байна. СЗ нь тэдгээр санал хүсэлтэд тухай бүр, шаардлагатай хугацаанд нь хариу өгнө. СЗ нь байгаль орчин, нийгмийн асуудлаарх компаний бодлого, эсвэл өөрийн БОНМС-ийн тойм мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан (хэрэв байгаа бол) олон нийтэд танилцуулж байх нь зүйтэй. Мөн бололцоотой тохиолдолд санхүүжүүлж буй «А» ангиллын дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ)-г байршуулсан холбоосыг цахим хуудсандаа тавих хэрэгтэй.

ЕСБХБ-д тайлагнах

15. СЗ нь БОНМС, энэхүү ГШ 2, ГШ 4-ын ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлага, мөн дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн арга хэмжээний хэрэгжилтийн талаарх жил тутмын тайланг ЕСБХБ-нд хүргүүлнэ.

Сайн дурын санаачилга

16. Төслийн үйл ажиллагаанд багтах эсэхээс үл хамааран, СЗ өөрийн зээлийн ба хөрөнгө оруулалтын ажиллагаанд байгаль орчин, нийгмийн менежментийн олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэн ашиглах явдлыг хөхиүлэн дэмжинэ. СЗ нь:
 - БОНМС болон байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийн журмыг өөрийн бизнесийн бүхий л үйл ажиллагаа, түүний дотор энэхүү ГШ-д хамаарахгүй үйл ажиллагаанд ч мөн нэвтрүүлнэ,

- байгаль орчин, нийгмийн өндөр үр ашигтай (жишээ нь эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүч, биологийн олон янз байдалд тааламжтай бизнес, бизнес эмэгтэйчүүдэд зориулсан, бичил бизнес эрхлэгчдэд зориулсан зээл г.м.) санхүүгийн бүтээгдэхүүнийг бий болгох боломжийг тодорхойлох арга хэмжээг хөхиүлэн дэмжинэ.

СЗ нь Эквадорын зарчмууд, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Санхүүгийн санаачилга ба хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмууд зэрэг санхүүгийн салбарт шилдэг туршлагыг дэмждэг зохих олон улсын санаачилгуудад нэгдэх асуудлыг авч үзэх хэрэгтэй.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 10

Мэдээллийг ил тод болгох, талуудын оролцоо

Танилцуулга

1. Энэхүү Гүйцэтгэлийн шаардлага (ГШ)-д зээлдэгч, зээлдэгч байгууллагын ажиллагсад, төслийн нөлөөлөлд шууд өртсөн орон нутгийн олон нийтийн оролцоог нээлттэй, ил тод байдлаар хангах нь чухал ач холбогдолтой болохыг онцлохын зэрэгцээ, шаардлагатай тохиолдолд олон улсын сайн туршлага, компаний нийгмийн хариуцлагын хүрээнд бусад талуудын оролцоог мөн хангах нь чухал хэмээн үзэж байна.⁹⁵ Талуудыг оролцоог хангаснаар тухайн төслийн байгаль орчин, нийгмийн тогтвортой байдал сайжирдаг. Ялангуяа, төслийн цар хүрээ, мөн чанарт тохирсон үр дүнтэй олон нийтийн оролцоо нь төслийн байгаль орчин, нийгэм, санхүүгийн арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг сайжруулан, тогтвортой түвшинд дэмжих ба олон нийтийн хүртэх үр ашгийг нэмэгдүүлнэ. Төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлуудыг үр дүнтэйгээр удирдан зохион байгуулахад талуудын оролцоо нь ихэд чухал бөгөөд олон нийттэй үр бүтээлтэй, хариуцлагатай, сайн харилцааг бий болгоход мөн голлох үүргийг гүйцэтгэдэг. Үр дүнд хүрэх үүднээс талуудын оролцоог тухайн төслийн эхний шатнаас л хангаж эхлэх нь зүйтэй.
2. Энэхүү ГШ-д талуудыг оролцуулах олон улсын сайн туршлагад үндэслэсэн арга хэмжээ, үйл явцыг багтаасан ба эдгээр нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд байнга үргэлжилнэ. Үүнд, (i) холбогдох мэдээллийг нийтэд ил болгох, (ii) талуудтай нухацтай зөвлөлдөх, (iii) хүмүүст шүүмжлэл, санал гомдол гаргах боломжийг олгосон үр дүнтэй журам, бодлогыг боловсруулж ашиглах арга хэмжээ багтана. Энэ үйл ажиллагаа нь төслийн төлөвлөлтийн аль болох эхний үе шатанд эхэлж, төслийн бүхий л хугацаанд үргэлжлэх ёстой. Түүнчлэн, талуудын оролцоо нь төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлыг үнэлэх, зохицуулах, мониторинг хийх арга хэмжээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм. Иймээс энэ ГШ-ыг ГШ 1 болон ГШ 2-д тусгасан ажиллагсдыг татан оролцуулах тухай шаардлагуудтай уялдуулан ойлгож танилцвал зохино. Албадан нүүлгэн суурьшуулах, төслөөс үүдэн эдийн засгийн хохирол амсах, нутгийн уугуул иргэдэд нөлөөлөх, соёлын өвд сөрөг нөлөө үзүүлэх үр дагавартай төслийн хувьд ГШ 5, ГШ 7, ГШ 8-д тусгагдсан мэдээллийг ил тод болгох, зөвлөлдөх тусгай шаардлагуудыг зээлдэгч хэрэгжүүлэх ёстой.

Зорилго

3. Энэ ГШ-ын зорилго нь:
 - оролцогч талудтай, ялангуяа төслийн нөлөөлөлд шууд өртсөн олон нийттэй бүтээлч харилцаа тогтоож, урт хугацаанд хадгалахад зээлдэгчид дэмжлэг үзүүлэх талуудын оролцооны арга аргачлалыг тодорхойлох,
 - талуудыг төслийн үйл ажиллагаанд үр дүнтэй татан оролцуулах замаар зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн арга хэмжээний хэрэгжилтийг сайржуулах,

⁹⁵ Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргах, шударга ёсыг сахиулахад олон нийтийн оролцоог хангах тухай НҮБ-ын Европын Эдийн засгийн комисс (UNECE)-ийн конвенцид заасан олон нийтэд ил тод болгох, талуудын оролцоог хангах зарчмууд, зорилтууд нь энэхүү ГШ-ыг чиглүүлсэн болно.

- байгаль орчин, нийгмийн талаарх мэдээллийг төслийн оролцогч талуудад хүргэх нөхцлөөр хангах, мөн төслийг хэрэгжүүлэх хугацаанд нөлөөлөлд өртсөн олон нийтийн хангалттай оролцоог дэмжих,
- нөлөөлөлд өртсөн олон нийт болон бусад талуудын санал гомдолд хариу өгч зохих ёсоор шийдвэрлэж байгаа эсэхийг хянах асуулдууд болно.

Үйлчлэх цар хүрээ⁹⁶

4. Энэхүү ГШ нь байгаль орчин, ажиллагсад болон төслийн шууд нөлөөлөлд өртсөн орон нутгийн олон нийтэд байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл, асуудлууд учруулж болзошгүй бүхий л төслүүдэд хамаарна. Зээлдэгч нь ГШ 1-д заасны дагуу өөрийн БОНМС, төслийн байгаль орчин, нийгмийн үнэлгээ, БОНМТ-ий хүрээнд төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй талуудыг тодорхойлон тэдний оролцоог хангана.

Шаардлага

5. Зээлдэгч нь төслийн шууд нөлөөлөлд өртөж буй олон нийт болон бусад холбогдох талуудын оролцоог хангахдаа цаг тухай бүрт, тэдэнд хамааралтай мэдээлэл, асуудлыг ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэх ба оролцооны үйл явцад аливаа булхай, гадны оролцоо, албадлага, сүрдүүлэг гарахаас сэргийлэн талуудын соёл, уламжлалын хэлбэрт тохирсон байдлаар оролцооны арга хэмжээг зохион байгуулна.
6. Талуудын оролцоо дараах хэлбэрүүдээр тодорхойлогдох ба үүнд, оролцогч талуудыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, талуудын оролцоог төлөвлөх, мэдээлэх, зөвшилцөх ба оролцоог хангах, гомдол гаргах үйл явцуудыг ил тод болгох, мөн холбогдох талуудад тайлагнах асуудлууд орно.
7. Талуудын оролцооны давтамж, утга агуулга нь төслийн мөн чанар, цар хүрээ болон орон нутгийн олон нийтэд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл, байгаль орчны эмзэг байдал, олон нийтийн ашиг сонирхол зэрэгтэй уялдсан байна. Талуудын оролцоог зээлдэгч болон төслийн онцлогт тохируулан явуулах үүднээс зээлдэгч нь талуудыг доор дурдсан байдлаар тодорхойлох нь зүйтэй юм. Олон нийтэд мэдээлэл хүргэх, хэлэлцүүлэг явуулах талаарх тухайн улс орны хууль, тогтоомж болоод олон улсын шаардлагын дагуу тухайн орны дагаж мөрдөхөөр заасан дүрэм, журмыг төслийн зүгээс хэрэгжүүлнэ.
8. Зээлдэгч нь талуудын оролцооны талаарх үүрэг хариуцлага, эрх мэдлийг нарийвчлан тодорхойлж зааж өгөх ба түүнчлэн, талуудыг татан оролцуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэгтэй боловсон хүчнийг томилсон байна.

Төслийг боловсруулах үе шатанд талуудыг оролцуулах асуудлууд

Оролцогч талуудыг тодорхойлох

9. Зээлдэгч нь хувь хүн эсвэл олон нийтий бүлгийг (i) төслийн нөлөөлөлд өртсөн, эсвэл өртөж болзошгүй (шууд болон шууд бусаар), (ii) төсөлд (бусад сонирхогч

⁹⁶ Үүнээс гадна, онцгой байдалд бэлэн байх, хариу үзүүлэхтэй холбоотой тусгай заалтуудыг ГШ 4-д тусгав.

талуулын асуудалд) сонирхолтой байж мэдэх талууд зэргээр тодорхойлж, баримтжуулна.

10. Зээлдэгч нь төсөлд хамааралтай хувь хүн, олон нийтийн бүлгүүдийг тодорхойлохдоо ГШ 1, 5, 7-д заасанчлан эдгээр хүмүүсийн сул тал, эмзэг байдлаас шалтгаалж төслийн үйл ажиллагаанд ялгаатай байдлаар өртөх асуудлыг хөндөж болно. Ингэснээр эдгээр хүмүүс болон бусад талуудын оролцоо хангагдаж байгаа эсэх, олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох боломжгүй эсвэл оролцоог нь хангахад тодорхой арга хэмжээ болон/эсвэл нэмэлт туслалцаа шаардаж байгаа эсэхийг тодорхойлох шаардлагатай. Түүнчлэн, шаардлагатай тохиолдолд зээлдэгч нь дээрх талуудад бий болох янз бүрийн ашиг сонирхлыг тодорхойлно. Талуудын ашиг сонирхол нь тэдний насны ялгаа, хүйс, үндэс угсаа, соёлын олон янз байдал, төслийн нөлөөлөл, үүнийг бууруулах арга хэмжээ, төслөөс хүртэх ашиг тус зэргээс шалтгаалан өөр байж болох юм. Тиймээс талуудыг өөр өөр, эсвэл тусдаа хэлбэрээр оролцуулах шаардлага үүсэж болно. Түүнчлэн, зээлдэгч нь талууд нөлөөлөлд хэрхэн өртөж болох, үүсэж болзошгүй нөлөөлөл (бодит ба төсөөлж буй)-ийн цар хүрээг тодорхойлно. Үүсэж болзошгүй нөлөөллийн цар хүрээг талууд өөрсдийн төсөөллөөр үнэлэн ойлгож буй тохиолдолд нэмэлт мэдээлэл өгөх байдлаар талуудтай зөвлөлдөн нөлөөллийн түвшнийг үнэлж баталгаажуулна. Төслийн хувьд тохиромжтой талуудтай харилцах арга хандлагыг сонгох зорилгоор талуудыг тодорхойлох явцад тухайн оролцогч талуудын талаарх нарийвчилсан мэдээллийг цуглуулсан байвал зохино.

Талуудыг татан оролцуулах төлөвлөгөө

11. Байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй төслийн хувьд зээлдэгч төслийн мөн чанар, цар хүрээ, эрсдэл, нөлөөлөл, хэрэгжилтийн үе шатуудад нийцсэн талуудыг татан оролцуулах төлөвлөгөө (ТТОТ) боловсруулж хэрэгжүүлнэ. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагатай аливаа төслүүдийн хувьд §21-25-д заасан мэдээллийг ил болгох, зөвлөлдөх шаардлагыг ТТОТ-нд тусгасан байвал зохино. ТТОТ-г нөлөөлөлд өртсөн талуудын онцлог, ашиг сонирхлыг тооцон үзэж, мөн талуудыг оролцуулах, талуудтай зөвлөлдөх арга хэмжээний цар хүрээ, түвшин зэргийг харгалзан боловсруулна. ТТОТ-нд төслийг боловсруулах, хэрэгжүүлэх бүхий л хугацааны туршид холбогдох талуудтай хэрхэн харилцах, хамтран ажиллах талаар, мөн санал гомдлын барагдуулах (ГШ-ын дараагийн хэсэгт тайлбарласан) талаар тусгасан байна. Тус төлөвлөгөөг хэр нарийвчлан боловсруулах талаар тухайн төслийн онцлогоос хамааран шийдвэрлэнэ. Олон нийтэд мэдээлэл хүргэх, олон нийттэй зөвлөлдөхөд зориулсан нөөц, санхүүжилтийг нэн тэргүүнд нөлөөлөлд өртсөн талуудтай зөвлөлдөхөд зарцуулна.
12. Уг төлөвлөгөөнд олон нийтийн дунд байгаа янз бүрийн бүлэг хүмүүстэй хэрхэн зөвлөлдөх талаар тусгах ба мөн, талуудын оролцоонд тулгарч буй саад бэрхшээлийг арилгах арга хэмжээг тодорхойлон оруулна. Эдгээр арга хэмжээг талуудын хүйс, нас, бусад ялгаа, ашиг сонирхолд үндэслэн боловсруулан баримтжуулна. Шаардлагатай үед, ТТОТ-нд хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн хүмүүсийн үр дүнтэй оролцоог хангах тусгайлсан арга хэмжээг тусгаж болно. Эдгээр эмзэг бүлгийн талуудын оролцоог үр дүнтэйгээр хангахад тусгай арга аргачлал, нэмэлт нөөц, санхүүжилт шаардагдаж мөн болно. Талуудын

оролцоо нь тухайн олон нийтийг төлөөлж буй төлөөлөгчдөөс⁹⁷ ихээхэн хамаарч байгаа тохиолдолд, зээлдэгч нь тухайн төлөөлөгч холбогдох олон нийтийн санаа бодлыг бодитоор төлөөлж чадаж байгаа эсэх, цаашлаад тухайн төлөөлөгч зээлдэгч болон талуудын хооронд мэдээллийг зөвөөр дамжуулж байгаа эсэхийг хянаж ажиллана.

13. Хэрэв холбогдох эрх бүхий байгууллагууд талуудыг татан оролцуулах үүрэг, хариуцлагыг хүлээж байгаа тохиолдолд зээлдэгч нь энэхүү ГШ-д нийцсэн үр дүнд хүрэх зорилгоор тухайн хариуцсан төрийн байгууллагатай хамтран ажиллана. Орон нутгийн зохицуулалт болон энэхүү ГШ-ын хооронд зөрүүтэй зүйл байвал зээлдэгч нь орон нутгийн дүрэм, журмаар заагдаагүй нэмэлт шаардлагуудыг хангах зорилго бүхий талуудыг татан оролцуулах арга хэмжээг тодорхойлон, шаардлагатай тохиолдолд тэдгээрийг хэрэгжүүлнэ.
14. Тухайн төслийн байршил тодорхойгүй байгаа тохиолдолд зээлдэгчийн БОНМС-ийн хүрээнд талуудыг тодорхойлох, оролцуулах үйл явцыг төлөвлөх ерөнхий зарчим, стратегийг тусгасан ТТОТ-г энэхүү ГШ-ын дагуу тухайн нутаг дэвсгэрт тохирсон аргачлалаар боловсруулах ба төслийн байршил тодорхой болох үед нөлөөлөлд өртсөн талуудыг эцэслэн тодорхойлно.
15. Ерөнхий санхүүжилт, хөрөнгө, хувьцааны санхүүжилт Банкнаас хүссэн олон газар төсөл, үйл ажиллагаа явуулж буй зээлдэгч нь ТТОТ боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайн компаний ТТОТ нь зээлдэгчийн бизнес түүнээс учирч буй байгаль орчин, нийгмийн нөлөө, олон нийтийн сонирхлын түвшинтэй уялдсан байна. ТТОТ-г нийт байгууллага даяар цаг хугацаа алдалгүй түгээн хэрэгжүүлнэ. Барилга байгууламж тус бүрт талуудын оролцоог хангах зохих журам, нөөц, санхүүжилтийг хуваарилсан байх шаардлагатай ба тухайн байгууламжийн ойролцоо байгаа талууд нь холбогдох байгаль орчин, нийгмийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар мэдээлэл авсан байна.

Мэдээллийг ил тод болгох

16. Төсөлтэй холбоотой мэдээллийг ил тод болгосноор сонирхогч талуудад төслийн эрсдэл, нөлөөлөл, боломжуудын талаар ойлголт өгөхөд тус дэм болдог. Хэрэв нийгмийн бүлгүүд төслөөс үүдэн байгаль орчин, нийгмийн нөлөөлөлд өртөж болзошгүй бол зээлдэгч нь олон нийтийг дараах мэдээллээр хангана. Үүнд:
 - төслийн зорилго, мөн чанар, цар хүрээ болон төслийн үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа,
 - талуудад эрсдэлтэй, бодит нөлөөллүүд үүсэхээр бол тэдгээрийг бууруулах төлөвлөгөө,
 - төлөвлөсөн бол талуудыг татан оролцуулах аливаа үйл явц, олон нийтийг оролцуулах боломж, арга замууд,
 - төлөвлөж буй аливаа олон нийтийн хэлэлцүүлэг, уулзалт болох газар, цаг, уулзалтын тухай мэдэгдэх, нэгтгэх ба тайлагнах үйл явц,
 - санал гомдлыг барагдуулах үйл явц орно.
17. ТТОТ-нд тусгасны дагуу мэдээллийг тухайн орон нутгийн иргэдийн ярьдаг хэл дээр, ойлгоход хялбар, тэдний соёл, уламжлалд тохирсон зохих хэлбэрээр

⁹⁷ Жишээлбэл, олон нийт, шашны тэргүүнүүд, орон нутгийн засаг захиргааны төлөөлөгчид, иргэний нийгмийн төлөөлөл, улс төрчид, багш нар зэрэг нэг болон түүнээс дээш нөлөөлөлд өртсөн талуудын бүлэг.

түгээнэ. Түүнчлэн, өөрсдийн нийгмийн статус, мэдээллийн хэрэгцээ зэргээс шалтгаалан төслийн нөлөөлөлд ялгаатай байдлаар өртсөн нийгмийн бүлгүүдийн хэрэгцээ, шаардлагыг мөн тооцон үзвэл зохино.

Үр дүнтэй зөвшилцөл

18. Утга учиртай, үр дүнтэй зөвлөлдөөн нь хоёр талын үйл явц юм. Нөлөөлөлд өртсөн талуудтай зөвшилцөх үйл ажиллагааг ТТОТ-нд заасанчлан аливаа нийгмийн бүлэг хүмүүсийн үзэл бодол, байр суурь, тодорхой хэрэгцээг тэдний соёл, зан заншилд тохируулан тусгах байдлаар явуулах ба энэ талаар зээлдэгч нь ТТОТ-г хэрэгжүүлэх явцад ойлгосон байвал зохино. Мөн зөвшилцөх үйл явцад нөлөөлөлд өртсөн талуудаас гадна бусад сонирхогч талууд хэмээн тодорхойлогдсон аливаа хувь болон бүлэг хүмүүс оролцож болно. Зээлдэгч нь нөлөөлөлд өртсөн талуудын зөвлөлдөөн явуулахыг илүүд үзэж буй хэл, тэдний зүгээс шийдвэр гаргахад ашиглахыг хүсэж буй арга хэлбэр, эсвэл эмзэг бүлгүүдийн хэрэгцээ зэргийг талуудтай зөвлөлдөхдөө харгалзан үзвэл зохино. Зээлдэгч нь зөвшилцлийг гадны оролцоо, албадлага эсвэл айлган сүрдүүлэлтээс ангид байлгана.
19. Тодорхой зөвшилцлийн хэрэгцээ болон мөн чанар нь талуудын тодорхойлсон үндэслэл дээр тулгуурладаг ба нөлөөлөлд өртсөн нийгмийн бүлгүүдэд төслийн болзошгүй сөрөг нөлөөллийн шинж чанар, хамрах хүрээнээс хамаарна. Нөлөөлөлд өртсөн нийгмийн бүлгүүд нь төслийн ирээдүйд учрах тодорхой сөрөг нөлөөллийн тухай асуудлуудыг дэвшүүлж, зээлдэгч нь үр дүнтэй зөвшилцлийг зохион байгуулснаар төслийн эрсдэл, нөлөөлөл, бууруулах шатлалын талаар санал бодлоо илэрхийлэх боломжийг талуудад олгохоос гадна зээлдэгч нь асуудлуудад хариу арга хэмжээ авах боломжтой болдог. Аливаа асуудал, нөлөөлөл болон боломжийн мөн чанар нь өөрчилдөг тул үр дүнтэй зөвшилцлийг тогтмол явуулах нь зүйтэй. Зээлдэгч нь ийм үйл ажиллагаанд оролцож байгаа тохиолдолд уг оролцооны тухай хангалттай баримт бичгээр хангаж өгөх хэрэгтэй.
20. Зээлдэгч олон нийтийн зөвлөгөөнд оролцсон хүмүүст төслийн талаар гаргасан эцсийн шийдвэрийг цаг алдалгүй хүргэн, байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээ, орон нутгийн олон нийтэд төслөөс орох ашиг тус, шийдвэрийн үндэс болсон шалтгаан, санал гомдлын механизм эсвэл үйл явцын талаар мэдээнэ.

«А» ангиллын төслүүдийн ил тод байдал болон зөвшилцөл

21. «А» ангилалд орсон төслүүдийн⁹⁸ хувьд байгаль орчин болон/эсвэл нийгмийн томоохон нөлөөллүүдийг үзүүлж болзошгүй, цаашлаад эдгээр нөлөөллийг шууд тодорхойлох боломжгүй тохиолдолд зээлдэгч нь оролцоонд түшиглэсэн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ)-г гүйцэтгэх шаардлагатай. Тухайн төслөөс хамааран БОННУ-ний үе шат бүрт мэдээллийн ил тод байдал, оролцоог хангах арга хэмжээнүүдийг төлөвлөх нь зүйтэй. Талуудыг мэдээллээр ханган оролцуулах арга хэмжээнд зохион байгуулалтайгаар зөвлөлдөх, төлөвлөж буй нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төслөөс бий болох ашиг тусыг эрх тэгш байдлаар хуваах, төслийг

⁹⁸ «А» ангилалд орсон төслийн жагсаалтыг ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлогын баримт бичгийн Хавсралт 2-т оруулсан болно.

хэрэгжүүлэх зэрэг асуудлаар нөлөөлөлд өртсөн талуудын санал бодлыг зээлдэгчийн шийдвэр гаргах үйл явцад тусгах асуудлууд орно.

22. БОННУ-г гүйцэтгэж эхлэх үеэс зээлдэгч нь төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол асуудлуудыг оновчтой тодорхойлох зорилгоор сонирхсон болон холбогдох талуудыг үнэлгээний үйл явцад татан оролцуулна. Зөвлөлдөх арга хэмжээний үеэр талуудад талуудыг татан оролцуулах төлөвлөгөө болон бусад баримт бичигт санал, зөвлөмж өгөх боломжийг олгоно.
23. БОННУ хийгсэн төслийн хувьд байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах шаардлага үүссэн тохиолдолд зээлдэгч нь талуудыг татан оролцуулах төлөвлөгөөний хүрээнд энэхүү байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөг нөлөөлөлд өртсөн олон нийтэд танилцуулах ёстой.
24. Үүнээс гадна, зөвлөлдөх үйл ажиллагаа нь тухайн улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомж, бусад холбогдох хуулинд нийцсэн байх хэрэгтэй. Зээлдэгч нь БОННУ-ний мэдээллийг төслийн нийт хугацаанд олон нийтэд хүртээмжтэй байлгах ба мөн нэмэлт өөрчлөлт оруулж болно. Түүнчлэн, төслийг дуусахад архивлахаас гадна эдгээр мэдээлэлтэй танилцах хүсэлт олон нийтээс ирсэн үед мэдээллийг тухай бүрт гаргаж өгнө.
25. Зээлдэгч талуудыг татан оролцуулах уг төлөвлөгөөнд заасны дагуу өөрийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны талаар сонирхсон талуудад хэвэлмэлээр, эсвэл вэб сайтаар дамжуулан тогтмол тайлагнаж байх ёстой. Эдгээр тайлангууд нь сонирхогч талуудад хүртээмжтэй хэлбэрээр байх ба хэдэн удаа тайлагнах вэ гэдэг нь холбогдох талуудын үзэмжээр болох боловч жилд нэгээс илүүгүй удаа байна.

Төслийн хэрэгжилтэнд талуудыг татан оролцуулах, хөндлөнгийн талд тайлагнах асуудлууд

26. Төслийг хэрэгжүүлэх хугацаанд холбогдох оролцогч талуудыг зээлдэгч нь төслийн мөн чанар, холбогдох нийгэм, байгаль орчны нөлөө болон төсөлд үзүүлж буй олон нийтийн сонирхлын түвшиний талаарх тогтмол мэдээллээр хангана. Төслийн гол үе шатанд зарим нэмэлт мэдээллийг ил тод болгох хэрэгцээ гарч мэднэ. Жишээлбэл төслийг эхлүүлэх үе шат, эсвэл нөлөөлөлд өртсөн олон нийтийн санаа зовоосон аливаа тодорхой асуудлууд үүсэхэд мэдээллийг ил тод болгох, зөвлөлдөх үйл явц, эсвэл санал гомдлыг барагдуулах үйл явцын хүрээнд шийдвэрлэнэ.
27. Хэрэв төслийн үйл ажиллагаанд аливаа бодит өөрчлөлт орсноос нөлөөлөлд өртсөн нийгмийн бүлгүүдэд нэмэлт сөрөг нөлөөлөл ба санаа зовоосон асуудлууд үүсгэхээр байгаа тохиолдолд зээлдэгч нь эдгээр талуудад тухайн нөлөөлөл, асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг хүргэн, талуудыг татан оролцуулах төлөвлөгөөтэй нийцүүлэн шинэчилсэн БОНМТ-г олон нийтэд ил тод болгоно. Хэрэв нөлөөлөлд өртсөн талуудад учрах эдгээр нэмэлт сөрөг нөлөө нь томоохон үр дагавар үүсгэх тохиолдолд зээлдэгч нь §16-20 зүйлд заасны дагуу нэмэлт зөвлөлдөөнийг тухайн тохиолдол тус бүрт зохион байгуулах шаардлагыг хангах үүргийг хүлээж болно.

Санал гомдлын механизм

28. Зээлдэгч нь төсөлтэй холбоотой оролцогч талуудын санаа зовоосон асуудлуудыг ойлгож мэдэн, цаг тухайд нь хариу өгч байх шаардлагатай. Энэ зорилгоор зээлдэгч нь төслийн байгаль орчин, нийгмийн ажиллагааны талаарх оролцогч талуудын санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх механизм, үйл явцыг бий болгосон байна. Санал гомдлын механизмын хамрах хүрээг төслөөс үүдэн бий болж болзошгүй эрсдэл, нөлөөллийн цар хэмжээтэй уялдуулсан байна.

- Санал гомдлыг барагдуулах журам, механизм нь соёл, зан заншлын хувьд зохимжтой, нөлөөлөлд өртсөн бүхий л олон нийтэд ойлгоход хялбар, ил тод байх шаардлагатай ба олон нийтийн санаа зовоосон асуудлуудыг түргэн шуурхай, үр дүнтэй, мөн ямарваа нэг шийтгэл оногдуулахгүйгээр шийдвэрлэдэг байхаар зохион байгуулагдсан байх ёстой. Энэхүү гомдол барагдуулах журам, механизм нь олон нийтийг шүүх, засаг захиргаанд гомдлоо гаргах явдалд саад тотгор учруулах ёсгүй. Зээлдэгч нь олон нийтийг татан оролцуулах ажиллагааны явцад санал гомдлын механизмын тухай нөлөөлөлд өртсөн холбогдох олон нийтэд мэдээлэх бөгөөд түүний биелэлтийг олон нийтэд тогтмол тайлагнах ба хүмүүсийн хувийн нууцыг хамгаална.
- Санал гомдлыг соёл, зан заншлын хувьд зохистой, тохиромжтой хэлбэрээр барагдуулах нь зүйтэй бөгөөд талуудын хэрэгцээ, санал бодолд бодитой, шударга, хариуцлагатай хандах ёстой. Мөн энэхүү механизм нь дурын санал гомдлыг хэлэлцүүлэх боломжийг олгосон байна.